

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 2 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлт

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
04 дүгээр сарын 12-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 16 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Ганболд, Ц.Мөнх-Оргил;
Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хуулийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Тогтохсүрэн, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Д.Сарангэрэл, Ц.Мөнхцэцэг, Ж.Батсуурь, Ё.Баатарбилэг, Ш.Адьяаа, Т.Доржханд нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Д.Тогтохсүрэн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Хуулийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ж.Батсуурь, С.Одонтуяа, Т.Доржханд, М.Оюунчимэг нар үг хэлэв.

Н.Энхболд: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 2 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хуулийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Д.Тогтохсүрэн, Ш.Адьяа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат, Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, С.Амарсайхан, Т.Доржханд нар үг хэлэв.

Н.Энхболд: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Н.Энхболд: 1.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь дэх хэсэгт “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасны “... 41.1.3, ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	12
Бүгд:	12

0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасны “... 41.1.3, ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	11
Бүгд:	12

8.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 13 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 18 цаг 29 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 16 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Гишүүдийн ирц бүрдсэн байна. 2023 оны 4 сарын 12-ны өдрийн Байнгын хорооны Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан эхэлснийг мэдэгдье. Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэхээр бэлдэж байна. Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 23 оны 4 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг нь ярина. Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл нарын 2 тэр гишүүн мөн 2023 оны 4 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэхийг нь ярина. Гуравдугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлт гэсэн ийм 3 асуудлыг хэлэлцүүлэхээр хуралдаанд оруулж байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл асуудалдаа оръё, хэлэлцэж эхэлье.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их

Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх хэлэлцүүлгийг эхлүүлэе. Би хууль санаачлагчдын нэгийн хувьд илтгэл хууль санаачлагчдын илтгэлийг та бүхэнд танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Доржханд, Мөнхбаатар, Тогтохсүрэн болон миний бие Монгол Улсын Их Хурлын хууль Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2023 оны 4 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Урт хугацааны хөгжлийн бодлогын эрх мэдлийн хуваарилалт хяналт тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана гэсний зорилт 5.1-ийн хүрээнд 1 дүгээр үе шат буюу 2021-2030 онд төрийн бодлого үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоог бүрдүүлэх.

Тодруулбал Улсын Их Хурлын сонгуулийг холимог системээр явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх ийм маш тодорхой зорилтыг энэ урт хугацааны бодлогын хүрээнд баталсан. Улсын Их Хурал баталчихсан байж байгаа. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн нэгд нам үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-д заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гэж намын бодлого үйл ажиллагааны үндсэн хүрээг нь тодорхойлсон байж байгаа. Энэ үндсэн хэмжээний хувьд улс төрийн нам, улсын хэмжээний бодлого, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр

дэвшүүлж, сонгуульд өрсөлдөх, сонгуулийн тойрог дагасан улсын төсвийн нэгдмэл бус байдлыг арилгах боломжит сонгуулийн тогтолцооны хувилбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх үндэс болж байгаа юм. Үндсэн хуулийн энэ заалт.

Энийг үндэслээд сонгуулийн тогтолцооноос үүдэн гарсан Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжлийн сөрөг үр дагаврыг арилгах, төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоог бүрдүүлэх, хууль тогтоомжийн чанарыг сайжруулах шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог мажоритар болон пропорциональ хосолсон тогтолцоогоор явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, түүнчлэн Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах зэргээр Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг эргэн харж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагатай байна гэж хууль санаачлагчид үзсэн.

Төслийг боловсруулахдаа Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас 2020, 2021 оны сонгуулиудыг ажиглаад өгсөн зөвлөмж, СЕХ, УБЕГ, ГХЯ, ЦЕГ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирсэн саналуудыг авсан. Хуулийн төслийг Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны суурь өөрчлөлт хуулиар зохицуулах харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлах боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагад үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөл боловсруулах ёстой. Ингээд хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгасан.

Үүнд нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын 38 гишүүнийг хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос, 38 гишүүнийг энэ хуульд заасны дагуу сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас тус тус сонгох сонгуулийн хосолсон тогтолцоотой байхаар тусгаж, үүнтэй холбоотойгоор нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх, саналын хуудсыг хэвлүүлэх, сонгогч санал өгөх, түүнийг тоолох, дүн гаргах, суудал хуваарилах, гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэд иргэн сонгуульд оролцож санал өгөх эрхийг хангах, улс төрийн намын бүртгэл өөрчлөлттэй холбоотойгоор нам, нам сонгуульд оролцохоо илэрхийлэх, хүлээн авах, түүнийг нь хүлээн авах, бүртгэх үйл ажиллагаатай холбоотойгоор гардаг урьд өмнө нь гарч байсан хүндрэл, эрх зүйн тодорхой байдлуудыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хяналттай байдлыг нэмэгдүүлэх. Уг үйл ажиллагаанд төрийн болон сонгуульд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх зэрэг харилцааг илүү нарийвчилсан зохицуулалтыг.

Хоёрдугаарт, Монгол Улсаас гадаад улсад суугаа ЭСЯ, ОУБ-ын дэргэд суугаа Монгол Улсын байнгын төлөөлөгчийн газар Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд, иргэн сонгуульд оролцож санал өгөх эрхтэй байхаар тусгаж, үүнтэй холбоотойгоор гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг зохион байгуулах байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагын бүтэц, бүрэн эрх, ажиллах журам, гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох харилцааг нарийвчилсан зохицуулалтуудыг.

Гуравдугаарт, улс төрийн намын бүртгэл өөрчлөлттэй холбоотойгоор нам

сонгуульд оролцохоо илэрхийлэх, хүлээн авах, бүртгэх, үйл ажиллагаатай холбоотой гардаг хүндрэл, эрх зүйн тодорхойгүй байдлыг арилгах талаар нарийвчилсан зохицуулалтуудыг.

Дөрөвдүгээрт, сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хяналттай байдлыг нэмэгдүүлэх. Уг үйл ажиллагаанд төрийн болон сонгуульд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр зохицуулалтуудыг.

Тавдугаарт, санал авах өдөр өөрийн харьяа хэсгийн хороонд саналаа өгөх боломжоор бүрэн хангагдаж чаддаггүй сонгогчид болох оюутан, ээлжийн ажил хийдэг хүмүүс зэрэг сонгогчдын эрх, сонгох эрхийг хангах шаардлагад үндэслэн урьдчилан санал авах ажиллагааны талаарх зарим зохицуулалтыг тусгасан болно.

Хууль хамт өргөн барьсан тогтоолын төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Өнөөдрийн өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. СЕХ-ны дарга Дэлгэрнаран, СЕХ-ны Ажлын албаны дарга Баяндүүрэн, СЕХ-ны Хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Цахим хөгжил харилцаа холбооны дэд сайд Эрхэмбаатар, Эрхэмбаатар ирсэн үү? Оруулаарай Эрхэмбаатарыг. Ийм хүмүүс ажлын хэсэгт ирсэн байгаа. Хуралдаанд оролцож байгаа гишүүдээс гишүүд хууль санаачлагчдаас илтгэлтэй нь холбогдуулаад асуух саналтай бол нэрээ өгье. Занданишатар гишүүнээр тасаллаа. Хууль санаачлагчаас асууна шүү дээ. Бямбацогт гишүүний микрофоныг өгье.

С.Бямбацогт: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар оруулж ирж байна. Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 1

дүгээр зүйл дээр 3.1 дээр Монгол Улсын Их Хурлын 38 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос 4.3.2 дээр Монгол Улсын Их Хурлын 38 гишүүнийг энэ хуульд заасны дагуу сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам эвслийн нэр дэвшигчийн жагсаалтаас гээд оруулж ирж байна л даа. Өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурлын 38 гишүүнийг сонгуулийн тойргоос, 38 гишүүнийг намын жагсаалтаар сонгохоор ийм хуулийн төсөл өргөн баригдаж байна. Өөрчлөлт нь. Тэгээд энэ хэр зөв юм бол?

Эндээс ингээд харах юм бол бид нар чинь бас Сонгуулийн тухай хуульд Үндсэн хуульд бас сонгуулийн тойргийг байгуулахдаа Их Хурлын гишүүдийг бас хуваарилахдаа хүн амын тоо, засаг захиргаа, нутаг юу засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан байгуулна гэж заасан байдаг л даа. Өөрөөр хэлэх юм бол 21 аймагтай, 9 дүүрэгтэй. Эдгээрийгээ засаг захиргааны нэгж гэж явдаг. Тэрэн дотор бас аймгуудынх нь газар нутгийн хэмжээ, хүн амын тоог харгалзах ийм заалттай. Ингэхээр 21 аймагтай, 9 дүүрэгтэй. Өөрөөр хэлэх юм бол ба засаг захиргаа нэгжийн хувьд аваад үзэх юм бол 21 аймаг, 9 дүүрэгт чинь бол 30 нэгж болох байх. 30 нэгжээс яг нэгжийг харгалзана гэх юм бол 30 гишүүн нэр дэвших нь. Цаана нь 8 гишүүн бол тэгээд газар нутгийн хэмжээ харах уу, хүн амын тоо харах уу гээд үзэх юм бол юу гэдэг юм олон хүн амтай аймгууд гэвэл Хөвсгөл, Өвөрхангай олон хүн амтай дүүрэг гэх юм бол Баянзүрх, Сонгинохайрхан гээд л үндсэндээ бол 1 цөөхөн, дүүрэг, аймаг 2 гишүүнтэй, бусад одоо ихэнх аймаг, ихэнх дүүрэг бол үндсэндээ 1, 1 төлөөлөлтэй л болох нь л дээ. 1, 1 гишүүний төлөөлөлтэй. Энэ хэр зохимжтой юм бол? Энэ дээр бас манай хууль санаачилж юу гэж үзэж байгаа юм бол? Урьд нь 3 төлөөлөлтэй байсан чинь Ховд аймаг 1 л төлөөлөлтэй болох нь. Энэ зөв үү?

Хоёрдугаарт нь бас гишүүд яриад байгаа бас улс төрийн намууд ч яриад байх шиг байна. Ер нь сонгуулийн гишүүдийн жендерийн харьцааг 50, 50 болгоно, адилхан 1, 1 болгоно гэсэн асуудал. Ингээд үзэх юм бол нөгөө 38 гишүүний чинь 19 нь эмэгтэй болох нь, 19 нь эрэгтэй болох нь нэр дэвшигч нар. Тэгээд дэвшээд гараад ирэхээр үндсэндээ бол зарим аймаг нь эмэгтэй ганцхан төлөөлөлтэй, зарим аймаг нь эрэгтэй ганцхан төлөөлөлтэй иймэрхүү л юм болох нь л дээ. Тэгээд энийг бас харгалзаж үзсэн үү? Энэ бас бодох л ёстой асуудал болох байх.

Жагсаалтын хувьд 38-ын жагсаалттай болох нь байна. Жагсаалт нь дотроо гулсах юм уу, гулсахгүй юм уу? Намын нэр дугуйлах юм уу, хүний нэр дугуйлах юм уу? Бас намын нэр дугуйлаад явдаг нам дотор жагсдаг гээд л шүүмжлэл дагуулж байсан 2012 оны Сонгуулийн хууль дээр. Хүн дугуйлаад хүний авсан саналаар нь бас эрэмбэлэх ёстой гэж байгаа асуудал бас яригддаг. Эдгээр дээр бас юу гэж үзсэн юм бол? Тэгээд одоо бол энэ үндсэндээ миний хэлэх гэж байгаа санаа бол үндсэндээ энэ 38 тойргоос дэвших чинь бол 1 аймаг, 1 дүүрэг 1 л төлөөлөлтэй болох нь. Энэ хэр зөв юм бэ? Энэ дээр 1 тодорхой хариулт өгөөч.

Н.Энхболд: Би эхлээд хариулчихъя. Тэгээд дараа нь манай хууль санаачлагчид нэмэх зүйл байвал нэмээрэй гэж хэлье. Бямбацогт гишүүн одоогийн байгаа 76 гишүүний хүрээнд асуудлыг хөндөж тавьж байна. Энэ тохиолдолд яг саяынх шиг асуудлууд гарна нэгдүгээрт. Урьд нь яаж зохицуулж байсан бэ гэхээр том тойргууд байгаа, том тойргууд байгуулаад том тойргуудаасаа сонголт хийгээд явж байсан 1 ийм хувилбар бид нар хэрэглэж байсан.

Хоёрдугаарт яах вэ зүгээр энэ асуудлыг асуултыг ашиглаад хэлэхэд Цэц дээр бол Цэцээс гарсан шийдвэр,

шийдвэрийн үндэслэл дээр үндсэндээ Монгол Улсын сонгуулийг ийм тогтолцоогоор явуулж болох тухай шийдвэр гарсан гэж үзэж болно. Ер нь бол гишүүдийн тоо, тойргийн хуваарилалт тойргийг бол тэртээ тэргүй Улсын Их Хурлаас дахиад тогтоолгож шинээр тогтоодог. Энэ бол дараагийн шатны асуудал байгаа. Тойргийн тоо, гишүүдийн тоо, тогтолцоо энэ бүгд бол хоорондоо уялдаатай ийм цогц асуудал байгаа. Асуудлыг яг энэ байдлаар нь аваад үзэхээр энэ саяын Бямбацогт гишүүний асууж байгаа энэ бэрхшээлүүд, бэрхшээл гэхээсээ илүү асуудлууд үүснэ. Энийг хэлэлцүүлгийн явцад бид нар шийдэх боломжууд байгаа гэж үзэж байгаа нэгдүгээрт.

Хоёрт жагсаалтад намууд хүмүүсээ дэвшүүлээд нэрийг нь зооно, санал авахдаа намд өгч болно, хүнд өгч болно. Тэгэхдээ тэр одоо зүгээр энгийнээр ингээд тайлбарлаад хэлэхэд санал авах хуудсан дээр 3 баганад байна. Эхний баганаар нь тойрогт нэр дэвшиж байгаа хүмүүсээ сонгогчид тухай тухайн тойрог дээрээ сонгочихно. 2 дахь багана дээр нь нам, 3 дахь дээр нь хүн, хүний нэр байх болов уу гэж. Зүгээр дараалал нь ямар байхыг би мэдэхгүй байна. Энийг бас сонгууль санал хураах хуудас дээрээ бид нар дахин ярих, зарчмын асуудлуудаа шийдчихээд тавих ёстой. Тэрнээс хүн бол эсхүл намд нь эсхүл хүнд нь 1 санал 1, 1 санал өгнө, 1 л санал өгнө. Намд өгөөд, хүнд өгөх асуудал тухай байхгүй. Одоо бид нарын өргөн мэдүүлсэн хувилбараар бол. Ингээд нийт намд өгсөн санал, хүнд өгсөн саналууд нь нийлээд тухайн намд очих саналын нийт дүн болно. Тэрүүгээр нь үлдсэн нөгөө 38 суудлаа хэнд ямар хувиар хуваарилах вэ гэдгээ хувиар аль намд хэдэн хувиар хуваарилах вэ гэдгээ шийдээд явах ийм тооцоотойгоор энэ хуулийн төслийг боловсруулсан. Засгийн газраас санал авсан. Эмэгтэйчүүдтэй холбоотой хэсэг дээр жагсаалтад байгаа тухай тухайн нам, эвслээс жагсаалтад бичигдсэн хүмүүсийг эрэгтэй, эмэгтэй,

эрэгтэй, эмэгтэй гэсэн дарааллаар солбиж бичиж оруулъя гэсэн санал ирсэн. Тэрийг нь ажлын хэсэг дээр ярьж байгаад ямар ч байсан Засгийн газраас ирсэн саналыг хүлээж аваад, хуулийн төсөлдөө тусгаад өргөн мэдүүлчихсэн байгаа. Хэлэлцүүлгийн явцад бас энд янз бүрийн саналууд гарч байгаа гишүүдээс. Тэгээд явцааа шийднэ.

Өнөөдрийн бид нарын өргөн мэдүүлчихсэн байгаа хууль, АН-ын 2 гишүүний өргөн мэдүүлчихсэн байгаа хуулийн гол зарчмын асуудал бол холимог мажоритар, пропорциональ 2 хосолсон энэ тогтолцоогоо шийдээд авчихвал энийгээ дагалдаад тэр гишүүдийн тоо, эмэгтэйчүүдийн квот, дотор нь яаж хуваарилах вэ, тойргийн асуудал гэх мэтчилэн зүйлүүдийг энэ хүрээндээ яриад шийдэх боломжууд бол нээлттэй байгаа гэж харж байгаа. Тийм. Нэмэх юм байна уу? Юу? Гулсах тухай асуудал байхгүй. Хүн бол эсхүл тойрог дээр нэр дэвшинэ, эсхүл жагсаалтад орно. Аль нэгээс нь бие рүү нь шилжих асуудал байхгүй. Ярьчихсан тийм. Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Тойргоос 38 гэдэг маань нэг л жоохон сонсогдохгүй л байна л даа. Үндсэндээ бол ихэнх аймаг, ихэнх дүүргүүд маань 1, 1 л төлөөлөлтэй болох нь. Одоо бол дунджаар 3 төлөөлөлтэй байгаа. Тэгээд дээрээс нь нөгөө эмэгтэй, эрэгтэй солбиод явна гэх юм бол бүр 1 төлөөлөл нь эмэгтэй тийм л болох нь. Тэгэхээр энийг бид нар өөр зохицуулах бололцоо байхгүй байсан юм байх даа. Энийг илүү жоохон тодруулаад хариулт өгөх бололцоо байна уу?

Н.Энхболд: Бямбацогт гишүүний яриад байгаа зүйлүүд бол би өөрийнх нь хэлж байгаа үгтэй санал нэг байна. Энэ бол бодох ёстой асуудал гэж. Тэгээд энэ хууль өргөн баригдсанаар бүх асуудал хаагдчихаж байгаа биш гэдгийг дахиад тодруулаад хэлье. Тойрог дээр, тоон дээр Улсын Их Хурлын гишүүд зарчмын зөрүүтэй саналуудаа гаргаад, олонхоороо

яваад шийдээд, шаардлагатай бол бусад хууль тогтоомж руу ч гэсэн тэрнээс үүдээд орох ийм үүд хаалга бол нээлттэй байгаа гэж ойлгож байгаа. Тогтохсүрэн гишүүн уг нь ажлын хэсэг, хүлээж бай тэгээд. Оюунчимэг гишүүний микрофоныг өгье.

М.Оюунчимэг: Юуны өмнө Засгийн газраас орж орж ирж байгаа бас энэ санал манай Нямаагийн Энхболд тэргүүтэй 4 гишүүний өргөн барьсан, Цогтгэрэл, Ганбат нарын гишүүдээс өргөн барьсан гээд энэ бүх хуулийн төслүүдэд ямар ч байсан нөгөө төлөөллийн оролцоог тэгш хангах, жендерийн баланс барих, хөгжлийн асуудал энэ тэрийг маш сайн дэвшилтэт ийм заалтууд тусгаж орж ирсэнд юуны өмнө маш талархаж байгаагаа илэрхийлье. Саяын харин Бямбацогт гишүүний ярьдгаар тэр тойрог тоон дээр үнэхээр бас маш нухацтай хандах нь бол бас зөв болов уу гэж бодож байгаа. Жишээлбэл ЧД гэхэд 1 хүн төлөөлөөд явах уу? Саяын яг нэг Хөвсгөл аймаг гээд тэр олон мянган хүн амтай аймаг дээр 1 байх уу эсвэл 60, 40 юм уу, 38, 38 гэх юм уу гээд. Бас улс орны хөгжил энэ хүн амын бүтэц тоо энэ тэрээ харгалзаж байж энэ нөгөө тоо тогтоох, тойрог тогтоох энэ тэр асуудал дээр бодолцохгүй бол энэ өөрөө эргээд бас дахиад л өөрчлөлт оруулах хэрэг гарах вий гэсэн болгоомжлолыг сая бас бид нар Blue sky-д нөгөө төсвийн шинэчлэлийн асуудлаар ярьж байхад эдийн засагч бас судлаачдын зүгээс танай хууль дээр ийм явж байгаа юм байна лээ гээд зөвлөж хэлж байна лээ. Тэгэхээр бид нар бас анхнаасаа энэ асуудлууд дээрээ бас болгоомжтой хандаж сайн ярих нь зөв болов уу гэсэн байр суурьтай байна.

Одоо бол энэ Цогтгэрэл нарын гишүүд, Нямаагийн Энхболд нарын ингээд гишүүдийн өргөн барьсан хуулийн төслийг харахад жагсаалт бол 1, 1 гэсэн харьцаа дээр ер нь аль аль нь бол санал нэгдэж байгаа гэж би бол ойлгож байна. Эхлээд энэ 3, 1 гэж байснаа энэ Ганбат,

Цогтгэрэл нарын гишүүдийн өргөн барьсан дээр дахиад энийгээ 1, 1 гэж өөрчилж байна гэж ойлгож байгаа нь зөв үү? Тэгэхээр ер нь бол энэ дээр бол хаана хаана санал нэгдэж байгаа гэсэн ойлголттой байна. Энэ нь өөрөө яагаад гэвэл нөгөө хөгжлийн асуудал учраас бас энэ дээрээ анхаараад явах нь зөв болов уу гэсэн бид нар бас бодолтой байгаа.

Хоёрт нь энэ дээр ийм байгаа юм. 22.47 гээд нөгөө 12 дээр цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахад зарцуулах зардал нь сонгуульд зарцуулсан нийт зардлын 15 хувиас хэтрэхийг хориглоно гээд заасан заалт байна л даа. Тэгэхээр сонгуулийн зардлыг аль болохоор бууруулъя, тэгэхгүй бол маш их зардал гарч байна. Харин ч нөгөө шударга өрсөлдөөн болж явахын оронд мөнгөний өрсөлдөөн болоод байгаа. Тиймээс аль болохоор зардал бууруулъя гэдэг санал бол нэлээд их гарч байгаа шүү дээ ер нь хаа сайгүй. Олон нийтийн зүгээс ч, хэвлэл мэдээлэл, бас улс төрийн намуудын зүгээс. Тэгэхээр ер нь зардал бууруулах тухай асуудал дээр энэ хууль санаачлагчид ямар дэвшилтэт заалтууд оруулж ирж байгаа вэ?

Хэрэв энэ зардал бууруулчихвал энэ цахим орчин гэдэг бол ерөнхийдөө шударга өрсөлдөөн гэхээсээ илүү хар мэдээллээр бие биеийгээ харлуулсан сөрөг PR-аар л нил болдог шүү дээ. Өнгөрсөн сонгуулиудын түүхийг харахад. Тэгээд л сонгуулийн дараа нь энэ өөр болоод л хувирчихдаг. Тэгэхээр энэ тэрээ бид эхнээсээ нэгэнт л Сонгуулийн тухай хуульд ингээд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тохиолдолд санхүүжилт, сурталчилгаа, хэвлэх материал, зардал энэ тэрээ бол маш тодорхой болгоод тусгаад явчихвал зөв болов уу гэсэн би байр суурьтай байгаа.

Хууль санаачлагчдын хувьд нэг зүйл хэлэхэд өчигдөр ТББХ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, улс төрийн намууд хамтраад маш чухал хурал хийсэн,

хэлэлцүүлэг хийсэн. Энэ нөгөө төлөөллийн баланс, тэгш оролцооны асуудлаар. Тэгээд энэ намын жагсаалтад ялах магадлалтай тойрогт эмэгтэйчүүдийг тодорхой байршуулж, хуваарилах шаардлагыг мандатад тусгах нь уг нь их чухал. Хэрэв нөгөө энэ квотын шаардлагаа бариагүй тохиолдолд СЕХ тухайн нам сонгуульд дахин сонгууль явуулах ч гэдэг юм уу тийм яг заалтыг нь оруулж өгөхгүйгээр квот ч юм уу, 1, 1 ч гэдэг юм уу, 30 хувь, 40 хувь гэж тавиад үр дүн бага байдаг гэсэн зөвлөгөөг өгч байна лээ л дээ. Тэгэхээр энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ гэсэн асуулт байна. Баярлалаа.

Н.Энхболд: Цогтгэрэл гишүүн нарын өргөн мэдүүлсэн хуулийг бид нар энэний дараа тусгайлан хэлэлцэнэ. Тэр үед нь тэр жендерийн харилцааны тухай асуудлаар Цогтгэрэл дарга хариулчихна байх гэж бодож байна.

Зардал бууруулах тал дээр нэлээд олон зүйлүүдийг оруулсан байгаа. Саяын Оюунчимэг гишүүний хэлсэн ерөөсөө угаасаа холимог тогтолцоог оруулна гэдэг бол зардлыг өөрөө ихээхэн хэмжээгээр бууруулах автомат том суурь болж байгаа. Яагаад гэвэл 36 тойрог дээр хүн болгон ихээхэн хэмжээний юм зардаг байсны тал нь алга болоод, намынхаа хэмжээнд бүхэлдээ улсын хэмжээнд сурталчилгаа явуулах бол тэгээд өмнөх сонгуулиудын туршилагаас харахад яг тойрог дээр явуулж байсан зардал бас бага гарч байсан. Энэ өөрөө 1 том суурь болж байгаа гэж харж байгаа.

Тэгээд дээр нь СЕХ-ныхны зүгээс бас бэлдэж байгаарай. Яг зардал бууруулахтай холбогдсон ямар, ямар заалтууд оров гэдгээ. Би зүгээр 1, 2-оос нь дурдъя. Нэмэх шаардлагатай гэвэл Ерөнхий хорооныхон түрүүчийн хуулиудтайгаа харьцуулаад нэмэлт лавлагаа өгөөрэй. Хэвлэмэл хуудасны хэмжээг бууруулж байгаа, хэрэглэх унаа

малын хэмжээг бууруулж байгаа, энд тэнд хатгадаг самбаруудын хэмжээг бууруулж байгаа гэх мэтчилэн. Тэгээд ер нь хууль батлагдсаны дараа СЕХ-ноос тухай тухайн тойрогт тухайн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээнүүдийг тооцож гаргадаг. Энэ хуулийг ийм байдлаар ингээд баталлаа гэж бодоход зардал ямар хэмжээгээр хэмнэгдэх тооцоо гарсан бэ гэдгээ СЕХ хэрэв одоо хийсэн байгаа бол тийм тоог нэмээд хэлчих, хийгээгүй бол хэлэлцүүлгийн явцад яг одоогийн өргөн барьсан төслийн хэмжээнд бол зардал ийм хэмжээгээр буурна гэдэг тоогоо бас танилцуулаарай.

Цахим сурталчилгааны хувьд бол яах вэ нийт сурталчилгааны зардлын хугацааны 15 хувиас хэтрэхгүй гэсэн ийм заалт байгаа. Тэгвэл доторх нь яаж агуулгынх нь тал дээр бол мэдээж сонгуулийн үеэр тавьдаг бусад хэвлэл мэдээллийн байгууллага сурталчилгааны материалын агуулгад тавьдаг шаардлагуудыг адилхан тавиад, хугацааг нь бол 15 гэж ингэж хугацаагаар хэмнэсэн байгаа.

Дахиад Оюунчимэг гишүүн гишүүдийн тоотой холбоотой асуудлыг хөндөж тавьж байна. Төлөөллийн асуудал. Тэгээд яах аргагүй үнэхээр хүн амын тоо, орон нутгийн төлөөлөл бол бас боломжийн хэмжээнд байх шаардлага энэ элдэв юмнуудаас үүдээд миний дахин, дахин хэлээд байгаа яаж энэ асуудлуудыг тогтолцоогоо ерөнхийдөө холимгоороо тогтчихоод, хэдэн хүнтэй ч байна нийт нэр дэвшигчийнхээ 50, 50 хувиар жагсаалтаар тойргоор гэдэг дээрээ тохирчихвол бусад асуудлуудыг бүгдийг нь ярих ийм боломжууд нээлттэй байгааг би дахиад хэлье. Хүний тооны асуудал ч энэ дээр ярилцах боломж бий. Тойргуудыг яаж хуваарилах вэ гэдэг дээр ч ярих асуудлууд бол байгаа. Урьд өмнөх сонгуулиудаар ч гэсэн ийм асуудлууд гарч байсан. Зарчмын том асуудлуудаа шийдчихсэн байхад бусдыг нь бол хэлэлцүүлгийн явцад олонхоороо яриад

шийдээд ингээд явж байсан практик бий. Хуулийн тийм боломж ч байгаа.

Зүгээр нэг зүйлийг зориуд нэмж хэлэхэд энэ удаа жишээ нь бид нарын манай 4 гишүүн АН-ын 4, 2 гишүүн энэ хуулийн төслийг ялангуяа манай хуулийн төслийг бидний өргөн барьсан хуулийн төслийг өргөн мэдүүлэхдээ ажлын хэсгийн хүрээнд бүх санал дээр нь санал нэгдэж байгаад ингээд оруулсан төсөл гэдгийг нэгдүгээрт хэлье. Дараа нь АН дээр ярьж байгаад, зарим зүйл дээр намын бүлэг дээрээ намын гишүүдтэйгээ зөвлөж байгаад бас тэрнээс арай өөр хувилбарууд байж болох юм гэсэн санал гаргасан. Тэрнийгээ өөрснөө хуулийн хуулиар олдсон эрхийнхээ дагуу хуулийн төсөл болгоод өргөн мэдүүлсэн, харьцуулж үзсэн Байнгын хороон дээр. Зарчмын том зөрүүтэй санал байхгүй. Тэгээд хамгийн гол суурь болох холимог тогтолцоо, тоо хэд ч байсан жагсаалт, тойрог хоёрынхоо харьцааг тавь тавиар гэсэн дээр санал нэг байгаа. Суурь том, зарчмын том. Хувиасаа хэлэхэд олзуурхууштай, урьд өмнө ярьж байсан, тэгэхдээ санал нийлдэггүй бас ийм зүйлүүд дээр санал нийлсэн нь бол энэ 2 хуулийн төслийн нэг нийтлэг онцлог байгаа гэдгийг бас хэлчихье. Оюунчимэг гишүүний микрофоныг өгье.

М.Оюунчимэг: Ямартай ч одоо бүх жендер талаасаа ярихад Засгийн газрын хуулийн төсөл дээр ч, манай энэ 6 гишүүний өргөн барьсан Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл дээр ч гэсэн тэгш оролцооны асуудал, энэ хөгжлийн асуудлыг жендерийн баланс барих асуудлуудыг үнэхээр дэвшилттэйгээр ингэж зааж оруулж ирсэнд бол талархлаа илэрхийлье. Харин энэ нь өчигдрийн тэр гаднын экспертүүд, тэр Сонгуулийн ерөнхий хорооны хүмүүсийн ярьж байх дээр жишээлбэл намын жагсаалтаар гэхэд нөгөө төлөөлөх чадвартай хүчтэй кандидат л байх асуудал нь өөрөө одоо яг яриад байгаа

нөгөө тэгш баланс барьж, хөгжлийн асуудал нь өөрөө болдог. Тэгэхгүйгээр бас зүгээр 1 кноп дардаг хүмүүс оруулаад ирвэл эргээд энэ дэвшил чинь 4 жилийн дараа юм уу бүр алдагдахад хүрнэ шүү.

Тийм учраас одоогоос анхнаасаа энэ ажлыг эхлүүлэхдээ энэ шалгуур энэ тэрээ маш сайн барих ёстой гэдгийг ХБНГУ-ын өнөөгийн энэ хөгжлийн туршлага харуулж байгаа шүү гэдгийг ярьж байсан. Тийм учраас энэ Сонгуулийн хуулийг хэлэлцэж эхлэх явцад.../минут дуусав/

Н.Энхболд: Тийм, энэ бүх гишүүдэд хандаж хэлж байгаа санал гэж бодож байна. Бид нар эхлээд Байнгын хороон дээрээ, тэгээд дараа нь Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаад 76-уулаа шийднэ. Манай гишүүд энэ Оюунчимэг гишүүн бусад эмэгтэй, энэ чинь ганцхан эмэгтэй хүний асуудал биш л дээ. Хүйсийн тэнцвэрийн асуудал байгаа юм. Бүгдээрээ энэ дээр анхаарал хандуулж байгаа гэж бодож байна. Дахиад нэг зүйлийг хэлэхэд бол энэ хууль ажлын хэсэг байгуулахаас өмнө улс төрийн ер нь Монголд бүртгэлтэй үндсэндээ бүх намууд, эрдэмтэн судлаачид орсон хэд хэдэн удаагийн зөвлөгөөн болсон. Тэр дундаас гарсан саналуудыг нэгтгэж, бүлэглэж байгаад хамгийн нийтлэг гарч байсан өнөөдөр нийгэмд хүлээгдэж байгаа гэж үзэж болохуйц саналууд, дээр нь Зөвлөлдөх санал асуулгын дүнгээр гарсан гарсан бас байр сууриудыг нэгтгэж байж ийм хуулийн төслүүд аль, аль гарч, тэр нь тэр бол энэ 2 хуулийн үндсэн суурь болсон шүү гэдгийг бас дахиад хэлчихье. Түрүүн Амарбаясгалан даргыг орж ирэхийг хүлээгээд Тогтохсүрэн дарга асуухаа хойшлуулчихсан ингээд. Ажлын хэсгийн гишүүн ч гэсэн санал өгсөн Засгийн газраас асуулт байгаа бололтой, асууя гэсэн юм. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй

холбоотой асуудлаар бол хуулийн төсөлтэй холбогдуулж асуух асуулт бол алга байна. Би харин Улсын Их Хурлаас өгсөн үүрэг чиглэлтэй холбогдуулж Засгийн газраас асуух гээд байгаа юм. Тэгэхээр энэ Сонгуулийн хуулийн тухай асуудал ярихаар Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн давхар хашихтай холбоотой асуудлаар, сонгуулийн холимог тогтолцоотой холбоотой асуудлаар ингээд яриад ирэхээр энэ явж явж байгаа л Улсын Их Хурлын гишүүдийн тоотой холбоотой болчихож байгаа юм. Бид энийг нэг тоогоо жаахан өргөтгөж, сонгогчдоо төлөөлдөг төлөөллөө ч нэмэгдүүлэх, сонгогчдоо төлөөлдөг төлөөллөө ч нэмэгдүүлэх, дээр нь энэ сонгуулийнхаа холимог тогтолцоог ч цаашидаа бодитой болгох. Холимог тогтолцооны чинь давуу тал нь санал гээгддэггүй, улс орныг төлөөлдөг, улс орныхоо нийгэм, эдийн засгийн амин чухал томоохон асуудлуудаа эрэмбэлж авч явдаг гээд ингээд ийм олон давуу талууд байгаа юм.

Энэ үүднээс нь Улсын Их Хурлын өнгөрсөн намрын 8 дугаар сард ээлжит бус чуулганаараа 1 тогтоол гаргасан юм 54 дүгээр тогтоол гэж. Тэр үед манай Одонтуяа гишүүн, Доржханд гишүүн эд нар гээд их олон гишүүн энэ үед үг хэлж шийдвэр гаргасан юм. Тэр шийдвэрээ гаргахдаа Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 6 сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоол эцсийн шийдвэр. Үндсэн хуулийн цэцийн 02 дугаар тогтоол эцсийн шийдвэр. Энэ 2-ыг үндэслэж энэ 2 тогтоолын агуулга нь гишүүдийн тоог нэмэгдүүлэхтэй холбоотой асуудал, сонгуулийн холимог тогтоолтой холбоотой асуудлаар цаашидаа Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлага байна гээд Цэцийн шийдвэр гарчихсан юм. Тэгээд энд Цэцийн шийдвэрийг судалж санал боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах үүргийг Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолоор Засгийн газар чиглэл болгосон юм. Тэгээд энэ чиглэлээр Засгийн газраас ямар ажил хийж байна вэ? Тодорхой саналууд бэлтгэгдсэн үү? Яг

өнөөдөр Улсын Их Хуралд өргөн барих ч юм уу, танилцуулахад ер нь бэлэн болсон уу гэдэг асуудлаар би одоо нэгэнт энэ Сонгуулийн хуультай холбоотой асуудал учраас би Засгийн газраас энэ асуултыг асууж байгаа юм. Баярлалаа.

Н.Энхболд: Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Амарбаясгалан 5 дугаар микрофон.

Д.Амарбаясгалан: Өдрийн мэнд хүргэе гишүүддээ. Монгол Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол гарч Засгийн газарт бас үүрэг өгөгдсөн. Учир шалтгааныг бол та бүхэн мэдэж байгаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарахдаа энэ парламентын гишүүдийн тоо нэмэх, тогтолцоог холимог тогтолцоонд шилжүүлэхтэй холбоотой асуудлыг тухайн шийдвэрийнхээ үндэслэл болгож шийдвэр гаргасан байдаг. Тэгэхээр энийг бол шийдэх ийм тогтоолын хэрэгжилтийг хангах үүргийг бол Засгийн газрын зүгээс бол аваад хэрэгжүүлээд ажиллаж байна.

Сая Тогтохсүрэн даргын асуусанчлан Засгийн газрын зүгээс бол өнгөрсөн оны 6 дугаар сард гарсан 34 дүгээр тогтоол Улсын Их Хурлын, мөн энэ 8 сарын 30-нд гарсан 54 дүгээр тогтоол 2-ын хэрэгжилт тэр агуулгынх нь хүрээнд бол Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, судлаачидтай хамтран ажиллаад эцсийн байдлаар бол бэлэн болсон байгаа. Өнөөдрийн байдлаар бид төлөвлөж байгаагаар бол Засгийн газрын зүгээс яамнуудаасаа санал авах процессыг эхлүүлэх, иргэд олон нийтийн түвшинд дунд хэлэлцүүлгийг зохион байгуулах зэрэг ажлыг эхлүүлэхээр бол төлөвлөн ажиллаж байгаа. Мэдээж эдгээр асуудалд олон нийтийн зүгээс улс төрийн намуудын зүгээс хэрхэн яаж хандах вэ гэдгээс шалтгаалж энэ асуудал Улсын Их Хуралд өргөн барих эсэх, цаашиад хэлэлцэх эсэх асуудлууд бол шийдэгдээд явах байх гэж ингэж хариулмаар байна.

Ер нь бол Засгийн газарт өгөгдсөн чиглэлийг бид ойлгохдоо энэ парламентын гишүүн давхар энэ Засгийн газрын гишүүнээр ажиллах энэ боломж нөхцөл нээгдсэнтэй холбоотойгоор энэ 76 гишүүн гэдэг тоо бол хэт бага байна. Нэг ёсондоо 16, 7 парламентын гишүүн Засгийн газрын гишүүнээр ажиллахаараа эргээд парламентынхаа хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлд сөргөөр нөлөө үзүүлж байна. Ирцэд нөлөө орж байна. Дээрээс нь парламентад парламентын гишүүдэд Засгийн газрын нэрийн өмнөөс бас нөлөөлөл үзүүлдэг тийм муу жишиг тогтох вий гэдэг ийм болгоомжлолыг барьж Үндсэн хуулийн цэцийн ийм шийдвэр үндэслэлийг хийсэн гэж бидний зүгээс бол ойлгож байгаа юм.

Зүгээр яах вэ Монгол Улсын тухайд бол энэ парламентын гишүүн 76 байгаа байдал нь бидэнтэй ижил хүн ам цөөтэй пост коммунист улсуудад бол харьцуулалт хийгээд үзэхэд бол хэт цөөн гэдэг энэ зүйл дээрээ очсон. Хэт цөөн гэдгийн 1 шалтгаан бол 1 гишүүний төлөөлж байгаа сонгогч иргэд сонгогчдын тоон дээр бол харьцуулалт хийгээд үзчихье. 1992 онд парламентын 1 гишүүн 24000 орчим иргэдийг төлөөлдөг байсан бол өнөөдрийн байдлаар 45000 иргэдийг төлөөлдөг болсон. Энэ нь эсрэгээрээ ард иргэд сонгогчдын дунд парламентын гишүүн хүрэлцэхгүй нөгөө гишүүнээ ард иргэдийн зүгээс хайх сурвалжлах тэр нөхцөл рүү бол оруулаад байна гэж байгаа юм. Тэгээд олон улсын жишигээр бол ерөөсөө 1 парламентын гишүүн нийт хүн амынхаа дээд тал нь 1%-ийг төлөөлдөг ийм практик байгаа бол манайд өнөөдөр 1.45 орчим хувь болчихсон байгаа нь харьцангуй өсжээ гэдэг энэ тоог бол харж болохоор байгаа юм.

Тэгэхээр яах вэ Засгийн газар эдгээрийг үндэслээд улс төр судлаачид, Үндсэн хууль судлаачид, мэргэжлийн хуульчидтай бас хамтарч ажилласны

үндсэн дээрээс саналыг бол боловсруулсан гэдгийг бас та бүхэндээ хэлье.

Н.Энхболд: Баярлалаа. Ерөнхийдөө түрүүн гишүүдийн асуусан асуулт, Засгийн газраас өгч байгаа хариулт өнөөдрийн нөхцөл байдалд хийж байгаа дүгнэлт, асуудалд хандаж байгаа хандлагууд бол 1 долгион дээр байна уу гэж би харж байна. Тийм учраас хэлэлцүүлгийн явцад энэ зүйлүүдийн нэмээд, тодруулаад шаардлагатай гэвэл өргөн барьсан хуульдаа зарчмын зөрүүтэй саналуудаар өөрчлөлт оруулаад, бүр шаардлагатай гэвэл дахиад өөр бусад хөндөх ямар асуудал гарч ирэх нь тэрийг нь хамт хэлэлцээд хөндөөд хэлэлцээд явах ийм боломж ерөнхийдөө байна гэж харж байна. Тийм хандлага ажиглагдаж байгааг хэлчихье. Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Сонгуулийн хууль, Төсвийн хууль дээр бол ер нь Их Хурлын гишүүд ер нь өөрийнхөө санал бодлоор л саналаа өгдөг. Тэгэхээр ер нь Төсвийн хууль дээр яагаад тэгдэг юм бэ гэхээр бас тодорхой хэмжээгээр энэ сонгогдсон ард иргэдийнхээ төлөө тэндхийн ард иргэдийн нийгмийн асуудал, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхийн тулд бас тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг тавих дээр бол заавал намын бүлгийн шийдвэрийг дагалгүйгээр бас өөрийн тэр сонгогдсон хүмүүсийнхээ төлөө саналаа өгдөг. Сонгосон хүмүүсийнхээ.

Тэрэнтэй адилхан Их Хурлын гишүүд бол дахин сонгогдохын тулд Сонгуулийн хууль дээр өөрсдийнхөө бодлоор саналаа өгдөг ийм л талтай байдаг юм. Тэгэхээр өнөөдөр ТББХ-ныхон яг энэ сонгуулийн 38, 38 хувилбар дээр санал өгөх гэж байна. Тэгээд МАН-ын 15 гишүүн байна. Тэгээд би эндээс тоолж үзлээ. 5 нь бол жагсаалтад орох юм байна. Тэрний 4 нь бол 12-оос урагшаа, танай нам нэг 12-13 суудал авах байх. Тэрний тэгээд 4 нь бол юу руугаа орох юм

байна жагсаалтаараа Их Хурлын гишүүн болох юм байна. 1 нь жоохон хойшоо суугаад мултрах юм байна. 6 Их Хурлын гишүүн тойрогт нэр дэвших юм байна. Тэрний 2 нь ялж магадгүй тийм нөхцөл байдалтай байна. Бусдаар нь бусад нь бол нэмэргүй. Тэгээд 4 гишүүн бол яг энэ Сонгуулийн хуулиар явах юм бол тойрог ч үгүй, юу ч үгүй, дэвших ч эрх ч үгүй үлдэх юм байна.

Тэгээд иймэрхүү энэ жишээ нь 15 хүнээс 5 үгүй ээ, 6-гийнх нь эрх ашгийг хангасан энэ хууль дээр танай намын гишүүд ямар бодолтой байгаа юм би сайн мэдэхгүй байна л даа. Их, мэдээж танай намынхан бүлгээрээ ярилцсан байх. Намын дарга, генсек 2 нь орж ирээд ийм, ийм хувилбараар явна. Тэгээд ингээд болохгүй бол Үндсэн хууль хийнэ. Та нар хэрэв тойрогтоо багталцахгүй бол Үндсэн хуулийн өөрчлөлт рүү явна. Тэрэн дээр 76, 76 болгодог ч юм уу, 76, 50 болдог ч юм уу иймэрхүү юм руу явна гэж ярилцсан байх л даа. Тэгээд та нар нөгөө Их Хурлын гишүүд нь нөгөө даргынхаа үгэнд ордог бас дээрээс нь жоохон аймхай учраас юм хум асууж чадаагүй ч үгүй байх. Тэгэхээр энэ хууль бол нөгөө нэг яг өнөөдрийн байгаа Их Хурлын гишүүдийн эсрэг ийм л хууль болчихоод байгаа юм л даа. Тийм учраас энэ хууль чинь явахгүй болчихоод байгаа юм.

Явахгүй болох дээр яах вэ гэхээр Үндсэн хуулийн өөрчлөлт рүү оруулж нөгөө гишүүдийн тоог нь нэмээд, тэр ард түмэн ерөөсөө зуун ямаанд жаран ухна гэгчээр яасан их гишүүдтэй болдог юм гэж эсэргүүцээд байхад тэрний эсрэг явахаар л ийм нөхцөл байдал руу түлхэж байна л даа. Тийм учраас энэ ер нь бол энэ хууль бол ингээд Үндсэн хуулийн өөрчлөлт рүү аваачна. Үндсэн хуулийн өөрчлөлт явахгүй бол тэгээд буцаад хуучин 2020 оныхоороо л явах байх гэсэн ийм л төсөөлөлтэй байгаа. Би тэгээд асуулт алга надад.

Н.Энхболд: Ганц Пүрэвдорж гишүүний таамаглаж байгаа асуудал ч бас биш байх. Улс төрийн нөхцөл байдал бүгдээрэнд нь өөрс өөрсдөд нь тийм дүгнэлт хийх бололцоо олгож байгаа болов уу гэж бодож байна. Санал хэллээ, асуулт асуусангүй. Сарангэрэл гишүүний микрофоныг өгье.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Миний асуулт бөгөөд үндсэндээ Оюунчимэг гишүүнийхтэй нэлээн давхцаж байгаа учраас товчилъя. Би Энхболд дарга нөгөө хэлэлцэх эсэх нь явагдаж байгаа учраас танин мэдэхүйн чанартай асуулт тавих гэсэн юм. Ерөнхийдөө АН-ын 2 гишүүн өргөн барьсан, манай намын 4 гишүүн өргөн барьсан, түүнээс гадна Засгийн газрын өргөн барьсан ийм 3 төсөл байна гэж ойлгож байгаа юм. Тэгээд нэг чиглэлээр олон хүн гэдэг юм уу, нэг хэсэг бүлэг гишүүд хуулийн төсөл өргөн барихаар эсвэл нэгтгэдэг эсвэл тус тусад нь хэлэлцдэг. Тэгэхээр энэ чиглэлээр ер нь ямар мэдээлэл байна вэ гэдэг 1 дүгээр асуулт.

Хоёрдугаарт бол би бас Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөлд мөн манай намын бүлгийн гишүүдээс өргөн барьсан хуулийн төсөлд талархал илэрхийлж байгаа нь улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдээр зогсохгүй нийгмийн бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадууд гээд ингээд бүх бүлэглэлийн төлөөллийг оруулах ийм төлөөллийн ардчиллын зарчмыг хангасан ийм хуулийн төслийг ер нь Монголын парламентын түүхэд, улс төрийн намын түүхэнд бол манай нам, Засгийн газраас бол оруулж ирж байгаа нь үнэхээр их дэвшилттэй, аргагүй дэвшилтэт бодлого байна гэж бас хүлээж авч байна. Энийг ч гэсэн бас олон нийт тэр дундаа эмэгтэйчүүдэд талархалтай хүлээж авч байгаа.

Эдгээрийгээ энэ явцад хэлэлцүүлгийн явцдаа ингээд

баталгаажуулах ийм магадлал хэр өндөр байгаа вэ? Энэ өргөн барьсан, энэ 3 талаас өргөн барьсан хуулийн төслүүдийн түвшинд ер нь та бүхний хооронд харилцан яриа хөөрөө өрнөсөн зүйл байна уу гэдэг ийм хувь тодруулгыг хийх гэсэн юм. Баярлалаа.

Н.Энхболд: Нэгдүгээрт 3 төсөл биш, 2 төсөл явж байгаа. Засгийн газраас бол санал авсан. Бид нарын өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр санал ирүүлсэн байгаа юм. Тэгэхээр 2 хууль 2 төслийнхөө хүрээнд ярина. Хэрэв энэ 2 төсөл маань хэлэлцэх эсэх нь дэмжигдчихвэл цаашидаа нэгтгээд явах ийм бүрэн боломж байгаа. Яагаад би тэгж хэлж байна гэхээр нэгдүгээрт тийм хуулийн боломж байгаа, хоёрт тийм практиктай явж ирсэн. Гуравт үндсэндээ манай 2 төслийн сууриуд нь адилхан. Тоо, харьцаа тэр юмнууд дээр л зөрүү байгаа болохоос биш нэг тийшээ, хандлага нь бол нэг тийшээ Сонгуулийн хуулиа илүү боловсронгуй болгоё, санал гээгддэггүй тогтолцоо сонгож авъя, нийгмийн бүлэг төлөөлөл давхар болгоны төлөөллийг оруулдаг ийм боломжийг нээе, зардлыг хэмнэе, гадаадад байгаа иргэдийнхээ оролцоог нэмэгдүүлье гэх мэтчилэн олон урьд өмнөх сонгуулиудаар шүүмжлэгдэж ирсэн асуудлуудыг цэгцлэх энэ үндсэн санаанууд нэг, суурь нь нэг байгаа учраас цаашидаа хамтраад ингээд хэлэлцээд явах ийм боломж байгаа гэж бодож байна.

Ер нь бол бид нар энийгээ ярьсан. Би түрүүн хэлсэн. Хамгийн анхны хувилбарт бол ажлын хэсэгт орсон 6 хүн буюу Энхболд, Доржханд, Мөнхбаатар, Одонтуяа, Тогтохсүрэн, Цогтгэрэл 6-уулаа санал нийлээд хамгийн сүүлд ажлын хэсгээрээ дахиж 1 хэлэлцээд ингээд өргөн барьсан. Тэгээд дараа нь түрүүн ч би давтаж хэлсэн. Сүүлд нь манай АН-ын бүлгийн зүгээс оруулж ирсэн хуулийн төсөл бол бас ерөнхийдөө ойролцоо, хамтраад хэлэлцээд явахад бол дундаас нь боломжийн хууль гарчих ийм сайн

дэвсгэртэй төслүүд болсон л гэж үзэж байгаа. Тийм. Занданишатар дарга асууя. Дараа нь Мөнхцэцэг гишүүн бэлдэж байгаарай.

Г.Занданишатар: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Хэдэн асуулт байна. Нэгдүгээрт, ер нь энэ Сонгуулийн хуулийн тогтвортой байдлын талаар юу гэж бодож байна вэ? Ерөөсөө ардчилсан шилжилтийн энэ 32 жилийн хугацаанд гуч гаруй жилийн хугацаанд Сонгуулийн хууль хэдэн удаа өөрчлөгдөв? Энэ чинь 1 тогтвортой ард түмэнд ойлгомжтой байж ард түмний засаглах эрхийг эдлүүлж, ард түмэн төлөөлөл сонгох тэр зарчмыг энгийн ойлгомжтой, хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тэгээд л эрх баригч хүчин сонгууль болгонд л ингээд сонгуулийн тогтолцоо өөрчилж, Сонгуулийн хуулиа өөрчилж байснаас болоод ойлгомжгүй байдал үүссэн гэж судлаачид ярьж байна. Ийм учраас цаашидаа энэ Сонгуулийн хуулийг тогтвортой мөрдүүлэхийн тулд ямар зарчим Сонгуулийн хуулийн тогтвортой байдлын үндсийг бүрдүүлэх ёстой юм бэ? Үндсэн хуульчлах ёстой юм уу? Аль эсвэл босгыг нь өндөрсгөх ёстой юм уу? Энэ талаар ер нь ажлын хэсгийг юу гэж бодож байна вэ?

Хоёрдугаарт бол ер нь ардчиллын нэг зарчим бол сонгуулийн ардчилсан тогтолцооны зарчим бол төлөөллийн зарчим. Төлөөллийн зарчмын 1 дэх суурь нь бол ард түмний төлөөлөл байх ёстой. Төрийн эрх барих дээд байгууллага гэдэг бол ард түмнийг төлөөлж, хууль тогтоогчдыг сонгож, хууль тогтоох хуулиар төрийг жолоодно гэсэн ийм агуулгаар Үндсэн хуульд төрийн дээд байгууллага ард түмний төлөөллийн байгууллага гэж заасан. Тэгэхээр энэ ард түмний төлөөллийг хангах 1 дэх зарчим байх ёстой.

2-т нь энэ үндэсний аюулгүй байдлын хувьд ч гэсэн энэ нутаг дэвсгэр газар нутгийн төлөөллийг хангах ёстой.

Газар нутаг гэдэг бол улсын үндэс шүү дээ. Тэр газар нутаг дээр хүн зон амьдарч, ажиллаж, сонгох эрхээ эдэлж байж газар нутгийн бүрэн бүтэн байдал хадгалагдана. Тийм учраас манайх ишг өргөн уудам нутагтай, цөөхөн хүн амтай, ялангуяа хөдөө орон нутагт хүн амын төвлөрөл бага ийм улсад үндэсний аюулгүй байдлын үүднээс газар нутгийн төлөөлөл маш чухал байдаг. Өөрөөр хэлбэл газар нутгийн төлөөлөл нь төрийн бодлогод газар нутгийн бүрэн бүтэн байдлын талаар асуудлыг эзгүйрүүлэхгүйгээр тусгах боломжийг хангадаг. Газар нутгийн төлөөллийн цаана мэдээж тухайн нутаг дэвсгэрт нь амьдарч байгаа хүн амын төлөөлөл байх шаардлага тавьж байгаа юм.

Тэгтэл одоо 1 аймгийг 1 л хүн төлөөлнө гэдэг маань тэр аймаг, сум, багт хүрээд малчны хотонд очоод тэднийг төлөөлж төр удирдах, тэдний санал бодлыг тусгах хууль тогтоомжид ийм боломж хязгаарлагдах юм биш үү? Тэр Баян-Өлгий аймгаас 1 нэгж. Үндэсний аюулгүй байдлын үүднээс бол 1 газар нутгийн нэгжийг 1 хүн төлөөлөх нь эрсдэлтэй гэж үздэг. 1 төлөөлөгч эрсдэлд автах, лоббид автах зэрэг тохиолдолд гарах эрсдэлийг саармагжуулах үүднээс дор хаяж 2 төлөөлөл байх ёстой гэж үздэг. Тэгэхээр энэ чинь 38 гэсэн төлөөлөл, тэгээд энэ Улаанбаатар хотод хүн амын тал нь суурьшиж байгаа Улаанбаатар хотын төлөөлөл чинь 10 гаруй гишүүд л болох нь байна шүү дээ. Ийм учраас энэ төлөөллийн зарчим чинь бүрэн хангаж чадаж байгаа юм уу энэ тоо, тогтолцоонд чинь.

Гуравдугаарт энэ ардчилсан сонгуулийн тогтолцооны төлөөллийн 1 зарчим бол нийгмийн бүлгүүдийн төлөөллийг хангах ёстой гэсэн ийм шалгуур. Энэ 3 шалгуур. Ард түмний төлөөлөл, газар нутгийн төлөөлөл, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл. Нийгмийн бүлгүүдийн төлөөлөл бол энэ пропорциональ тогтолцоогоор нийгмийн

бүлгүүд сегментүүд өөрийн бүлэгт сегментэд тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх хууль тогтооход тусгах шаардлагатай гэж үздэг. Тэгэхдээ нийгмийг бүхэлд нь харж чадахгүй. Тухайн л одоо багш, эмч, бизнес, мэргэжил, сонирхлынхоо тухайн бүлгийн хүрээнд л шийднэ. Тэгэхээр энэ ямар бүлгийг нь оруулах ёстой юм, багш, малчин, эмчийг оруулчихвал инженерийг оруулах уу, хүнсний үйлдвэржилтийг оруулах уу энэ тэр гэсэн ийм ялгаа бас гардаг юм байна лээ. Энийг ер нь яаж шийдэх ёстой юм бэ? Энэ нөгөө бодлогын нам төлөвшихөд хүндрэл учрах уу?

Н.Энхболд: Асуултууд ерөнхий юунд чиглээд байгааг би ойлгож байна. Бас энд байгаа хүмүүс бүгдээрээ ойлгож байгаа байх гэж бодож байна. Эцсийн дүндээ тооны асуудал маань сонгож авч байгаа тогтолцоотойгоо хэр зэрэг уялдаж байгаа юм бэ гэдэг асуулт л энийг тойроод л явж байна гэж бодож байна. Сүүлийн 2 асуулттай харьцуулж хэлэхэд, Занданшатар дарга ч өөрөө ерөнхийдөө асуултаараа хариултуудаа хэлчих шиг боллоо. Сонгуулийн хуулийн тогтвортой байдлын хувьд гэвэл энэ сүүлийн сонгуулиудаас ингээд үзэхэд 4 удаа ер нь 7 удаа Их Хурлын сонгууль мажоритар юу мажоритар олонхын системээр, ганцхан удаа холимог системээр явсан. Ер нь миний санаж байгаагаар сонгууль болгоны өмнө Сонгуулийн тухай хуульд ямар нэгэн өөрчлөлт орж байгаагүй тийм сонгууль болж байгаагүй. Зарчмын том өөрчлөлтүүд хийдэггүй юм гэхэд зохион байгуулалттай холбоотой, зардал мөнгөтэй холбоотой асуудлууд байнга нэмэлт, өөрчлөлтүүд хийж ирж байсан.

11 онд 1 том өөрчлөлт хийсэн тэр нь холимог тогтолцоо болсон. 16 онд тэрийгээ буцаасан. Энэ нь бас дахиад 1 том өөрчлөлт болсон. Одоо бид нар хэрэв энэ хуулиа ингээд явуулж чадвал энэ миний ойлгож байгаагаар Монголын улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралд томоохон сүүлийн үеийн алдаа гэх үү,

дутагдаж ирсэн зүйлүүдээ нөхөх, засруулах ийм түүхэн шийдвэр болно л гэж ингэж ойлгож байгаа юм. Тэгэхээр тэгээд энэтэй яг уялдаад хуулийн тогтвортой байдлыг яаж хангах вэ гэвэл хэрэв бид нар Үндсэн хуульдаа шууд холимог юм уу эсхүл цэвэр пропорционалиар гээд биччихвэл тэр илүү тогтвортой байж магадгүй. Одоох одоогийн байдлаар бол бид нар Цэцийн дүгнэлтийн дагуу л урьд өмнө олон удаа нааш цаашаа болсон дүгнэлтүүдээ дахиж нэг эргэж, эргэж нөгөө нэг байран дээрээ очоод л, эргээд холимог тогтолцоог Цэцийн дүгнэлтийн дагуу ингээд сонгож аваад явж байгаа.

Цаашидаа Үндсэн хууль дотор бол тэр нөгөө үг нь байж байгаа. Уг нь 19 оны нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ тогтолцоог нь гэж Үндсэн хуульд оруулъя гэсэн санал явж байгаад тэгээд олонхын санал авч чадаагүй унасан юм, хуулиар тогтооно гээд л Сонгуулийн хууль гээд үлдсэн. Тэгэхээр энэ Цэцийн хамгийн сүүлд гарсан дүгнэлт үндэслэлүүд бол би олон дахиж өөрчлөгдөхгүй болов уу гэж бодож байна. Энэ нь өөрөө цаашид Сонгуулийн хууль харьцангуй тогтвортой явах нөхцөлийг бүрдүүлж байгаа гэж харж байгаа.

Төлөөллийн зарчмын хувьд бол яах аргагүй тийм байгаа. Зүгээр ганцхан жишээ дурдахад л сүүлийн сонгуулиудаар хэд хэдэн удаагийн сонгуулиудаар жишээ нь нийт сонгогчдын 50 орчим саналыг авсан улс төрийн хүч, заримдаа 50 хүрэхгүйг авсан улс төрийн хүчнүүд Их Хуралд хамгийн олон суудалтай буюу олонх болж ирж байсан. Тэр нь өөрөө одоо энэ сонгогчдын бухимдлыг төрүүлдэг. Миний санал Их Хурал дээр очиж тусгалаа олсонгүй гэсэн зүй ёсны. Тэрийг ч бид нар олон жил ярьж байсан. Тэгээд энэнээс гарах нэг арга зам бол сонгогчийн санал болгон Улсын Их Хурлын суудалд тусгалаа ямар нэгэн байдлаар олж байдаг, 1 ч хүний санал гээгддэггүй энэ тогтолцоог сонгож авах нь зүйтэй гэж олон жил яригдсаныхаа үндсэн дээр

төлөөллийн зарчмын хамгийн том шаардлага болох энэ саяын Занданшатар даргын хэлсэн зүйлийг тусгаж чадах хувилбар нь холимог систем гэж үзээд энүүнийг авсан.

Мэдээж газар нутагтай холбоотой, тойрогтой холбоотой орон нутгийн эрх ашигтай холбоотой асуудлууд хөндөгдөж байна. Энэний цаана бол хэрэв бид нар дахиад хэлэхэд тогтолцоогоо холимогоороо аваад, тойрог жагсаалт хоёроо 50, 50 хувиар авна гэсэн энэ зарчмын дүгнэлтдээ хүрчихвэл шулуухан хэлэхэд Улсын Их Хурлын гишүүдийн тоонд хүрэх энэ зам руу л орох байх. Энд ганц Пүрэвдорж гишүүний ганцаараа яриад байгаа зүйл биш. Ерөөсөө энэ асуудал цогцоороо байх шаардлага, тэгээд тэр ерөнхий шаардлага хажуугаар нь нөгөө нутаг дэвсгэрийнхээ ч эрх ашгийг тусгаж байдаг хангалттай хэмжээний төрийн нэгдсэн бодлогуудаа ч авч явдаг хангалттай хэмжээний гишүүдтэй байна гэвэл тэр рүү явахаас өөр аргагүй байдалд хүрэх байх гэж би бодож байна. Тэгээд хэлэлцүүлгийн явцад энүүнийг бид нар мэдээж тэгээд ярьж таарна.

Өнөөдөр асуултууд ингэж гарч байгаа юм чинь маргааш хэлэлцээд шийдсэний дараа ажлын хэсэг байгуулаад явахад энэ асуудлыг хөндөгдөх юм байна гэж би ойлгож байна. Яг энэтэй адилхнаар нийгмийн бүлгүүдийн төлөөллийг Улсын Их Хуралд шийдвэр гаргах дээд байгууллага, төрийн эрх барих дээд байгууллага хууль тогтоох дээд байгууллагад тусгаж болох хамгийн боломжтой хэлбэр бол сонгуулийн хэлбэр угаасаа өөрөө энэ холимог эсхүл пропорциональ тогтолцоо. Энэ бид нар болоод бодоод олчихсон юм биш. Дэлхийн бүх парламентад ёстой улс орнуудын түүхэнд ажиглагдаж ирсэн шинжлэх ухаан шиг нотлогдчихсон ийм үзэгдэл юм билээ. Тэгэхээр энүүнийг бодолцож бас энэ холимог тогтолцоог сонгож авсан гэдгээ хэлье. Занданшатар дарга

тодруулъя. Манай ажлын хэсгийн бусад гишүүд бас хариулна шүү.

Г.Занданшатар: Тэгэхээр энэ төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах байгаа юм. Энэ баги, эмч нар, төрийн захиргааны албан хаагчид, төрийн тусгай албан хаагчид гээд 225250. Тэгээд нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхлыг хамгаална гэхээр тэр бүлгүүд хамрагддаг. Тэгтэл төрийн албан хаагчид бол улс төрийн намд харьяалагдаж болохгүй, улс төрийн намын ашиг сонирхолд орж болохгүй гээд ингээд хаагдчихдаг. Тэгээд энэ хүмүүсийн сонгох, сонгогдох эрх энэ хуулиар хамгаалагдаж байгаа юу, яаж дэмжиж байгаа вэ? Энэ нийгмийн бүлгүүдийн төлөөлөл гэдэг дээр энэ зарим сегмент хаягдаад байна гэдэг маань энийгээ багцаар нь нэг хариулчих.

Хоёрдугаарх асуудал нь тэр тогтвортой байдал гэдэг бол ер нь сонгогчдын боловсролд хэрэгтэй байгаа юм л даа. Ерөөсөө бүх тогтолцоо сайн, муу талтай. Тэгээд тэрнийгээ тууштай мөрдөж байж нөгөө сонгогчдын боловсрол дээшилж, сонгогчид саналаа өгч дуусгахгүй бол нэг том мажоритар, нэг жижиг мажоритар, нэг пропорциональ, нэг юу гээд ингээд байхаар сонгогчид саналаа өгч сурах энэ ардчиллын 30 жилийн шилжилтийн үед чинь нөгөө ард.../минут дуусав/

Н.Энхболд: Ер нь энэ хуульд тогтолцоо маань өөрөө ерөөсөө энэ бүлэглэл сегментүүдийг оруулахыг илүү их боломж олгосон ийм тогтолцоо. Түүнээс хууль дотор жишээ нь тэрийг заавал оруулна, энийг заавал оруулна, тэрийг заавал оруулна гэсэн үг байхгүй. Ер нь тэгж оруулсан хуультай улс бараг байдаггүй юм байна лээ. Энэ юунаас шалтгаалав гэхээр намуудын байр сууриас шалтгаална. Иргэдийн сонгуулийн тухай ойлголт, боловсрол, улс төрийн төлөвшил, төрөө байгуулах ажилд хандаж байгаа хандлагаас шалтгаална.

Түүнээс яг хуульд бид нарын хамгийн том бололцоо өгч байгаа нь хэлбэр нь л энэ холимог тогтолцоогоо сонгож авч байгаа энэ юу шүү дээ хэлбэр шүү дээ. Бид нарын сонгосон сонголт. Хуучин жижиг тойргоор явдаг байхад энэ тухай яригддаг ч үгүй байсан, бололцоо ч туйлын бага байсан. Энэ бол өөрөө тогтолцоонд их том боломжийг нээж байгаа. Тэгээд дахиад хэлэхэд тэгээд энэ боломжийг намууд яаж ашиглах вэ, иргэд яаж ашиглах вэ гэдгээс л бүх зүйл шалтгаална гэж бол би бодож байна. Манай ажлын хэсгийн гишүүд энэ дээр хэлэх зүйл байвал, Тогтохсүрэн гишүүн, дараа нь Доржханд гишүүн ярих уу? Тэгье.

Д.Тогтохсүрэн: Сая Занданишатар даргын асуултад хариулъя. Тэр Сонгуулийн хуулийн тогтвортой байдал гэж. Сонгуулийн хуулийн тогтвортой байдал үнэхээр чухал байгаа. Бид чинь тэгээд л эрх барьж байгаа нам Улсын Их Хуралд сонгууль болохоор л сонгуулийнхаа тогтолцоо, сонгуулийнхаа журмыг өөрчилж байгаа. Цаашидаа энэ сонгуулийн хууль, эрх зүйн орчин тогтвортой байх нь чухал. Тийм учраас энэ сонгуулийн тогтолцоотой холбоотой асуудлыг Үндсэн хуульд тусгах ёстой гэдэг ийм хувь хүний байр суурь байгаа.

Тэгэх юм бол эрх барьж байгаа болон Улсын Их Хурал тухай бүрд нь сонгуулийн тогтолцоог өөрчлөвд байх ямар ч боломж байхгүй. Тийм учраас энийг бол бид нар Үндсэн хуульдаа тусгах ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа юм.

Н.Энхболд: Хууль санаачлагч Доржханд гишүүн, та ер нь асуултаа болиод байр сууриа юмнууд дээр нэмээд хариулаад явчихвал яасан юм бэ дээ тийм ээ?

Т.Доржханд: Зөв, зөв. Би Их Хурлын даргын тэр байр суурь дээр бол

нэг тодруулга хийчихье. 100 хувь санал нэг байгаа. Одоо нөгөө дүрмээ бид нар маш тодорхой болгохгүй бол ямар сонгуулийн дүрмээр, ямар зарчмаар сонголт хийх юм бэ гэдэг энэ асуудал нь бол иргэдэд ойлгомжгүй байсаар ирсэн. Одоо энийгээ ойлгомжтой байлгах хэрэгтэй. Тийм болохоор энэ пропорциональ сонгуулийнхаа тогтолцоо дээр бид нар бол тогтвортой байдлыг хангах байдлаар ажиллах нь зүйтэй байгаа юм. Тэр ч агуулгаараа улс төрийн намууд бол энэ дээр бол тохирсон байгаа. Энэ санал санаачилга бол зөвхөн энэ парламентад суудалтай байгаа 3 намын санал санаачилга биш юм. Энэ бол сүүлийн 2 жил тойрон зохион байгуулагдсан парламентад суудалгүй намуудын бас оролцоо тэд нарын саналыг тусгаж явсан ийм хамтын шийдвэр юм шүү. Хамтын шийдвэр байгаа.

Тэгээд Монгол Улсын түүхэнд энэ улс төрийн намууд нь магадгүй ингэж зөвшилцөж, ойлголцож явсан анхны тохиолдол юм болов уу гэж ойлгож байгаа. Тэгээд тийм болохоор энэ дээрээ бол бүгдээрээ яаж сонгох нь хамаагүй. Тэгэхдээ тодорхой, ойлгомжтой байх хэрэгтэй. Тэгээд бүх улс төрийн хүчнүүд бол энэ сонгуулийн пропорциональ тогтолцоог бол оруулах нь зүйтэй гэдэг дээр бол санал нэгдсэн байгаа.

Тэгээд бүлгүүдийн асуудал хөндөгдөж байна. Ерөөсөө л энэ сонгуулийн систем пропорциональ тогтолцоо орж байж тэр нөгөө мэргэжилтнүүдийн, эмэгтэйчүүдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл бол Улсын Их Хуралд орж ирэх бүрэн боломжтой байх юм.

Би зүгээр нэг л зүйлийг асуух гээд байгаа нь мэдээж хууль санаачлагчийн хувьд биш юм. Энэ бол нөгөө Засгийн газрын Хэрэг эрхлэх сайд нь ороод ирчихсэн байгаа болохоор бүр тухайлан онцолж асуух шаардлага байгаа юм шүү.

Тийм болохоор би өөрийнхөө цаг дээрээ асууя гэж хүсэж байна. Баярлалаа.

Н.Энхболд: Мөнхцэцэг гишүүн асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ өргөн баригдсан Сонгуулийн хуулийн 2 төслийг бол тогтолцооны хувьд бол ер нь дэмжиж байна. Тэгэхдээ энэ хууль санаачлагчаас асуулт бол байна. Сонгуулийн зардлыг бууруулах чиглэлээр энэ төслийн 4 дүгээр зүйл дээр тодорхой ингээд юунууд бол заалтууд оруулсан байна. Тэгэхдээ яг харахад бол эд нар маань сонгуулийн зардлыг үнэхээр дорвитой бууруулах тийм юу бол харагдахгүй байна. Та бид бүгд мэдэж байгаа 2012 оны сонгуулиар бид нар урлагийн тоглолт болон сонгуулийн сурталчилгааны үед асар өндөр зардал шаардаж байсан энэ урлаг уран сайхны арга хэмжээг бүрэн хориглосон. Энэ бол тухайн үед сонгуулийн зардлыг бууруулах маш том дэвшил байсан.

Тэгвэл ягт одоо энэ цаг мөчид бид нар бас ийм шинэчлэл хиймээр байна. Тэгэхгүй бол бид нар энэ сонгуулийг хөрөнгө мөнгөний өрсөлдөөн эсвэл тухайн тойргоо түрүүлж усалсан гэдэг юм уу, тойрогт сонгогчдод бэлэг сэлт тараасан цөөн хэдэн улс төрчдийн хувьд давуу байдал олгох энэ боломжийг бид нар арилгаж чадахгүй. Тийм учраас энэ хууль санаачлагчдаас ийм тодорхой зарчмын шинжтэй томоохон юунууд хийх боломж байгаа юу гэж асуумаар байна л даа. Жишээлбэл энэ ухуулагч нарын тоог бол цөөлж байна. Энэ бол дэвшил. Тэгэхдээ ер нь олон улсын чиг хандлагаар энэ ухуулагч бол сайн дурын ажилладаг цалин хөлс авдаггүй. Энэ байдлыг оруулах боломжгүй байсан уу?

Телевизээр явуулах сурталчилгааны цагуудыг хязгаарлаж өгмөөр байна. Ер нь сонгуулийн зардлын үлэмж хэсэг бол энэ телевизийн сурталчилгаанд ордог. Мөн энэ нам нэр

дэвшигчдийн сурталчилгааны материалыг нэгдсэн журмаар тараах буюу Монгол шуудан маань өөр хүргэлтийн компаниудаар тараах энэ боломж байхгүй юу? Ер нь сонгуулийн зардлыг үлэмж ихэсгэж байгаа нэг чухал зүйл бол энэ хэвлэл мэдээллийн болон энэ сурталчилгаатай ухуулагч нартай холбоотой үйл ажиллагаа байдаг. Ийм дорвитой заалтууд ер нь оруулах тийм боломж байгаагүй юу? Ер нь бид нар энэ сонгуулийн зардлыг бууруулах чиглэлээр том өөрчлөлт хийх энэ босгон дээр ирчихсэн байгаа. Тэгэхээр Улс төрийн намын тухай хуульд бол энэ тодорхой заалтууд орчихсон явж байгаа.

Тэгээд дараагийн асуулт нь энэ яг өнөөдрийн энэ өргөн барьсан тогтолцооны юугаар бол 38, 38 гэдэг бол төлөөллийг хангаж чадах юм уу, үгүй юу? Жишээлбэл би бол нийслэлээс сонгогдсон гишүүн байгаа. Манай нийслэл бол өнөөдөр яг 1 сая 639 мянган оршин суугчтай. Нийслэлийн гишүүд бид нар ерөнхийдөө 140-150 мянган гишүүдийг иргэнийг бол төлөөлж байгаа. Манай СБД бол 144000 хүн амтай. Гэтэл энэ 38, 38 ингээд хуваагдаад явахаар нийслэл маань ерөнхийдөө арваад 11, 12 ч юм уу ийм л гишүүнтэй болох гээд байна. Гэтэл хүн амын тал нь ингээд нийслэлд суурьшсан.

Гэтэл түрүүн энэ Занданшатар даргын хэлснээр ер нь энэ парламент маань иргэдээ төлөөлсөн байх ёстой, иргэдийн төлөөлөл аль болохоор туссан, иргэдийн санал гээгдэхгүй байх ёстой. Ингэж байж парламентын ардчилсан парламентын тогтвортой иргэдээрээ хүлээн зөвшөөрдөг энэ шинж хангана. Гэтэл одоо байгаа энэ цөөхөн тойргууд маань бүр ингээд багасаад явчихна. Тэгээд нийслэлийн иргэд бол бараг төлөөлөлгүй шахуу үлдэх болох нь. Тэгэхээр энэ маань яг энэ өнөөдрийн байгаа энэ 76 гишүүн бүхий парламенттай чинь хэр уялдаж байгаа юм бэ гэдгийг бол асуумаар байна. Ер нь

бол сонгогч бүр өөрийг нь төлөөлсөн ижил тооны төлөөлөгчтэй байж байж тэр сонгогчийн эрх хангагдах ёстой.

Хоёрдугаарт нь бас парламентын төлөөллийг бид нар бас эргэн харах шаардлагатай байна.

Н.Энхболд: Зардалтай холбоотой асуудал дээр манай СЕХ-ноос бас нэмж тайлбар өгөөрэй. Хөрөнгө мөнгөний өрсөлдөөнийг багасгах, зардлыг бууруулах бүх л ажлуудыг олон талаас нь ярьсан. Яг цаг дээрээ ярихаар жишээ нь таны ярьж байгаа шиг ийм ухуулагч нар сайн дурын үндсэн дээр байх, сурталчилгааны материалыг нэгдсэн журмаар хэвлэх гэдэг зүйлүүд бол яг энэ Сонгуулийн хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцуулсан олонхын саналыг авч чадаагүй л гэсэн үг. Тэр бол зөвхөн бид б-гийн хоорондын асуудал биш, бүх л шатад хэлэлцэж байхад 1 хэсэг нь тийм санал гаргадаг юм. Жишээ нь манай намаас ч юм уу, АН-аас гэхэд нөгөө шинээр өнөөдөртөө улс төрд том орон зай эзлээгүй, харьцангуй бага танигдсан улс төрийн хүчнүүдийн зүгээс бол аль болохоор бололцооныхоо хэмжээгээр олон хүнд хүрэх материал гаргах, бололцооныхоо хэмжээгээр илүү хөрөнгө мөнгө зарж байж нэр дэвшигчдээ танилцуулах энэ шаардлагууд нь цаанаасаа байж байдаг.

Тийм учраас бид нарын хэлэлцээд л хүрсэн ойлголцсон хэмжээндээ л оруулж ирж байгаа нь энэ. Нэмээд хэлэхэд бол хэлэлцүүлгийн явцад эцсийн дүндээ Улсын Их Хурал энийг шийднэ. Хэлэлцүүлгийн явцад энэ асуудлуудаа дэвшүүлээд, шийдүүлээд явах бүрэн боломж байгаа. Гишүүн болгонд байгаа, нам болгонд байгаа, намын бүлэг болгонд байгаа яг энэ асуудлууд дээр бол. Ингээд явчхаж байна.

38, 38-тай холбоотой бол одоо та хэд дэх хүн нь болов уу, 5, 6 дахь хүн нь асууж байх шиг байна. Бүгдээрэнгийнх нь асуулт дээр нь давтагдаад явж байна.

Тэгээд түрүүн Их Хурлын дарга ч бас байраа, байр сууриа бас асуултаараа хариулаад илэрхийлж байна лээ гэж ойлгосон. Ингээд орон нутгийг, газар нутаг төлөөлөх шаардлага, олон зүйлийг харгалзаж байгаад хэлэлцүүлгийн явцад энэ талын саналууд гарвал тэгээд ийм олон гишүүдээс ийм асуулт гарч байгаа бол энэ ерөнхийдөө бүгдийнх нь толгойд байгаа, шийдэх ямар нэгэн хувилбартай сууж байна гэсэн үг байх л даа. Тэгээд ингээд шийдэгдээд явах ийм боломжууд нь бол байгаа гэж харж байна. Нэмэх үү, Дэлгэрнаран дарга СЕХ-ны дарга, 3 номер. Асуулт.

П.Дэлгэрнаран: Та бүхний. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ хуулийн өргөн баригдсан хуулийн төслийн 37 дугаар зүйлээс эхлээд сонгуулийн зардалтай асуудлууд хөндөгдөөд ингээд явж байгаа. Тэгэхээр урьд нь 20 онд хэрэглэсэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар тэр зардалтай холбоотой хэмжээ 2-ыг харьцуулж бид нар бас энэ хуулийн төсөлтэй, одоо явж байгаа хуулийн төслийг харьцуулж тооцоолол хийж үзсэн. Энэ дээр хэр зэрэг хэмжээний зардал хэмнэгдэх нь вэ гэж энэ шинээр өргөн баригдсан хуулийн төслөөр бол. Тэгэхээр бид нарт бол энд хэд хэдэн зардлууд бол нэлээн хувь нэр дэвшигчээс гардаг зардлууд дотор их өндөр байр суурь эзэлдэг зардлууд байгаа.

Тэр ухуулгын самбарын зардал, хэвлэмэл хуудасны зардал, тээврийн хэрэгслийн зардал, ухуулагчийн зардал гээд ингээд энэ зардлууд их байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бол энэ шинэ хуулийн төслөөр бол 30-70 хувь багасгасан. Овор хэмжээ, гарах зардал энэ зүйлүүдийг бол тоо хэмжээг нь хүртэл ингээж заримыг нь хязгаарлаж өгсөн байгаа.

Ухуулагчтай холбоотой юм бол урьд нь бол ингээд яг ингээж хөлсөөр ажиллахаар ийм ойлгогдохоор ингээж

байсан бол энэ хуулиар бол юу тодотгож өгч байгаа вэ гэхээр ухуулагч бол сайн дурын үндсэн дээр ажиллана. Хэрэв нэр дэвшигч өөрөө тэр хүнд ажлын хөлс төлье гэвэл тэр нь бас дээд хязгаартай. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээс илүүгүй байхаар ингэж төсөлд оруулж авчирч байгаа. Тэгэхээр бол ерөнхийдөө нийтдээ энэ бүлэг зардал дотор ингээд үзэхээр нэр дэвшигчээс гарч байгаа зардал бол 50 орчим хувиар хямдарч байна гэсэн энэ шинэ хуулийн төслөөр бол урдах хуулиасаа хуулийн заалтуудаасаа бол ингээд гарах зардал нь 50 орчим хувиар өнгөрч байна гэсэн ийм тооцоо байгаа.

Тэгээд яах вэ энэ дээр бол нэг л тоо нэмэгдэж байгаа. Сонгууль маань бол энэ төслөөр бол хосолмол хэлбэрээр явах учраас пропорциональ, мажоритар. Тэгээд пропорциональ талд байгаа намын зардал, намын ухуулагчийн тоо 2 бол өсөхөөр байгаа. Тэгээд намын ухуулагчийн тоо бол 100 байсныг 500 гэсэн хэлбэрээр энэ төсөл дээр явж байгаа. Энэ тоо бол 1 л ийм тоо нэмэгдэж байгаа.

Гэхдээ одоо бол мөнгөний ханшитай холбогдуулаад ер нь юмны үнэ ханшитай холбогдуулаад урьд нь хувь хүнээс өгч байсан хандивын тоо бол 3 сая гэж байсан бол энэ хуулиар 5 сая болгож өсгөсөн. Ийм зардлуудын тооцоо мөнгө төгрөгийн тооцоо явж байгаа.

Н.Энхболд: Тэгэхээр товчхон зүгээр би бас түрүүн асууж байсан тэгвэл тийм байна. Зардлаар нь аваад үзвэл 30-70 хувь хямдарч байгаа юм байна. Дунджаар бодоод үзэхэд нэр дэвшигчээс гарах зар бол 50 орчим хувиар буурна гэсэн ийм ойлголттой явж байх зөв үү? Тийм ээ. Баярлалаа. Батсуурь гишүүн асууя.

Ж.Батсуурь: Баярлалаа. Тэгэхээр би Сонгуулийн хууль, Үндсэн хууль, Төсвийн хууль энэ тэрийг бол нийгмийн зөвшилцөл байх ёстой гэж ингэж хардаг. Тэгээд зарим хууль санаачлагч нарын

хэлээд байгаа шиг энэ улс төрийн намууд бүгдээрээ зөвшилцөөд ороод ирсэн зүйл бол огт байхгүй. Жишээлэх юм бол одоо гудамжинд байгаа намуудын дарга нар хэзээ ч, хаана ч хэлэлцүүлэг хийж байгааг бид нар хараагүй. Хэдэн гишүүнтэй нь ч мэдэхгүй. Зөвхөн өөрөө орж парламентад сууж суухын төлөө хаана ч юм, хэзээ ч юм нэг гарын үсэг зурсан ийм л үйл явдал байгаа. Би Ардын намыг бол мэдэхгүй байна. Жишээлэх юм бол АН, Ардын нам 2 бол Монгол Улсын хэмжээнд өрхийн хэмжээнд бүтэцтэй нам. Тэгэхээр АН-ын гишүүдийн хэмжээнд ч тэр, дунд шат, анхан шат, тэр бүлэг дээр ч яригдаагүй зүйл зөвшилцлийн хэмжээнд орж ирж байна гэж ийм зүйл ярьдаг бол буруу гэж ингэж ойлгож байгаа.

Дээр нь би Монгол Улсын тусгаар тогтнол бол би энэ Төрийн ордонд байдаг гэж ойлгодоггүй. Монгол Улсын бүх нутаг дэвсгэр дээр, тэр хил хязгаарт байгаа хүмүүсийн амь амьдралтай холбоотой асуудал. Тэгэхээр Монгол Улсыг сайхан хөгжүүлнэ гэхэд бол одоогийн байдлаар 52 тэрэг нь орон нутагт байгаа, 24 тэрэг нь л аймагт Улаанбаатар хотод байдаг. Тэгээд энэ бүгдийг багтаасан хуулийг хэлэлцэхэд бол ийм байдлаар салхилж, шуургалж бол би явж болохгүй л гэж ингэж хардаг. Нөхцөл байдал бол тодорхой болчихсон байна л даа. Бүхэл бүтэн ийм том Байнгын хороон дээр ер нь бүгдээрээ л шуураад явчих шинжтэй юм байна.

Тэгэхээр би бол ингэж бодож болохгүй гэж бодож байгаа юм. Жор үзсэн ламаас зовлон үзсэн чавганц гэж. Жор үзсэн хүмүүс чинь 8 удаагийн сонгуулийг явуулаад өнөөгийн ийм түвшинд л авчирсан. Үнэхээр зовлон үзсэн хүмүүсийн тэр хүсэл эрмэлзлийг бий болгосон Сонгуулийн хуулийг батлах нь л бид бүхний үүрэг гэж ингэж харж байгаа юм. Би пропорционалийг бага хэмжээнд орж ирэх нь бол зүйтэй байх. Пропорциональ үнэхээр 50 хувилаад ороод ирэх юм бол нөгөө намын доторх авлигал,

албан тушаал, нэг хэсэг хүмүүсийн дарангуйлал шууд л үүснэ шүү дээ. Энхийг чинь бид нар өөрсдөө туршсан шүү дээ. Пропорциональ сайн байна гээд бүх хүмүүсийн амнаас ярьж байна. Сайн мууг нь ч мэдэхгүй хэдэн судлаач нарт юу өгөөд захиалга өгөөд бүх хүн мэдсэн ч, мэдээгүй ч зарим нь сонгууль гэдгээ ч мэдэхгүй хүмүүс пропорциональ сайн гэж ярьж байгаа байхгүй юу.

Өнөөдөр 2012-оос 16 онд энэ холимог системийг үзсэн. Тэр гулсдагийг чинь үзсэн. Миний хувьд тэгэх гээд 8 сонгуулийн 7-д нь орж бүх системийг үзсэн. Тэгээд 12-16 онд сайн байсан нь хаана байна вэ? Бүх хүмүүс Засгийн газарт орж ирсэн. Саллаа л гэсэн, нийллээ л гэсэн, үр дүн гараагүй. Өнөөдөр тэр холимог системийн орж ирсэн орж ирж Их Хурлын парламентад сууж байсан хүмүүсээс 20 онд нэг нь ч байхгүй л байна шүү дээ. Тэгэхээр хүмүүсийн хүсэн хүлээж байгаа зүйл пропорциональ элементээр дамжиж Монголын төрд орж ирдэггүй гэдэг нь өөрөө нотлогдчихоод байхад зөрүүлээд пропорциональ системийг ингэж ихээр нь оруулж ирж зүтгүүлэх нь бол би бүтэхгүй асуудал гэж ингэж бодож байгаа юм. Бүтэхгүй асуудал.

Тэгээд ч нийгмийн зөвшилцөл байх ёстой Сонгуулийн хууль бол. Тийм учраас намыг хүсэхгүй 60, 70 хувь байгаа шүү дээ. Тэрийг 26 намаар 30 хэдэн нам гэсэн далайлтаар хэдэн ч гишүүнтэй юм, хэдэн ч хүнтэй юм, дарга нь хэн ч юм, хэдэн удаа ч солигддог юм ийм хүмүүсийн гарын үсгээр энэ Сонгуулийн хуульд өөрчлөлт орох нь бол явц муутай. Тийм учраас би энэ төслийг, ер нь явж, явж яг 38, 38-аараа батлахгүй нь тодорхой шүү дээ. Энэ бол заль байгаа шүү дээ. 50, 50 гэж орж ирээд парламентын тоо руу л орох гэж байгаа юм.

Өнөөдөр 1 гишүүний тоо, парламентын тоо, гишүүдийн тоо нэмэгдэх юм бол улам л чанаргүй болно.

Жишээлбэл бид нар асуулт асууя гээд 20 гишүүн саналаа өгөх гээд 5, 5 минут, 140 минут байдаг. 152 болбол яах юм нэгхэн асуулт асуухын тулд 2 цаг 40 минут хэрэгтэй байна шүү дээ. Зөвхөн.../минут дуусав/

Н.Энхболд: Бараг асуултгүй байр сууриар юу гэлээ? 1 минутаа авчих, асуултаа тавьчих. Батсуурь гишүүнд минутыг нь нэмээд өгчихье.

Ж.Батсуурь: Тэгэхээр гишүүдийн тоо нэмэгдсэнээр бол улам л чанар багасна. Өнөөдөр бид нар 76 дотроо 1 Байнгын хороонд асуухад 20 удаа хүн асуухад л ингээд л 2 цаг 40 минут болдог. Ганцхан асуудал дээр шүү дээ, зарчмын зөрүүтэй асуудал. 150 хэд болох юм уу, 100 гаруй болоод ирэх юм бол 1 гишүүн ер нь асууж чадах уу, үгүй юу? Нөгөө байнд орох уу, үгүй юу гэдэг шиг ийм зүйлүүд болно. Тэгээд би түрүүнд бол маш олон асуулт асуусан. Улс төрийн намын тухай хууль, нийгмийн зөвшилцлийн асуудал. Энэ намыг хүсэхгүй 60, 70 хувийн энэ пропорционалийн ард бол орж ирж чадахгүй энэ тэр гээд ийм олон асууж байгаа. Тэгээд би хариулт сонсчихоод харилцан л санаагаа ярьмаар байна л даа.

Н.Энхболд: Түрүүн Доржханд гишүүн бас хэлж байсан ажлын хэсгийн гишүүний хувьд. Би ч бас хэлж байгаа. Олон удаагийн ярилцлага болсон. Олон удаа ялангуяа манай намаас зохион байгуулж, улс төрийн тогтолцоо ямар байх вэ, сонгуулийн тогтолцоо ямар байх вэ? Зөвхөн намын дарга нартай биш, зөвхөн парламентад суудалтай намын даргатай биш, намуудтай биш, эрдэмтэд судлаачид, бүр цаашаа яривал сүүлийн 3, 4 Улсын Их Хурал дамжигдаж ярьж ирсэн энэ төрийн тогтолцоотой холбоотой, хариуцлагатай холбоотой, үүрэгтэй холбоотой эрх, үүргийн тэнцэл, хяналтын тухай холбоотой 2 удаа явсан санал асуулгууд байна. Зөвшилцөх санал асуулга. Энэ бүх юмнуудын дүнг нэгтгэж байж гаргасан хууль гэж би өөрөө

хуулийн төсөл гэж би бол хувьдаа ойлгож байгаа. Энэний ихэнхэд нь би бас оролцож явсан.

Тэрнээс гадуур тэрэнд яригдаагүй асуудлууд нэг ч ороогүй. Харин яригдаж байсан олон зүйлүүдээс бол гадуур нь үлдсэн юмнууд бол байгаа байх. Тэгээд би зүгээр ингэж бодож байна л даа. Би энэ хуулиар бол 800 хүн нэгдээд нам байгуулна гээд заачихсан. Тэр хуулийнхаа дагуу иргэд эвлэлдэн нэгдэх эрхээ эдлээд, намууд байгуулчихсан. Тэрийг нь бүртгээд авчихсан. Албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж болно та нар. Та нар бол нам мөн шүү гээд хэлчихсэн. Ер нь ихэнх намын дүрэм дотор нь бол тэр тухайн намын дарга юм уу, тэр удирдлага нь намаа төлөөлөөд асуудал шийдэхэд оролцдог ийм байдаг юм байна лээ. Манайх лав тийм. Танайх бас тийм байх АН. Тэр улсууд нь ирээд л орсон. Ярьсан зүйлүүдийнхээ л дагуу, тэр ярьсан зүйлүүдийнх нь дагуу би бүх нам орсон гэж ярьж байгаа юм. Түүнээс энийг дотор нь ялгаад, энэ нь жижиг, тэр нь том, энэ нь гишүүнтэй, энэ нь гишүүнгүй гэж хандаж ялангуяа ийм асуудалд бол тэгж хандсангүй би.

Бид нар тэр олон хэлэлцүүлгүүдийн дунд л тэр дарга нь ямар эрх ямар намынхаа дүрмээр эрхээ авсан юм төлөөлөлдөө эрхээ авсан юм. Эрхээ авчхаад тэр эрхийнхээ дагуу илэрхийлж байгаа байр сууриндаа яаж хүрсэн юм тэр нь бол тэр намын дотоод асуудал. Бид нарыг хуулийн дагуу төлөөлж байгаа хүмүүстэй нь харьцсаныгаа л намуудын удирдлагын хүрээнд ярьсан, ойлголцсон зүйл гэж ярьж байгаа шүү Батсуурь гишүүнээ.

Яах вэ би бас хариулчихъя. Таны саналууд бол асуулт маягтай тавьсан саналууд гэж бодож байна. Ганц нэг зүйлд нь. Олон болохоор чанар муудах тухай асуудал ярьж байна. Парламент ажиллаж чадахгүй болох тухай асуудал ярьж байна. Манайх бол 30 хэдэн жил

болж байгаа шинэ парламент. 200, хэдэн зуун зуу, хэдэн зуун зуу хэдэн жил болчихсон парламентууд 200, 300, 400 хүнтэй парламентууд үйл ажиллагаагаа явуулаад байж чаддаг л юм байна лээ. Дэгээрээ зохицуулчихдаг юм байна лээ.

Тэгэхээр бид нар тэд нараас нэг их дутаад, хурлаа зохион байгуулж чадахгүй хэмжээнд арай оччихгүй байлгүй дээ. Энэ чинь туршлагауд байна, дэгүүд байна. Яавал хурлаа зохион байгуулалт сайтай, дэгтэй, яг асуудалдаа анхаарлаа хандуулаад, яг ярьж байгаа зүйлүүд яриад явдаг вэ гэдэг тийм том туршлагауд байна шүү дээ. Дээд тал нь 450 хүртэл хүнтэй зүйлүүд байна. Зүйлүүд гэнэ парламентууд, болдог л юм байна лээ. Бид тэд нараас юугаараа дутах вэ. Тэгээд тооны асуудал бол учиргүй тийм парламент ажлаа явуулж чадахгүй хэмжээнд хүргэчих хүчин зүйл биш болов уу л гэж бодож байгаа. Доржханд гишүүн ажлын гишүүний хувьд хэлье. Доржханд гишүүнийх.

Т.Доржханд: Энэ парламентын гишүүдийн тооны хувьд бол би бас нөгөө шинжлэх ухааны үндэслэлтэй маш олон дүгнэлтүүд байгаа юм. Тэгээд бид нар нөгөө нэг шийдвэр гаргахдаа бас нөгөө шинжлэх ухаанаа судлаачдынхаа байр суурийг бас харгалзаж үздэг байх ёстой байх. Тэгээд ямар дүгнэлтүүд байна гээд тэгэхээр ер нь парламент ямар тохиолдолд үр ашигтай явдаг юм бэ гэдэг тоо байгаа юм. Тэр нь нөгөө хүн амын тооноосоо хамаарахгүйгээр тухайн олонлог шийдвэр гарахад хамгийн багадаа 120 байж хуйвалдаан байдаггүй, хулгай байдаггүй, хоорондоо нэгдэж үгсэн хуйвалддаггүй. Энэ бол 1 математикчдын судлаачдын тоо шүү.

Дээшээгээ парламент 800-аас дээшээ болох юм бол зах болчихдог. Өөрөөр хэлэх юм бол тэрэн дээр шийдвэр гардаггүй, үр дүн гардаггүй. Тэгэхээр аливаа улсын парламент хамгийн багадаа 120, дээшээгээ 800. Энэ дотор л байх

ёстой гэдэг тоо байгаа юм. Тэгэхээр нөгөө Хятад чинь 1.5 тэрбум хүнтэй байхад 700-гаад хүн болоод байна. Гэтэл энэ Монгол гуравхан сая хүнтэй байж 76 хүнтэй арай ч дээ гэдэг энэ тооцоолол чинь шинжлэх ухааны үндэслэлгүй юм нэг.

2-т нь би нэг ямар ч байсан олон улсын 100-гаад улсаар явж, 50-иад улсад нь бас очиж зөвлөгөө өгч байсан мэргэжилтэн хүн. Ази Номхон далайн орнууд гээд 18 улс байдаг юм, 18 улс байдаг юм. Тувалу ч гэдэг юм уу, Майкронезия ч гэдэг юм уу эд нар бүгдээрээ тусгаар улс НҮБ-ын гишүүн улсууд юм. Гэтэл нэг улс нь тухайлбал 30000 хүнтэй байдаг юм, 30000 хүнтэй шүү тусгаар улс. Тэнд юу байдаг юм гэхээр Засгийн газарт нь байдаг юм, бүх бүтцүүд нь байдаг юм. Сангийн яам нь байдаг, татвар нь байдаг, бүх яамнууд нь байдаг. Гучхан мянган хүнтэй байж яахаараа ийм бүтэц байдаг юм бэ гэдэг юм байдаггүй байхгүй юу. Тэр чинь хүний тооноос хамаардаггүй байхгүй юу.

Тэгэхээр дэлхий дээр Монголоос цөөхөн хүн амтай маш олон улс байдаг. Тэгсэн мөртөө Монголоос илүү парламентын гишүүдтэй л байдаг. Хамгийн бага гишүүдтэй улсууд тухайлбал бид нарын энэ 1 хамгийн их яриад байдаг Норвегийн баялгийн сан хэрэгтэй. Норвегийн хөгжлийн загвар ямар гоё юм бэ төрсөн хүүхэд нь сая долларын ийм хадгаламжтай төрөөд байна шүү дээ гээд л бүгдээрээ Норвегийн загвараар яриад байгаа шүү дээ. Гэтэл Норвегийн хүн ам чинь дөрөв аравны хэдэн сая хүн амтай шүү дээ. Гэтэл парламентын гишүүд нь одоо буураад 169 болчихоод байгаа жишээ нь. Тэгээд Европын парламентын орнууд бол бүгдээрээ л ийм загвараар 120-оос дээшээгээ л яваад байгаа.

Тэгээд үүгээрээ юу хэлж байна вэ гээд тэгэхээр шийдвэр гаргах процесс үр дүн талаасаа бол шинжлэх ухаанаар судлаачдын байр суурь болохоор 150 дор

хаяж байх ёстой гэдэг ийм тоо. Зөвхөн нөгөөд нэг хүн амын өсөлт төлөөлөх чадвараас гадна яг өнөөдрийн Монгол дээр бий болж байгаа тэр судалгааны үр дүнгүүд бол ингэж мөргөөд байгаа юм шүү. Маш олон биеэ даасан судалгааны байгууллагууд, олон улсын байгууллагуудын бас зөвлөх экспертүүд хүртэл яг л энэ дээр ингээд санал нэгдээд байгаа. Тэгээд тийм болохоороо бид нар энэ Улсын Их Хурлын гишүүдийн тоог өсгөх асуудлыг бол зайлиггүй ярих ёстой юм. Ярих ёстой юм.

Харин өнөөдөр бол Сонгуулийн тухай хуульд бол энэ зарчмаа оруулж ирж байгаа. Цаашаа бол бид нар энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг зайлиггүй ярих ёстой. Өнөөдөр тухайлбал би ХҮН намын залуучуудтай цуг бүх 21 аймгаараа явж байгаа. Сүхбаатар аймгаар ороод явсан, иргэдтэй бас уулзсан. Бодит байдлуудыг шинжлэх ухааны үндэслэлүүдийг ярихад дэмжиж байлаа шүү. Иргэд дэмжиж байна лээ шүү. Мэдээллийг нь өгөхгүй тохиолдолд эсэргүүцэж байна, мэдээллийг нь бодитой өгсөн тохиолдолд дэмжиж байгаа шүү гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Н.Энхболд: Батсуурь гишүүн би одоо танд өглөө. Би таны түрүүчийн нөгөө пропорциональ хэсэг нь арай том биш үү гэж байгаа асуулт байна. Магадгүй том байж магадгүй. Тэгэхдээ энийг хэдүүлээ ярьж байгаад шийдье тийм ээ. Хүн болгон өөрийн байр суурьтай байгаа, өөрийн тайлбарлах өнцөгтэй байгаа, ярьж байгаад л шийдье. Бид нар яаж энийг сонгосон юм бэ гэхээр нөгөө хөгжлийн том асуудлууд ерөөсөө шийдэгдэж чадахгүй байсаар байгаад өнөөдөр бид нар эдийн засгийн хараат байдал маань улам л гүнзгийрээд байна шүү дээ. Энэнээс 1 гарах арга нь том бодлогуудаа ер нь шийдэх асуудал дээрээ илүү хүч хаяж, илүү анхаарал тавьж байхгүй бол болохгүй нь гээд, улсын бодлогын ярих үед төсөв ярья гэж бодъё.

Тэр үед тэн хагас нь ядаж том бодлого дээрээ илүү анхаардаг, яг тэн хагас нь орон нутаг дээрээ анхаардаг. Ингээд ярьж байгаад алтан дунджаа олоод, зөв хөгжлийн асуудлуудаа шийдээд явъя гэдэг ийм л байр суурийн үүднээс хандсан.

Би яагаад магадгүй 50, 50 гэдэг нь их байж магадгүй юм гэж байгаа юм гэхээр жишээ нь танай намын зүгээс тийм санал гарсан 28, 48 гээд. Гэтэл үгүй ч байж магадгүй. Яагаад тэгж хэлж байна гэхээр 100 хувь парламент нь пропорционалиар сонгодог улс орнууд байна. Тэр улс орнуудад орон нутаг нь ерөөсөө хаягдаад манайх ч нөхцөл байдал өөр, өөр л дөө. Гэхдээ том утгаар нь аваад үзвэл зөвхөн том асуудлаа бодно. Тосгон хөдөө бусад юмаа бодохгүй гэдэг юм явдаггүй л юм байна лээ. Тэгэхээр энэ бол цэвэр сонголтын асуудал, цэвэр улс төрийн шийдлийн асуудал, цэвэр хувь хүний байр суурийн асуудал. Хэдүүлээ ярьж байгаад л шийдье. Зарчмууд дээрээ уг нь ойлголцоод аваад, хэлэлцээд гээд эхэлчихвэл бүх асуудлууд нээлттэй байгаа нь миний хэлээд байгаа энд л байгаа юм. Тийм. Батсуурь гишүүний утсыг юу микрофоныг өгье.

Ж.Батсуурь: 4 минут өгчхөж болохгүй юу? Ганц асуулт асуугаад ажлын хэсэг гээд ингээд 10, 20 минут пулементлуулчихаар чинь ингээд асуудал чинь яригдахгүй байна шүү дээ 2 талаасаа.

Н.Энхболд: Дэгээрээ л явж байна шүү дээ гишүүнээ.

Ж.Батсуурь: Үгүй ээ одоо тэгээд л харин дэгээрээ гээд л ингээд мэтгэлцээн үүсэхгүй.

Н.Энхболд: Дэгээ санаачлаад өөрчилж болно шүү, өөр асуудлыг өөр юмаар хэрэгжүүлдэг юм.

Ж.Батсуурь: Тэгэхээр олон улс орноор явсан л гэх юм. Тэр улс орнуудад

ийм том газартай, ийм цөөхөн хүн амтай газар байхгүй. Хуйвалдаан гэж ярьж байна. Хуйвалдаан чинь бол пропорционалийн ард л орж ирнэ. Яах вэ пропорционалийн ард дандаа алт мөнгөжүү хүн орж ирдэг гэвэл бол 12-16 оны пропорционалиар орж ирсэн хүмүүс 20 онд нэг ч байхгүй байна гэх мэтчилний ингээд юмнууд ярьж байна. Тэгэхээр асуудлыг бол би зүгээр нэг би дийлэхгүй л юм шиг байна л даа. Гэхдээ би зүгээр протоколд үлдэж байгаа юм. Яагаад ийм олон хүмүүс, олон талаасаа ярилцахгүй ингээд бүгдээрээ шуураад байгаа юм бэ л гэсэн асуудал байж байгаа юм. Тэглээ гээд сайн сайхан зүйлийг хийж байгаа гэж бодож байгаа бол эндүүрлээ, эндүүрэл. Яагаад вэ гэхээр асуудал.../минут дуусав/

Н.Энхболд: Дэгээрээ л явж байна Батсуурь гишүүнээ. Баатарбилиг гишүүний микрофоныг өгье.

Ё.Баатарбилэг: Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амрыг айлтгая. 2, 3 зүйл тодруулна. Энэ яах вэ зүгээр СЕХ-ныхноос ганц 2 асуулт байгаа. СЕХ одоогийн мөрдөгдөж байгаа хуулиар жишээлэхэд ингээд ирэх жил сонгууль явуулах боломж байгаа юу? Яагаад гэвэл бид нар 19 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулаад Сонгуулийн хуулиа тэрийг дагуулж батлаад сонгуулиуд явсан. Нэгдүгээрт одоогийнхоор боломж байгаа юу?

Хоёрдугаарт сонгуулийн одоо өргөн барьж Сонгуулийн хуулийг өргөн барьсан хүмүүсийн хувьд одоогийн Сонгуулийн хууль яг юу нь болохгүй болчихоод өөрчлөх гээд байгаа вэ гэдэг дээр жаахан нөгөө та бүхний тайлбарлаад байгаа тайлбар дээр учир дутагдал байна л даа. 38, 38 буюу холимог тогтолцоо оруулж ирж байгаа юм. Тэгэхээр энэ дотор АН бас ийм холимог тогтолцоо оруулж ирж байна. 12 онд сонгуулийнхаа хуулийг холимог болгож оруулж ирээд, 16 оны хавар өөрчлөхдөө энэ холимог ерөөсөө манайд болохгүй юм байна гээд

холимгийг больсон шүү дээ. Ерөөсөө мажоритарар явах нь зүйтэй юм байна гээд. Тэгэхээр тэр 16 онд сонгуульд Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулсан цаг хугацаанаас өнөөдрийн цаг хугацаа яг юугаараа өөр болчихоод улс төр, эдийн засаг, нийгмийн орчин нөхцөл өөр болчихоод буцаад энэ нь боломжтой, ерөөсөө холимог л байхгүй бол болохгүй болчихоод байгаа юм бэ гэдэг дээр хууль санаачлагчид 1 тодорхой хариулт өгөөч. Энэ дээр ерөөсөө хариулт өгөхгүй байна. 4 жилийн өмнөхөөс 16 оныхоос өнөөдөр юу нь өөр болчихоод байгаа юм бэ? 16 онд энэ холимог болохгүй байна гээд мажоритар руу орсон шүү дээ. Энэ дээр 1 хариулт өгчхөөрэй.

Цэцийн дүгнэлт чинь 2 янзын юм байгаад байгаа юм, 1 нь зөвшөөрөөд, 1 нь зөвшөөрөөгүй. Цэц бол улс төрийн тоглоом болгоод байна шүү дээ. Дараагийнх нь энэ жагсаалт жагсаалтын чинь асуудал, асуудалтай холбоотой нөгөө гулсах асуудал чинь энэ хуульд чинь байхгүй байна шүү дээ. Жишээлэхэд одоо ингээд холимог тогтолцоо орж ирлээ, жагсаалтаар намын квотоор сонгогдлоо, орон гарсан, нөхөн сонгууль болох тохиолдолд яаж гулсах юм энэ тэр гэдэг, би тийм юм энэ юун дотор байхгүй байх юм, байна уу, үгүй юу энэ нэмэлт, өөрчлөлтөд энэ орж ирж байгаа хууль? Энэ чинь хуульд орохгүй бол СЕХ журмаар батална гэж ингэж явж болохгүй асуудал. Энэ чинь хамгийн чухал асуудал шүү дээ.

Жишээлэхэд жагсаалтаар намынхаа квотоор юм уу орсон нөхцөлд өмнө нь орсон нөхөр ямар нэгэн шалтгаанаар чөлөөлөгдлөө гэхэд дараагийн нөхөр яаж орох вэ энэ тэр гэдэг чинь хуульд нь байхгүй байна шүү дээ. Энийг яаж зохицуулах гэж байгаа юм 1 ийм асуудал.

Дараагийнх нь 1 асуудал. Энэ дээр тодруулга өгчхөөрэй. Дараагийнх нь болохоор яах вэ зүгээр хувь гэж яриад

байна лээ. Намын болон нэр дэвшигчийн нэрээр хувь цуглараад нам дээр тэрийгээ эрэмбэлнэ гэж байгаа юм. Магадгүй хамгийн эхний 5-аар эрэмбэлэгдсэн нэр дэвшигч хувь нэрээрээ маш бага хувь авсан мөртөө жагсаалтаараа их өндрөөр эрэмбэлэгдчихсэн, жагсаалтаар нэлээн хойгуур эрэмбэлэгдсэн мөртөө хувь улс төрчийнхөө рейтингээр маш өндөр хувь авчихсан байвал тэр хойгуур байгаа өндөр рейтингтэй улс төрч чинь хохирох юм биш үү? Тэгээд нөгөө сонгогдож чадахгүй. Энэ яг энэ жагсаалтад чинь нэг ийм шударга биш юм гарах гээд байгаа юм биш үү?

Нөгөө нэг юунд ойрхон дарга нартай ойрхон жагсаалтаар яаж ийж байгаад нэг урдуур яачихдаг нэг долоосон гарууд урдуур орчихоод, тэгээд ингээд сонгогдох юм руу л орчих гээд байна шүү дээ. Энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ гээд. Нэг ийм 3 тодорхой асуудал, СЕХ-ноос одоогийн хуулиараа явах боломж байна уу, үгүй юу гэдгийг нэг асуучихъя. Тэгээд тодруулна.

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүн хариулъя, дараа нь СЕХ. Яагаад дөрөвхөн жил болоод өөрчилчхөв, яагаад заавал холимог систем чинь давуу тал нь юу байгаад байгаа юм бэ гээд. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Үндсэн хуулийн цэц 22 оны 6 сарын 22-ны өдөр 01 дүгээр тоот тогтоол гэж гаргасан юм. Тогтоол. Тогтоол гэдэг бол эцсийн шийдвэр шүү дээ. Энэ тогтоолыг гаргахдаа өмнө нь Үндсэн хуулийн цэцээс гаргаж байсан бүх шийдвэрүүдийг нэгтгээд, заримыг нь хүчингүй болгоод ингээд шийдвэрээ гаргасан юм. Өөрөөр хэлэх юм бол сая Баатарбилэг гишүүн хэлээд байна. 16 онд энэ гулсдагийг хориглосон шийдвэр гарсан байсан тэрийгээ хүчингүй болгосон. Дараа нь 12 онд уучлаарай. 16 онд шууд гэдгийг тайлбарлаад пропорциональ

тогтолцоо болохгүй байна гээд шийдвэр гаргасан байсан. Тэрийгээ хүчингүй болгосон. Эдгээр шийдвэрүүдээ бүгдийг нь нэгтгээд тэгээд Үндсэн хуулийн цэц б сарын 22-нд шийдвэр гаргасан юм. Энэ Үндсэн хуулийн шийдвэрээр холимог тогтолцоо пропорциональ тогтолцоо орж ирэх эрх зүйн орчныг Үндсэн хуулийн цэц нээчихсэн юм. Тийм учраас хууль санаачлагчид өнөөдөр оруулж ирэхдээ нэгдүгээрт энэ холимог тогтолцоог хууль, эрх зүйн хүрээндээ болно гэж үзэж оруулж ирж байгаа юм.

Хоёр дахь нь манай улс төрийн намуудаас тавьдаг нэг чухал санал байдаг. Байнга ярьдаг. Пропорциональ тогтолцоо бол санал гээгддэггүй тогтолцоо. Сонгогчдын санал гээгддэггүй тогтолцоо. Энэ санал гээгддэггүй улс төрийн олон нам зөвшилцөж үйл ажиллагаа явуулдаг энэ дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага руу явах шаардлага байна гэж ингэж үзээд 2-т нь бол энэ холимог тогтолцоог оруулж ирж байгаа юм.

Гуравдугаарт нь тойргийн эрх ашиг улс орны эрх ашгаас илүү байж болохгүй юм гэдэг агуулгаар нь 50, 50 хувь гэдэг тоог оруулж ирж байгаа юм. Пропорциональ тогтолцоо бол 1 сайн тал нь улс орны томоохон асуудлуудад түлхүү анхаарах бололцоо боломжийг олгодог тогтолцоо байгаа юм. Тийм учраас энэ 2-ыг тэнцүү хэмжээнд байх ёстой гэдэг ийм 3 үндэслэлээр нь холимог тогтолцоог оруулж ирж байгаа юм. Энэ холимог тогтолцоо оруулж байгаатай холбоотой сая Баатарбилиг гишүүн 2-т нь гулсах тухай асууж байна. Энэ нь бид нарын санаачилж оруулж байсан хуульд гулсахгүй. Өөрөөр хэлбэл 1 нэр дэвшигч тойрог болон намын жагсаалтад зэрэг нэр дэвшихгүй гэдэг ийм байдалтай байгаа.

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Баатарбилэг гишүүний асуултад нэмж хариулъя. Баатарбилэг ийм байгаа. Жагсаалтаар нэр намын жагсаалтаар нэр дэвшиж байгаа хүмүүсийн тухайд бол орон гарах нь чөлөөтэй. Дараагийн хүн нь урагшлаад л, ингээд л шилжээд л яваад байна. Байгаа, байгаа, байгаа.

Харин тойргоос нэр дэвшсэн хүн дээр бол нөхөн сонгууль байгаа. 74 дээр байна уу, 75 дугаар зүйл дээр байгаа. Тэрэн дээр юу гэж байна вэ гэхээр ингээд биччихсэн байгаа. Тойргоос нэр дэвшсэн хүн бол орон гарсан тохиолдолд нөхөн сонгууль явагдана. Жагсаалтаар нэр дэвшсэн хүн дууссан тохиолдолд орон гаран явна гэж байгаа юм. Дуусаагүй тохиолдолд дараагийн хүн нь шилжиж явна гэдэг тийм зүйл 74, 75 дээр байж байгаа.

Н.Энхболд: Эрдэнэбатаа тэрийг яг уншаад өгчхөөрэй. Саяын тэр заалт Бат-Эрдэнэ. СЕХ 3 дугаар микрофон өгөөрэй. Би зүгээр ганцхан юм Баатарбилэг гишүүнээ 16 онд бол ёстой Сонгуулийн хууль өөрчлөхөд үнэндээ хэлэлцүүлэг элдэв юм болоогүй шүү. Сайн, мууг нь ч яриагүй. Гэнэтхэн сарын өмнө байна уу, хэдхэн хоногийн өмнө тэр үед олонх барьж байсан нам маань өөрчилнө гээд л тэгээд л явчихсан. Үнэндээ энэ удаагийнх шиг ийм олон талаас нь ярьсан, хэлэлцсэн, сайн, муугаараа талцсан тэрнийгээ аргумент гаргаж хэлэлцсэн юм ерөөсөө болоогүй. Тэр жоохон тийм харамсалтай л юм болсон юм байгаа юм. Бат-Эрдэнэ эхлээд чи тэр яг саяын Тогтохсүрэн даргын хэлсэн 2 заалтыг, хамт хариулчих.

П.Дэлгэрнаран: Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. 20 оны Улсын Их Хурлын Сонгуулийн хууль бол одоо хүчин төгөлдөр байгаа. Энэ өргөн баригдсан төслүүд батлагдаж, сонгуулийн Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн хуульд өөрчлөлт оруулбал энэ өөрчлөлт орсон хууль хүчин төгөлдөр

болоод энэ шинэ хууль болоод хэрэглэгдээд явна. Одоогоор бол энэ хууль батлагдаагүй төсөл өргөн баригдсан төсөл батлагдаагүй үед бол 20 оны хууль хүчин төгөлдөр хэвээрээ.

Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд бол Улсын Их Хурлын сонгуульд 1 жилийн сонгууль явахаас өмнө 1 жилийн дотор өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн ийм заалт байгаа. Тийм учраас бол хууль тогтоох эрх бүхий хүмүүс маань жилээсээ өмнө өөрчлөлтийг өргөн бариад орж өөрчлөлт оруулах гэж байна л гэж ойлгож байна.

Тийм учраас хэрэв энэ өөрчлөлтийг өргөн барихгүй юм уу эсвэл батлахгүй бол 20 оны Сонгуулийн хууль бол хүчин төгөлдөр үргэлжлээд явна л гэж ойлгох юм.

Н.Энхболд: Тийм, тэрийг асуусан.

П.Дэлгэрнаран: Тэрийг асуусан шүү дээ.

Н.Энхболд: Хамгийн эхлээд одоогийн Сонгуулийн хуулиар явах боломж байгаа юу гэсэн. Энэ хууль батлагдахгүй бол одоогийнхоороо явна гэдгээ хэлчихлээ.

П.Дэлгэрнаран: Тийм одоогийнхоороо явах боломжтой.

Н.Энхболд: Бат-Эрдэнэ чи юу хэлчих.

П.Дэлгэрнаран: Боломжтой.

Н.Энхболд: Нөгөө Бат-Эрдэнээ сая тэр нэг юу байна шүү дээ. Доошоо нөгөө жагсаалтын сонгогдсон хүн ямар нэгэн байдлаар бүрэн эрхийн хугацаа нь дуусчихвал дараагийн хүн нь орно гэсэн заалт байгаа шүү дээ тийм ээ. Тэрийгээ орсон төслөөр нь уншаад өгчих тийм. 2 номерын микрофон өгөөрэй.

Д.Бат-Эрдэнэ: Баатарбилэг гишүүний асуултад нэмж хариулъя. Хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудлыг нөхөх зохицуулалт нь хуулийн төслийн 77 дугаар зүйл дээр тодорхой зохицуулалт байж байгаа. Яг энэ дээр бол 77.2 дахь хэсэг дээр энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.1-д заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж сонгогдсон Их Хурлын гишүүний орон гарсан, мөн энэ хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-д заасны дагуу буюу жагсаалтаар сонгогдсон гишүүний орон гарсан бол дараагийн нэр дэвшигчийг Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцох. Жагсаалтад нэр дэвшихийн дэвшсэн гишүүний орон гарах юм бол дараагийн нэр дэвшигч нь сонгогдсонд тооцох тухай зохицуулалтыг хуулийн төсөл дээр тусгасан байгаа.

Н.Энхболд: Баярлалаа. Тийм, ер нь яг одоогийн зохицуулалт нь бол ингээд намууд нь эрэмбэлээд оруулчихна. Тэгсэн санал хураагаад гараад ирсэн чинь доогуур эрэмбэ намаасаа доогуур эрэмбэлэгдсэн хүн магадгүй дээр эрэмбэлсэн хүмүүсээсээ илүү санал аваад гараад ирвэл тэр нь яах вэ гэж байгаа юм. Яах вэ бид нарын төсөл дээр хэрэв би андуураагүй бол намын эрэмбээрээ явна. Намын эрэмбээр яагаад явна гэж ойлгож хийсэн бэ гэхээр аливаа нам хамгийн олон санал авах хүмүүсээ л дээгүүр, их дээгүүр тавьж санал авна гэсэн энэ эрүүл саруул логикоор хандаж л асуудалд хандана гэж ингэж оруулсан байгаа.

Магадгүй энэ хэлэлцүүлгийн явцад асуудал хураагаад санал хураалтын дүн гарсны дараа тэрүүгээр нь эрэмбэлнэ энэ тэр гэсэн юм байвал бас хэлэлцэж болохгүй гэх тийм асуудал байхгүй байна. Нээлттэй байгаа. Тийм. Бид нарынхаар бол яг сая миний хэлснээр. Тэгэхдээ намууд өөрснөө эрх биш эрүүл саруул хандаж, эрх биш элдэв асуудалтай тийм нөхдүүдээ дээгүүр жагсаахгүй байлгүй гэдэг л эрүүл саруул ухаанаар хандана л

гээж бодож л хуулиа хийсэн л дээ. Төслөө. Болох уу? Баатарбилэг гишүүний.

Ё.Баатарбилэг: Тэгэхээр яах вэ сонгууль дөхөхөөр сонгуулийн өмнөх жил бас Их Хурлын сонгууль Сонгуулийн хуульд өөрчлөлт ордог гээд бүр 1 тийм ойлголттой болчихлоо л доо бид нар. Тэгээд яг тэр энэ цикл нь ингээд 23 он учраас сонгуулийн хуульд өөрчлөлт орно гээд бүр нийгмээрээ ингээд хүлээн зөвшөөрөгдчихсөн маягтай ийм юу суучихлаа. Тэгэхээр энэ сонгуулийн тогтолцоо нь энэ Сонгуулийн хуулиараа тогтвортой байлгах асуудал дээр бол бид нар өөрсдөө хаана хаанаа анхаарах шаардлага зүйлс зүгээр ургаж байна.

Тэгэхээр энэнээс үндэслээд ер нь бол тэгээд цаашилаад Үндсэн хуулийн асуудал руугаа л орохоос өөр аргагүй болох юм байна шүү дээ. Үндсэн хууль. Түрүүний хэний Доржханд гишүүний ярьсан юун дээр бол би санал нэг байгаа. Хүн амын тоонд харьцуулдаг тийм ойлголт байхгүй. Нэг бүхэл бүтэн улсын парламент гэдэг ойлголтоороо тоо ярихгүй бол, тоо ярьж байгаа гишүүд буруу яриад хүн амын тоонд коэффициентлэж яриад байгаа нь өөрөө буруу болчихоод байгаа шүү дээ. Тэгэх юм бол 200, 300 сая хүнтэй улсын парламент хэд болох юм. Тэгэхээр бүхэл бүтэн улс гэж.../минут дуусав/

Н.Энхболд: Санал хэллээ гэж ойлголоо. Адьшаа гишүүн асууя.

Ш.Адьяа: Өнөөдөр энэ сонгуулийн пропорциональ системийг бол миний хувьд бол зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Энийг бол энэ Сонгуулийн хуульд хийх ёстой. Гэхдээ энэ ТББХ-ны даргаас 1 юм асууя. Энэ чинь Сонгуулийн хууль хэлэлцээд байгаа юм уу бид нар Үндсэн хуулийн өөрчлөлт хэлэлцээд байгаа юм уу? Энэ Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн хүрээнд л хуулиа хэлэлцмээр байна. Ингээд хаа хамаагүй юм хамж шимээд ингээд ярьдаг. Тэгээд

энэ чинь энийг харж байгаа ард иргэд чинь юу гэж ойлгох юм.

Хоёрдугаарт нь би энэ Тогтохсүрэн, Доржханд 2-оос 1 юм хариуцлагатай 1 юм асууя. Хариуцлагатай 1 юм асууя. Өнөөдөр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг ҮХЦ чиглэл өгсөн маягаар удаа дараа мэдэгдэж, сая бүр танилцуулга дээр энэ Ардын намын бүлгийн дарга ийм хариуцлагагүй юм ярьж байна. Энэ хууль тогтоох эрх мэдэл Улсын Их Хуралд байдаг байгаа юу ҮХЦ-д байгаа юу гэдгийг албан ёсоор надад хэлж өгмөөр байна. ҮХЦ гэдэг бол нохойнд барьдаг мод биш. ҮХЦ гэдэг байгууллага бол өөрийн хуультай. Энэ хууль нь Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль тогтоомж Монгол Улсын Үндсэн хуулийн зөрчсөн эсэх асуудлыг л хянаж шийдвэрлэдэг ийм үүрэгтэй, ийм хуультай.

Гэтэл яагаад өнөөдөр энэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэр мэтээр Цэцийн дүгнэлт мэтээр ийм ойлголтыг удаа дараа өгч байгаа юм бэ? Одоо энэ Сонгуулийн хууль дээр ингээж ярьж байна. Албан ёсоор та 2-оос би энэ тайлбар авъя. Яагаад гэвэл өнөөдөр бид ард түмний төлөөлөл. Ингээж ҮХЦ-ийн нэрийг барьж, энэ ярьж байгаа нь энэ ямар зорилго байна вэ? Хүнээр хүний нэрээр юм хийлгэх хийх гээд байгаа юм уу аль эсвэл хууль тогтоох эрх мэдэл ҮХЦ-д очсон юм уу? Та нар бол өнөөдөр Цэцийн нэрийг барихгүйгээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хуулиа өргөн барих эрх чинь нээлттэй байгаа. Гэтэл яагаад өнөөдөр энэ Цэцийн нэр бариад байна вэ. Би энэний хариулт авсны дараа Доржхандаас дахиад асууя.

Н.Энхболд: Хэн нь, Доржханд. Доржханд гишүүн эхлээд хариулчих. Тэгээд дараа нь Тогтохсүрэн. Энэ 2-оос асуух шиг боллоо.

Т.Доржханд: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монгол Улсын ҮХЦ гэдэг бол өнөөдөр Үндсэн хуулийг манаач гэж ойлгох хэрэгтэй. Үндсэн хуулийн шүүх. Тэгээд ҮХЦ-ийн шийдвэр бол маш зөв шийдвэр байсан. 01 дүгээр шийдвэр буюу 2022 оны 6 сарын 28-ны өдөр шүү. Сүүлийн 30 жилийн хугацаанд энэ тогтолцоо чинь 1 бол хүнээ сонгодог юм, шууд сонгодог юм. Үгүй бол пропорциональ болно, үгүй ээ болохгүй, болно, болохгүй, болно, болохгүй гээд. Сүүлдээ 2016 оны сонгуулийн ердөө 1, 2-хон сарын өмнө Цэцэд захиалга өгөөд л болохгүй хүнээ сонгодог юм гээд л ингээд л олж авсан тэр дэвшилттэй зүйлээсээ ухарсан нь бодитой үнэн шүү дээ.

Би 1 зүйл дээр санал нэг байгаа. Ер нь өнөөдрийг хүртэл Цэц бол нөгөө улс төрчдөд үйлчилсэн байдлаар ажилласан гэдэг дээр бол санал нэгтэй байдаг. Гэхдээ энэ 6 сарын 28-ны шийдвэр бол маш чухал шийдвэр гарсан. Энэ дээр бол Цэц бол хараат бусаар зөв шийдвэр гаргасан гэж бодож байгаа. Энэ бол Монгол Улсын парламентыг бэхжүүлэхэд Монгол Улсын ардчилалд хамгийн том хувь нэмэр оруулж байгаа гэж үзэж байгаа. Тэгээд үр дүнд нь Цэцийн их суудлын хуралдаанаар хамгийн эцсийн шийдвэр шүү дээ. Улсын Их Хурал ч өөрчлөлт оруулах боломжгүй шүү дээ. Манай Үндсэн хуулийн зохицуулалт нь өөрөө ийм байгаа юм. ҮХЦ-ийн их суудлын хуралдаанаар энэ 30 жилийн хэрүүл маргаан амбиц мөн хуйвалдаанд эцэслэж цэг тавьсан. Энэ дээр бол манай Одонтуяа гишүүн бид 2 бол идэвхтэй ажилласан байдаг. Энийгээ бол бид нар бол зөв гэж үзэж байгаа. Энэ бол Монгол улсын үе үеийн парламентад маш чухал зүйл.

Хоёр дахь зүйл нь юу вэ гээд тэгэхээр Цэцийн 2 дахь шийдвэр гарсан. 2 дахь шийдвэрийн агуулга нь юу байсан бэ гээд тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдийг төлөөлөх чадварыг нь өсгөх замаар давхар дээлийн асуудлыг шийдэж

болно гэдэг шийдвэр байсан 2 дахь шийдвэр нь. Энэний дагуу мөн ажлын хэсэг гараад Улсын Их Хурал дээр 53, 54 дүгээр тогтоолыг Одонтуяа гишүүн бид нарын зүгээс бас яг энэ Байнгын хороон дээр сууж байж, чуулган дээр ярьж байж энийг бас шахаж батлуулсан нь үнэн. Одоо энийгээ бид нар шаардлагыг нь нэхэж байгаа. Энэ бас мөн Монгол улсын парламентад, парламентын засаглалтай улсуудад байдаг түгээмэл хэрэглэгддэг хөгжсөн орнуудад хэрэглэгддэг ийм жишиг байгаа. Ийм болохлоор энийг зөв гэж үзээд бид нар итгэл үнэмшилээрээ шаардаж байгаа. ҮХЦ-ийн шийдвэр бол зөв байсан. Энэ бол зөв байсан. Энэ бол Монгол Улсын ардчилалд маш их хувь нэмэр оруулж байгаа шийдвэр.

Харин ҮХЦ-тэй холбоотой бусад шийдвэрүүдийн хувьд бол улс төрийн нөлөө бол орж байсан уу гэвэл орж байсан үнэн. ҮХЦ-ийг бие даасан, хараат бус байлгах ёстой гэдэг энэ зохицуулалтыг Үндсэн хуульдаа тусгаж өгөх ёстой юм байна гэдэг хатуу итгэл үнэмшил байдаг уу гэвэл байдаг. Баярлалаа.

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүн нэмэх юм байвал нэмье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Адьшаа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Адьшаа гишүүнээ ингэсэн юм. Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагч бид нараас пропорциональ тогтолцоо оруулж байгаа нь болж байгаа юм уу, болж байгаа юм уу, үгүй юу гэдэг ийм асуулт асуусан юм. Энд нь хариулахдаа Үндсэн хуулийн эцсийн шийдвэрийг эш татаж ярьсан юм. Өөрөөр хэлбэл 2012 онд ҮХЦ пропорциональ тогтолцоог болно гэж шийдвэр гаргасан юм. 16 онд болохгүй гэж шийдвэр гаргасан юм. Сая 22 онд энэ хоёроо хоёуланг нь хүчингүй болгоод, пропорциональ тогтолцоо орж болох тийм эрх зүйн орчныг нээсэн юм. Тийм учраас гишүүний асуултад хариулахдаа би энийг дурдсан юм.

Ер нь хууль тогтоогчид бид нар хууль тогтоохдоо Үндсэн хууль, бусад хууль, Цэцийн эцсийн шийдвэрийг үндэслэж хууль, эрх зүйн орчноо бүрдүүлж явдаг ийм л зүйл байгаа юм.

Н.Энхболд: Адьшаа гишүүн тодруулъя. Доржханд гишүүнээ ер нь зүгээр андуураад байна уу, аль эсхүл будилаад байна уу. Энэ асуултад хариулт өгөхгүй байна. Хууль тогтоох эрх мэдэл Цэцэд байгаа юм уу, Улсын Их Хуралд байгаа юм уу гэдгийг би асуусан. Цэцийн нэр барьж Цэцийн гарсан шийдвэр бол бид бүгд дагаж биелэх ёстой. Тэнд пропорциональ тогтолцоог л тэгж оруулна гэж байгаа.

Гэтэл өөрөө Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмнэ гэсэн агуулга байна гэдэг энэ хариуцлагагүй юмаа чи албан ёсоор тайлбарла. Ямар тийм агуулга байгаа юм бэ? Агуулгаар хууль хэлэлцдэг юм уу өнөөдөр. Энэ Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаа Их Хурлынхаа гишүүний бүрэн эрхийн хүрээнд та нар өргөн бариад яв. Гэтэл ҮХЦ-ийн ийм агуулгатай тийм агуулгатай гэдэг ийм бусдын нэрийг зээлчихсэн ийм юмаар ийм улс төрийн ийм хариуцлагатай цаг үед ингэж.../минут дуусав/

Н.Энхболд: Доржханд гишүүн. Доржханд гишүүний микрофоныг өгье.

Т.Доржханд: Тэгэхээр Адьшаа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ҮХЦ бол хууль тогтоогч бол биш. Тэгэхдээ ҮХЦ бол хуулийг ялангуяа Улсын Их Хуралд зөв хууль гаргаж байна уу, тэр нь Үндсэн хуульдаа нийцэж байна уу гэдэг дээр хяналтаа тавьдаг хамгаалагч. Олон улсад бол Үндсэн хуулийн шүүх гэж байдаг. Монгол Улс ч гэсэн энэ чиглэлээр бол ажиллаж байгаа. Тэгээд ҮХЦ гэдэг бол зөвхөн хамгаалагчаас гадна олон улсад бол Үндсэн хуулийгаа цаашаагаа баяжуулж байдаг, онолын түвшинд

асуудлаа ярьж байдаг ийм байгууллага юм билээ. Тэгээд энэ 02 дугаар шийдвэрийг гарахад бол та ч тэгэхэд орж байсан, би ч орж байсан. Та бол хурлаа хаяад гарсан үнэн. Энд бол цэвэр онолын маргаан гарсан. Монгол Улсын ҮХЦ-ийн хурлын түүхэнд анх удаагаа цэвэр онолын мэтгэлцээнүүд явсан. Энд бол бас парламентыг төлөөлж Энхболд гишүүн бас байсан, өөрөө бас гэрчлэх байх. Энэ шийдвэрүүд бол.../минут дуусав/

Н.Энхболд: Надаас асуусан юм бас Адьшаа гишүүн. Байнгын хороо Сонгуулийн хууль яриад байна уу, Үндсэн хууль яриад байна уу гээд. Бид нар Сонгуулийн хуулийн өргөн мэдүүлсэн 2 төслөө тойруулж ярьж байгаа. Энэтэй холбогдоод гишүүдийн энэ тоо ямар байх юм, хангалттай юм уу орон нутгаа төлөөлж чадах юм уу, тойргийн төлөөлөл багасах гэж байна гэсэн асуултауд гарч ирсэн учраас энийг тойруулж ер нь бараг бүх гишүүнээс гарлаа. Хариултууд дээр нь очихоор гарцаа байхгүй тэр ҮХЦ-ийн шийдвэртээ очиж нэг талаараа очиж мөргөлдөөд байгаа юм. Тэгэхдээ тэрний дагуу хийе гэсэн үг бас биш л дээ.

Яг бичгээр нь үзвэл ҮХЦ дотор Их Хурлын гишүүдийн тоог нэмж болно гэсэн үг байхгүй. Логик утгаар нь аваад үзвэл давхар дээлтэй холбогдуулаад өгсөн тайлбарт нь байгаа. Нэгэнт тоо тавиагүй зөвшөөрсөн маягийн тийм үг байхгүй гэж бид нар үзээд шаардлага гарвал тэгнэ гэж байгаа болохоос биш ҮХЦ-ийн шийдвэрийн дагуу юм уу, дүгнэлтийн дагуу тоо нэмэх асуудал яригдаагүй шүү гэдгийг бас та зөв ойлгоорой. Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа би маш товчхон асуулт асууя. Тэгэхээр нөгөө ЗГХЭГ-ын сайд орж ирсэн байгаа. Тэгээд түрүүн бас Тогтохсүрэн гишүүн дурдаж байна лээ. Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол бол гарсан. 55 дугаар тогтоол дээр бол ажлын хэсэг гарсан. Одонтуяа

гишүүн бид нар бол энэ дээр нэлээд их саналуудаа тусгаж тогтоол гарсан. Тогтоолын хүрээнд болохоор 2 зүйлийг зайлшгүй тусгаж оруулж ир гэдэг тов тодорхой чиглэл өгсөн байгаа.

Нэгдүгээрт, тогтолцооны асуудлыг, хоёрдугаарт Улсын Их Хурлын төлөөллийг нэмэгдүүлэх асуудлыг Үндсэн хуулийн төслийг боловсруулж ир гэсэн ийм тодорхой чиглэл өгсөн. Тэгээд Засгийн газар дээр ажлын хэсэг гараад ахалж байгаа хүн нь бол Засгийн газрын Хэрэг эрхлэхийн сайд гэж ойлгосон. Тэгээд түрүүн бол хуулийн төсөл бол бэлэн болсон, хэлэлцүүлгийг эхлүүлэхэд бэлэн гэдэг ийм тайлбар өгөх шиг боллоо. Би тэрэн дээр тодруулж асуумаар байгаа юм. Бэлэн болчихсон юм бол процессын хувьд яг хэзээ эхлүүлэх юм бэ? Яаралтай эхлүүлэх хэрэгтэй. Яагаад вэ гээд тэгэхээр өнөөдөр ингээд Улс төрийн намын тухай хууль өргөн барих асуудал яригдаж байна. Сонгуулийн тухай хууль мөн өнөөдөр хэлэлцэгдэж эхэлж байна. Маш сайн.

Тэгээд цаашаа бид нар яг энэ тогтолцооныхоо асуудлыг иж бүрнээр нь ярихын тулд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг ярих цаг нь бол болсон. Энэ бол зөвхөн Монгол Улсын ардчиллын асуудал бас биш юм. Тусгаар тогтнолын асуудал юм. Тэгээд зарим хүмүүс бас асуугаад байх шиг байна лээ. Сүүлийн 4 жилтэй харьцуулах юм бол юу өөрчлөгдсөн юм бэ гээд. 4 жилийн өмнө дайн болоогүй шүү дээ. 4 жилийн өмнө ковид болоогүй шүү дээ. Дэлхий ертөнц өөрчлөгдчихсөн шүү дээ. Ардчилал, ардчилсан нийгэм байх уу, авторитар нийгэм байх уу гээд дэлхий 2 хуваагдчихаад байна. Хөрөнгө оруулалтууд нь шал өөр түвшинд очоод маш том дайн болж байна.

Энэ тохиолдолд Монголд бас ардчилсан улс байя гэж үзэж байх юм бол, цаашаага тусгаар улс байна гэж үзэж байх юм бол, цаашаага эдийн засгийн

хараат бус бодлогоо хийж чадна гэж үзэж байгаа юм бол бид нар энэ парламентынхаа ардчиллыг сайжруулахаас өөр арга байхгүй. Өөр арга байхгүй олуулаа суудаг. Тэгэхээр энэ яаралтай юм шүү. Тэгээд яаралтай оруулж ирэх асуудлыг Хэрэг эрхлэхийн сайд маань хийж байна уу, үгүй юу? Яг хэзээ оруулж ирэх юм бэ? Ирэх долоо хоногт оруулж ирэх боломж байна уу? Одоо яаралтай хэлэлцэх хэрэгтэй гэсэн ийм байр суурьтай байгаа. Энэ дээр тодорхой хариулт өгөөч. Баярлалаа.

Н.Энхболд: 5 номерын микрофон Амарбаясгалан сайдын микрофоныг өгье.

Д.Амарбаясгалан: Доржханд гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол мөн Улсын Их Хурлын 34 дүгээр тогтоол 2-ыг үндэслээд ажлын хэсэг бол ажилласан байгаа. Мэдээж Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс судалсан, тооцсон, тоо нэмэх тогтолцоог бодитоор Үндсэн хуульд тусгах асуудлыг бол судлаад гаргаад ирсэн байна. Өнөөдрийн байдлаар бид яамнуудаасаа санал авахаар саналд гаргасан.

Мөн журмын хуулийн дагуу олон нийтийн дунд хэлэлцүүлэхээр Засгийн газрын веб сайтад байрлуулах бэлтгэл хангаад ингээд ажиллаж байна. Мэдээж хуулийн хугацаа мөн яамнуудаас ирсэн саналыг нэгтгээд, Засгийн газраар хэлэлцээд, тэгээд цаашаага энэ өргөн барих асуудал бол яригдахаар болж байгаа гэдгийг бас хэлмээр байгаа юм. Ер нь энэ гишүүдийн тоог бас дахиад тодруулаад хэлэхэд бол ҮХЦ-ийн шийдвэр гарахдаа энэ тоог нэмэх, тогтолцоог өөрчлөх асуудал нь парламент Засгийн газрын харилцаанд чухал үүрэгтэй шүү. Тэгэхээр цаашидаа энэ засгийн Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр ажиллаж байгаа тохиолдолд энэ тоог зайлшгүй нэмэх шаардлагатай юм гэдэг үндэслэл гарсныг Улсын Их Хурлын

гишүүд маань бас ойлгож байгаа гэж ингэж бодож байна.

Тэгээд парламентын гишүүний тоо нэмэгдсэнээр саяын бас гишүүдийн маань хэлээд байгаа олон үндэслэл шаардлагууд бүрэн хангагдах нөхцөл рүүгээ явах юм байна гэдэг энэ агуулгын үүднээс судлаачдаа ажиллуулсан. Батсуурь гишүүн маань түрүүн бас ярьж байх шиг байсан. Энэ судлаачид сонгууль мэдэхгүй судлаачид гэж ярьж байх шиг байсан. Судлаачид бол олон улсын сайн туршлага практик дээр яаж хэрэгжсэн байдалд бол үнэлэлт дүгнэлт өгдгөөрөө илүү онцлог. Мэдээж маш өргөн хүрээний мэдээлэл дээр харьцуулалтыг хийж, гаргаж ирдгээрээ онцлог байгаад байгаа юм. Яах вэ яг энэ сайн туршлагуудыг аваад үзэх юм бол олон улсад энэ 50, 50 холимог хэлбэрээр сонгуулиа явуулж байгаа улсууд бол ялангуяа Баруун Европт хэд хэдэн улс байна. Бидний хөрш ОХУ бас байна. Маш сайн эерэг үзүүлэлтийг гаргаж чадсан улс бол хамгийн сүүлийн жишээ бол Япон улсын жишээ байж байх жишээтэй. Энэ дээр бол нэг зүйлийг бодох ёстой юм шиг байгаа юм. Яг Япон, Солонгос гэсэн 2 улс сонгуулийнхаа системд энэ пропорциональ элементийг оруулж ирэхдээ хандсан хандлага дээр нь нэг нь оносон, нөгөөдөх нь алдсан байгаа юм.

Онош нь юу вэ гэхээр багадаа 40 хувийн нийт гишүүдийнхээ 40 хувийг пропорционалиар бүрдүүлэх өөрчлөлтийг хийснээрээ Япон авлигал улс төрийн түвшин дэх авлигал эрс багасгах, хяналт тэнцлийг өндөр түвшинд хангах нөхцөлөө бол хийж чадсанаараа өнөөдөр парламент нь хөгжсөн. Парламентдаа төрдөө итгэх ард иргэд сонгогчдын итгэл үнэмшил бол маш өндөр түвшинд хүрэх тэр нөхцөл бүрдсэн гэж. Эсрэгээрээ БНСУ нийт парламентынхаа гишүүдийн 15 хувийг пропорциональ элементээр оруулах нөхцөлийг шийдсэн. Харамсалтай нь манай 2012 оны шиг 30 хүрэхгүй хувийг нь пропорциональ болгож оруулсантай

адилхан алдаа дутагдлыг давтаад явж байна. Өнөөдөр БНСУ энэ алдаагаа засахын тулд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж, Солонгосын сонгуулийнхаа тогтолцоог өөрчлөх жижиг мажоритар болон байгаагаа том болгох пропорциональ 15 хувь төлөөлж байгаагаа үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх зорилгыг тавиад ажиллаж байгаа юм.

Тэгэхээр энэ бол бид нар сайн улсын жишээг харж жишигийг барьж энэ сонгуулийнхаа дараачийн түвшинд ахиулах энэ бодлогыг хэрэгжүүлж чадах юм бол улс оронд өгөх өгөөж нь илүү байх юм гэдэг энэ зүйлийг бол хийж байгаа. Маш олон намын оролцоо хангагдах боломж бүрдэнэ. Энэ хэрээрээ хяналтын тогтолцоо улам бүр сайжирч, хулгай хийгддэггүй байх тэр нөхцөл бүрдэнэ.

Н.Энхболд: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд хуулийн төслийн хэлэлцүүлэгтэй холбоотойгоор асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байвал нэрээ өгье. Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүнийг нэмчхээрэй. Баатарбилэг гишүүн.

Ё.Баатарбилэг: Тэгэхээр түрүүн би асуултдаа асууж байсан. Нөгөө сонгуулийн тогтолцооны тогтвортой байдал гэдэг юман дээр цаашид онцгой анхаарах шаардлагатай байна. Сонгууль дөхөхөөр сонгуулийн өмнөх жил зайлигүй сонгуулийн хууль өөрчлөгдөнө. Энэ удаа ямар хуулиар юу сонгууль явах юм бол доо гэдэг ийм маргаан мэтгэлцээн парламентаасаа өгсүүлээд, жирийн айл өрхийн гэрт хүртэл ингээд өрнөдөг ийм л болчихлоо шүү дээ. Сүүлийн сонгууль болгон дээр. Сонгууль болгоны өмнө.

Энэ байдал чинь өөрөө энэ манай энэ төр засгийн тогтворгүй байдал, тэгээд цаашилаад энэ гарч байгаа бодлого, шийдвэрийн залгамж чанар алдагдаж байгаа байдал, тэгээд энэ чинь улс нийгэм, эдийн засгийн дараа дараачийн үр

хөврөл хор холбогдлууд нь ингээд л ургаж гараад байна л даа. Аливаа юм тодорхой байх нь бол чухал давуу талтай. Тэгээд бид нар бол ямар сонгуулийн тогтолцоогоор, ямар хуулиар, ямар сонгууль явах нь тодорхой байдаг. Тэрэндээ улс төрчид нь яаж оролцох вэ, сонгогдсон гишүүд нь яаж ард иргэдийнхээ итгэлийг дааж ингэж ажиллах вэ, ингээд сонгуулийн амлалтаа эрх барьж байгаа нам нь яаж биелүүлэх вэ энэ маш олон юман дээр л ер нь тодорхой байдал чухал байгаа юм л даа.

Тэгээд нэг сонгуулийн хууль юу сонгууль дараагийн ээлжит сонгууль дөхөхөөр л сонгуулийн хуулиа барьж аваад л ноцолдоод л яаж энэ удаа I туг тойрчих вэ гээд л I иймэрхүү маягтай аргацаасан маягаар ингэж I жил хоногийг өнгөрөөдөг байдлыг энэ удаагийн энэ Сонгуулийн хуулиар ингээд таслан зогсоогоод эцэслээсэй билээ гэж бодож байна. Энэ удаагийн Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулбал нэг оруулсан шиг оруулаад, дагасан тэр хуулиуд нь орвол оруулсан шиг оруулаад, тэгээд 24 оноос хойш Сонгуулийн хууль нэг тогтвортой байгаасай гэж гэж ингэж бодож байна. СЕХ-ны нөхдүүд энд байж байгаа. СЕХ яах вэ дээ батлагдсан хуулийн дагуу л хэдэн дүрэм журмаа батлаад л, тэгээд сонгууль хуулийнх нь дагуу сонгуулийг зохион байгуулах л үүрэгтэй байгууллага.

Тэгэхээр хууль тогтоож байгаа байгууллагын бид нар өөрсдөө энэ асуудал дээрээ нэг жаахан тийм байр суурьтай байхгүй бол энд бол бас нэлээн олон сонгогдсон гишүүдээсээ гэсэн эхсүүлээд I сонгогдсон анх сонгогдсон гишүүд сууж байгаа юм. Тэгээд Сонгуулийн хууль өөрчлөх болгонд орж ирээд л байр суурь илэрхийлж байсан л байж таараа. Бид нар бас өмнөх сонгуулиуд Сонгуулийн хуулиуд дээр ороод л бас юм яриад л сууж л байсан. Тэгэхдээ өмнөх сонгуулийн юман дээр бол мажоритар орж ирэх нь бол ийм үүдээр хөөгөөд гаргахаар тооноор ороод

ирдэг юм гээд л ерөөсөө энэ холимог тогтолцоо пропорциональ болохгүй гээд л нийгмээрээ улсаараа пропорциональ тогтолцоо болохгүй гэж ярьсаар байгаад л сүүлдээ энэ Цэц рүү яваад л, тэгээд л Цэцийн тэр I дүгнэлт гэдгийг яахад түрүүн бас хэлж байна шүү дээ.

Цэцийн дүгнэлт гэдэг чинь өөрөө хууль биш шүү дээ. Тэрийг авах уу, авахгүй юу гэдэг асуудал байна. Тэгэхээр нэг ийм маягтай, нэг өдөр хоног аргацаасан байдлаа боливол яадаг юм бэ? Жаахан нэг нүүртэй, нэг арьстай улс төрөө хийцгээгээд явцгаавал яадаг юм гэж. Тэгээд нэг яаж дараагийн сонгууль сонгоцгоочих вэ? Яаж нэг ингээд нэг хуулиа нэг эвтэйхэн шиг засаж байгаад нэг туг тойрчих уу гэдэг ийм л маргаан явж байна шүү дээ. Улс төрийн намын хүрээнд чиг, хувь улс төрчдийн хүрээнд чиг. Тэгээд энэ нэг сонгуулийн хуулийг ярьж байгаа маягтайгаар юу улс төр хийцгээгээд л. Ямар ч байр суурь алга. Энэ ТББХ-ны энэ хуралдаанд оролцож байгаа гишүүдийн хувьд ч гэсэн яг адилхан. Бид нар өөрдөө. Бид нар өөрсдөөсөө л эхэлж ярих хэрэгтэй. Энүүгээр хамгийн түрүүнд Сонгуулийн хууль ярьдаг энэ Байнгын хороогоор.

Тэгээд яг ямар хууль орж ирж байгаа гэхээр 2 талаасаа ингээд I бас холимог тогтолцоо тэгээд тоог нь жооохон зөрүүлсхийгээд л оруулж ирж байгаа юм. Агуулга нь ерөнхийдөө адилхан. Тэгээд л нэг баахан жүжиг тавиад л болохгүй юмнуудаа Цэц рүү чихчхээд л, Их хурал нэг ийм байдалтай байж болохгүй шүү дээ. Болохгүй. Мажоритараараа яваад болохгүй байгаа юм байхгүй. 76 нь цөөдчихөөд байгаа юм байхгүй. Тэгэхээр энэ удаа бол нээрээ одоо Сонгуулийн хууль нэгэнт өргөн бариад өөрчлөх гэж байгаа юм байна, тэгээд л өөрчлөх л байх. Энэнээс цааш 28 он, 32 он гээд Сонгуулийн хууль дахиж битгий олон өөрчлөгдөөсэй, тогтвортой байгаасай. Сонгуулийн тогтолцоо тогтвортой байгаад төр засаг тогтвортой байгаасай

л гэж би бодож байна. Тэгж хүсээж байна. Баярлалаа.

Н.Энхболд: Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Парламентын харилцаа чинь парламент чинь ер нь харилцан ярьж байж аль, аль талаасаа асуудлаа гаргаж ирж тавьж байж зөв шийдвэр гаргах гэж би парламентын тогтолцоо гэж боддог хүн л дээ. Тэгээд би ТББХ бол бас парламентын нэг л бүрэлдэхүүн хэсэг. Тэгэхээр ижил тэнцвэргүй мэтгэлцээнүүд явагдаж байна л даа. Надад ганц минут асуунгуут 4-5 хүн дараалаад намнаж байна. Харилцан яриа биш, тэрийг заавал нэг дийлэх гэсэн байдлаар хандаж байна. Би бол сэтгэлээсээ л ярьж байна. Надад эрх ашиг алга.

Жишээлбэл сонгуульд орох намууд гарын үсэг зурсан гээд. Энэ сонгууль чинь намуудын гишүүдийн асуудлыг шийддэг сонгууль юм уу? Монголын ард түмний асуудлыг шийдэх гэж байгаа юм байгаа биз дээ. Тэгээд аль ч намыг хүсэхгүй 70, 80 хувь байна шүү дээ. Яагаад тэднүүдийг асуухгүй байгаа юм. Хаана ч байдаг, хэнийг ч очингуут цугладаг нэг хэдэн хүмүүс байдаг. Тэднүүсийнхээ тархийг угаачихдаг. Тэгээд бүх намууд гарын үсэг зурсан гээд. Тэгээд тэрийгээ тайлбарлахаараа 800 хүнтэй нам л юм чинь яагаад болохгүй байх юм бэ. Тэгэхээр би бол сэтгэлээсээ асууж байна. Монгол Улсад сонгууль боллоо. Сонгууль Монголын ард түмний асуудлыг шийдэх гээд байгаа юм уу, намуудыг дагасан гишүүдийн асуудлыг шийдэх гээд байгаа юм уу.

Тэгэхээр аль ч намыг шийдэхгүй байгаа энэ 60, 70 хувийн сэтгэл санааг сонс л доо. Тэр хүмүүс чинь пропорционалийн ард ямар нэгэн хүмүүсийг нуугдуулахгүй байх, пропорциональ хэтийдээд ороод ирэх юм бол болохгүй гэдгийг бид нар 16-аас, 12-16 онд үзчихсэн. Тэгээд ингээд ярингуут

ҮХЦ-ийг яриад байх юм. ҮХЦ бол Үндсэн хуулийн манаачийнхаа үүргийг биш, Монголын төрийг бужигнууллаа шүү дээ. Хангалттай хэмжээнд бужигнуулсан. 1 тогтоол гаргаад л давхар дээл, 1 тогтоол гаргаад л давхар дээл биш, 1 тогтоол гаргаад л сонгууль болно, 1 тогтоол гаргаад л сонгууль болохгүй.

Гэтэл өнөөдөр шүүр ажиллагаа гээд явж байна. Хэдэн мянган хүнийг ч гэнэ үү чөлөөлөх гэж байна. Үндсэн хуулийг даргалж байгаа дарга чинь төрийн албаны дээд хязгаар өнгөрөөд аль хэдийн эрх зүйн чадамжгүй болчихсон байгаа шүү дээ. Би энийг олон удаа хэлж байгаа шүү дээ. Тэнд мөн барьцаалагдсан өөрийнхөө хүслийн эсрэг байгаа хүмүүс зөндөө энэ шийдвэрүүдийг гаргаж байгаа шүү дээ. Тэгээд юуг яриад байгаа юм. Парламенттай орнууд хэд хэд байсан гээд. Хүнтэй нь харьцуулж ярьдгийг бол би тун буруу гэж бодож байна. Улс орон болгон удирдлагатай байгаа. Тэрийг парламент гэнэ үү, юу гэнэ үү. Тэгвэл улс орны тоотой харьцуулаад үзэх юм бол Хятад, Энэтхэг, Америк маш муу, цомхон удирдлагатай байгаа шүү дээ. Маш цомхон сенатын гишүүн, маш цомхон тэр ардын ямар, ямар нэртэй билээ ийм зүйлүүд байж байгаа.

Тэгэхээр миний бодлоор Сонгуулийн хууль, Үндсэн хууль, энэ Төсвийн хууль бол нийгмийн зөвшилцөл байх ёстой гэж. Нийгмийн зөвшилцөл байх ёстой. Ахиад би хэлж байгаа юм. Монгол Улс үнэхээр нэг нийгмээс нөгөө нийгэмд ороод байхад үнэхээр хэцүү байсан. Бид нарыг яваад очиход гэрэлтэй сум хэд байсан юм, гэрэлтэй галлагаатай аймаг хэд байсан юм. Энэ бүхний чинь өнөөдөр, одоо ямар болчихоод байгаа билээ. Энэ бүхний өөрчлөлтийг энэ мажоритар системийн сайн талаар, мөн орон нутгийн хөгжлийн сангийн тэр хуульд орсон нөлөөгөөр өнөөдрийн Монгол Улсын 21 аймаг, 300 гаруй сум, 1000 гаруй баг, хороо бас нэг хүн очихтойгоо болчихоод байгаа шүү дээ.

Өнөөдөр Монголын төрийг 76-гийн чинь 52 нь хөдөөд байдаг. 24 л Улаанбаатар хотод байдаг. Хөдөөд байгаа тэндээс сонгогдсон эрмэлзэлтэй тэр хүмүүс чинь Монголын төрд оролцоогоо хангаж чадахгүй болох нь байна шүү дээ. Улаанбаатарын түгжрэлийг, Улаанбаатарын утааг, Улаанбаатарын авлигыг Улаанбаатартай ноцолдоод барахгүй. Орон нутагт байгаа хүмүүсийн амьдралын чанар сумд байгаа амьдралын чанар адилхан болж байж энэ түгжрэл, утаа чинь байхгүй болно. Гэтэл би төдөн орноор явсан гээд хэний ч мөнгөөр явсан юм, хэний ч мөнгөөр сурсан юм. Сумд очиж баг бригадад очиж амьдарч үзээгүй, сурч үзээгүй, хонож үзээгүй хүмүүс Монголын төрийн 52 тойргийг шийднэ гээд ингээд чичрээд байгаа байхгүй юу. Чичрээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр би энийг юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр ТББХ-ныхноосоо би зүгээр гуйж байгаа юм. Надад ямар ч эрх ашиг алга. Ингэж савлахаараа юун дээр очдог вэ гэдгээ та бүхэн өөрсдөө мэдэж харж байгаа шүү. Мэдэж харж байгаа шүү. Одоо Үндсэн хуулийн өөрчлөлт рүү орно. Үндсэн хуулийг дэмжихгүй нийгмийн 90 хувь байгаа шүү.

Н.Энхболд: Одонтуяа гишүүний микрофон өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр би бас нөгөө асуулт асуух юмнаас хоцорчихсон учраас СЕХ болон Доржханд гишүүнээс 2 асуулт асууна. Энийг маргааш чуулган дээр бас хариулж болно. Энийгээ бол дахиж асууна. Дүгнэлт дээр өөрийнхөө бодлыг хэлье. Тэгэхээр ер нь 2011 оноос энэ холимог системийн тухай манайхан манай АН-ынхан судлаад энэ их зөв систем юм гээд явж ирснээс хойш бол би энийгээ бол туйлбартай дэмжиж яваа. Миний хувьд бол би бол эхлээд улс орны эрх ашгийг бодоход бол энэ холимог систем зүйтэй юм гэж бол үздэг.

Хэдийгээр манай нам бас ингээд олон өмнө нь олон хуваагдчихсан байсан ч гэсэн ер нь гишүүдтэй уулзахад мажоритар бол манай намд хэрэгтэй гэж хэлж байгаа хүн бараг тааралдаагүй. Голцуу л энд тэнд хүмүүс ярихад ер нь холимог систем л манай намд тохирно гэж, улс оронд тохирно гэж ингээд ярьж байсан. Тэгэхээр би бол энэ холимог системийн төлөө бас энэ дуустал нь ингээд явна. Энд бол хэнтэй ч хамтарч ажиллаж болно. Мэдээж зовлон бэрхшээлүүд байсан. Анх энэ чинь нөгөө шууд хуулиар биш заавал Үндсэн хуулийг ингээд л явж байсан учраас маш их зовлонг туулсан шүү дээ. Тэгээд л зөндөө л ярилцацгаасан. Тэгээд ер нь зүгээр алдаа гаргачих болов уу гээд суугаад байвал ер нь ямар ч реформ бол хийгддэггүй. Тийм учраас энэ дээр бол энийг бол маш том реформ гэж харж байгаа юм.

Манай Цогтгэрэл, Ганбат гишүүн 2 бол тусдаа хууль өргөн барьсан. Энэ хуульд бол их чухал, чухал санаа орсон юм. Яагаад гэхээр энэ сонгууль чинь өөрөө улс төрийн намын сонгуульд ордог хувилбар байгаа. Тэгэхээр ерөөсөө улс төрийн намуудын үүрэг ролийг бүр үгүйсгэчихсэн, дандаа бүх юмыг тэр цаагуураа төрийн алба нь хийдэг ийм байсан дээр хэд хэдэн чухал заалт орсон. Энийг бол бас ажлын хэсэг нэлээд хариуцлагатай хараад явах байх гэж бодож байна.

СЕХ-нд бол би их тийм шүүмжлэлтэй хандмаар байгаа. СЕХ бол бид нарт нэг ийм ерөнхийдөө нэг төсөл оруулж ирсэн. Тэр төслийг харахад бол зүгээр мажоритарыг л ингээд пропорциональ болгочихсоноос биш яг тэр пропорциональ дээр ч чинь саналын хуудас нь яг ямар байх юм, тэр ард иргэдийн нөгөө хүсээд байдаг нөгөө царцааг нь яаж болиулж байгаа юм. Нөгөө бүртгэлийн системийг нь яаж чанаржуулж байгаа юм, зардал хэмнэх. Одоо иргэд бол бүгд тэгдэг шүү дээ. Үгүй ээ нэг баахан самбар байх юм. Энийг тэр

Япон, Солонгос шиг нэг болгочихдоггүй юм уу. Үгүй ээ тэгээд тэрийг нь аргачлалыг нь бид нарт ингээд гаргаад өгч болно доо. Тэгэхгүй ингээд л бид нар чинь нэг ажлын хэсэг гээд л хэдэн хүн энд тэндхийн юм ухаад л. Үгүй ээ нөгөө самбар дээр нь нөгөө намууд нь багтахгүй бол яана, бие даагчид нь багтахгүй бол яана гээд л ингээд явах юм.

Дээрээс нь тэр тараах материалыг хүмүүс хэлдэг шүү дээ. Үгүй ээ ерөөсөө 1 ном болгоод л тэр хэсгийн ахлагч нараар тараалгачхаж болдоггүй юм уу гээд. Тэгэхээр энэ дээр хуртэл ямар ч бодит санал орж ирэхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр би энийг маргааш асууна. Энэ орсон уу, энэ хуулиудад чинь яаж орсон юм бэ? Яг энэ самбар, энэ материал дээр яаж тэр хүмүүсийн иргэдийн нөгөө хүсэн хүлээгээд байгаа намуудын хэлээд байгаа юм чинь яаж орсон юм бэ гэдгийг би асууя. Тэгэхээр маргааш та нар бэлдээрэй. Өөрөөр хэлбэл заавал бүгд бүгдийг нь төр хариуцахгүй байж болно шүү дээ. Өөрөөр хэлбэл хүмүүс материалын тэр зардалд нь тухайн тойргийн хүмүүс мөнгөө хуваагаад зардал хуваах маягаар бас ажиллаж болно. Тэр нэг хүнээр нь тараалгана. Тэгэхдээ хэвлэлтийн зардал, өөр юу байдаг юм тэр нэг ганц нэг зардлуудыг нь хуваах зарчмаар ингээд явах бас хэлбэр байж л байгаа. Тэгэхээр ийм реформын чанартай юмнууд нь ерөөсөө ингээд СЕХ-ноос орж ирээгүй. Өөрсдөө л юм ухаад л байдаг, ухаад л байдаг. Тэр хооронд саналын хуудсаа ингээж бичдэг гэнэ. Тэгэхээр энэ нь биш л гэнэ, мөн л гэнэ. Иймэрхүү зүйлүүд бол маш их байгаа.

Доржханд гишүүнээс маргааш би юу асуух вэ гэхээр тэр нөгөө цагаан сараар хэвийн боов тарааж байхад бид 2 нэг хэвлэлийн хурал хийж байсан. Яг энэ зардлыг яаж бууруулах юм бэ энэ сонгогдсон болон горилж байгаа хүмүүс ер нь энэ ингээд юм тараагаад байх юм уу, үгүй юм уу гэдгийг багасгая гэсэн ийм

зүйлүүдийг бол ярьсан байгаа. Тэгэхээр энийг маргааш асууна. Энийгээ яаж оруулсан юм, яаж энийгээ шийдэх гээд байгаа юм. Ер нь энэ нэг баахан юм тараадгаа л больчихмоор байгаа байхгүй юу. Зөвхөн Их Хурлын гишүүд биш. Одоо яаж байна вэ гэхээр төрийн баахан албан хаагчид ингээд юм тарааж байна л даа, би харж байна. Тэгэнгүүтээ 1 сарын 1-нээс юу яах юм байна л даа өргөдлөө өгөөд, би сонгуульд нэр дэвшинэ гээд гараад ирэх юм байна. Бид нар яаж тэд нарыг чинь гүйцэх юм бэ? Тэр олон Төрийн нарийн байсан хүмүүсийг чинь, тэр сайд байсан хүмүүсийг чинь гүйцэхгүй шүү дээ. Тэгэхээр нөгөө тэгш гараа чинь байхгүй болчихож байгаа юм. Энийгээ яаж шийдэх юм бэ?

Дээрээс нь гишүүд нь тараахаа больё гэхэд нэг хүн баахан юм тараагаад байдаг, дараа жил нь нэр дэвшээд гараад ирвэл яах юм гориллогчид. Тэгэхээр ер нь энэ нэг Их Хурлын гишүүд чинь хуулиа л баталдаг. Энэ улс орныхоо амьдралыг л сайхан болгох талаас нь бодохоос биш энийг айхтар зүйлүүдийгээ та энэ реформын юундаа оруулсан уу, үгүй юу гэдгийг маргааш асууна.

Н.Энхболд: Занданшатар дарга.

Г.Занданшатар: Ер нь аливаа органик хууль бол Үндсэн хуулийн үзэл санаанд бүрнээ нийцэж байх ёстой. Тэгэхээр ер нь Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог бол императив мандат буюу тойрогтоо амьдардаг, тойргийн төлөөлөгч байх энэ императив мандатын зарчмаас гадна нийт улс ард түмний эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, нийт иргэн, улсын эрх ашгийг эрхэмлэн дээдэлж ийм баримтлах үүрэгтэй ард түмний нийт ард түмний үндэсний төлөөлөгч юм гэж тодорхойлсон байдаг л даа.

Гэтэл өнөөдөр бол нөгөө мөнгөтэй хүнийг сонгоно, мөнгөтэй хүн сонгогдоно гэсэн нэг ийм агуулга ярьдаг ойлгодог. Тэгээд сонгуулийн тогтолцоо байнга

өөрчлөгддөг болохоос ард түмнийг сонгуулийн төөрөгдөлд оруулдаг ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа юм. Тийм учраас энэ улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, сонгуулийн зардлыг бууруулах ийм асуудлыг илүү тодорхой болгож энэ Сонгуулийн хуульд тусгах шаардлагатай. Энэ бол иргэдийн маш их юм ярьж байгаа. Энэ чинь нөгөө авлигыг өдөөгдөж байдаг, авлигын учир шалтгаан, улс төрийн авлигын учир шалтгаан болж байдаг энэ нөхцөлийг энэ Сонгуулийн хуульд бас тодорхой тусгаж байж энэ авлигын шалтгаан нөхцөлийг устгах нөхцөл бий болно.

Хоёрдугаарт нь бол энэ газар бол улсын үндэс мөн гэсэн энэ уламжлалт номлол философи, үндэсний үнэлэмж тогтсон байна. Нэн ялангуяа энэ 2 том гүрний дунд оршдог Монгол Улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлын хувьд газар нутаг, нутаг дэвсгэрийн төлөөллийг зайлшгүй хангах шаардлага үүснэ. Яагаад гэвэл тэр төрийн төлөөлөгч цөөхөн байх тусмаа төсөв мөнгө бага хуваарилагдана, хаягдана, алслагдана, тэгээд эзэнгүй болно. Энэ тэгээд Монгол Улсын эрх ашигт нийцэхгүй. Энэ Улаанбаатар улс болох уу? Бусад газар нутаг, хил хязгаарын бүрэн бүтэн байдал яах вэ? Энэ тэгэхээр хоёрдугаарт энэ бол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын бодлоготой нийцэх шаардлага гарна.

Энэтэй уялдаад энэ СЕХ бол улсын хэмжээнд ийм хараат бус төрийн байгууллага байж, сонгуулийг бүрэн зохион байгуулах эрх бүхий байгууллага байдаг. Тэгээд Сонгуулийн хууль өөрчлөгдөөд байх тусам энэ СЕХ-ны тогтвортой байдал бас алдагдсан. Энийг бас энэ хуулиар бүрэн тодорхой статусыг нь тодорхой болгож, энэ бүрэн эрх бүхий зохион байгуулдаг байгууллага болох тэр эрх мэдэл хэрэгтэй байгаа юм. Улс төрийн намууд, эрх баригчид оролцоод зохион байгуулаад байдаг биш. Тэгээд энэ бүхнээс үндэслээд энэ

сонгуулийн тогтолцоог тогтвортой байлгах асуудал яриад байна л даа. Сонгуулийн хуулийг тогтвортой байлгах тухай асуудал яриад байна. 2000 энэ удаа дараа өөрчилж байгаа нь бол жишээлбэл 2016 онд хоёрхон сарын өмнө сонгуулийн тогтолцоог үндсээр нь өөрчилж, улмаар энэ нь сонгогчдыг төөрөгдөлд оруулдаг ийм нөхцөл байдлыг үүсгэж байсан. Энэ бол ер нь хууль тогтвортой байх эрх зүйт ёсны утгын болон техникийн дүрмийг зөрчиж байгаа хэрэг юм.

Ингээд нэг өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлдэг, тэгээд ард түмнийг төөрөгдөлд, сонгогчдыг төөрөгдөлд оруулдаг ийм нөхцөл байдлыг энүүгээр таслан зогсоож нэг энэ тууштай нэг мөрддөг бол болмоор байгаа юм. Аль ч тогтолцоонд сайн, муу тал, давуу тал, эерэг тал, сөрөг тал бий. Харин гагцхүү тэрнийг хэлбэрэлтгүй мөрдүүлж байж, сул талуудыг нь арилгаж, давуу талыг нь нөхцөлдүүлж ашиглах ёстой. Ийм учраас энэ нөхцөл байдал энэ 3 шаардлага, шалтгааныг бид хэлэлцэхдээ Сонгуулийн хуулийг хэлэлцэхдээ бол бүрнээ анхаарч шийдмээр байна.

Нэн ялангуяа тэр улс төрийн санхүүжилт, сонгуулийн зардлыг бууруулах, тэр тойргоо услах, энэ Одонтуяа гишүүн гишүүдийн яриад байгаа төрийн албан хаагч, албан хаагч ч байна уу тойргоо усалдаг, тэгээд тэр нь хууль тогтоогчдыг сонгох сонгууль биш, хуучны депутат сонгодог сонгуулийн тогтолцоо хэвээрээ яваад байна. Энэ чинь хууль тогтоогчдыг ард түмнээ төлөөлж төрийн эрх барих дээд байгууллага гэдэг бол хуулиар төрөө удирдана, жолоодно гэсэн ийм агуулгаар тэгж бичсэн гэж Чимэд гуай хэлсэн байдаг. Тэгтэл хуулиар төр жолоодохоос гадна, сонгуулийн тогтолцоонд маань энэ мөнгөний нөлөө давамгайлах байдалтай болсноос энэ улс орны авлигын ч, сонгуулийн тогтолцооны ялзралын ч ийм учир шалтгаан болж байна. Энийг ингэж цогцоор нь шийдэх

шаардлагатай байна. Нэн ялангуяа энэ, энэ нь бол тогтолцооны өөрчлөлттэйгөө уялдах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ сонгуулийн зардлыг бууруулах.

Эцэст нь бол энэ төрийн албан хаагчдын сонгуулийн эрх ашиг сонирхлыг хангадаг байх шаардлагатай байна. 225205 хүнд сонгуулийн эрх мэдэл хязгаарлагддаг. 32295 төрийн албан хаагч сонгууль зохион байгуулдаг. Тэгээд төрийн албаны энэ сонгох, сонгогдох эрх, эмч, багш нарын сонгох, сонгогдох эрх, төрийн албан хаагчдын сонгох, сонгогдох эрхтийг бас зөв оновчтой болгомоор байгаа юм. Энэ асуудлуудыг бол хуулийн хэлэлцүүлгүүд дээр анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Н.Энхболд: Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Би нэг 3 зүйлээр та бүгдэд бас нэг байр сууриа илэрхийлчихмээр байгаа юм. Яагаад энийг бид нар дэмжиж батлах ёстой юм бэ? Яагаад бид нарт энэ сонгуулийн пропорциональ систем хэрэгтэй юм бэ гээд. Нэгдүгээрт би Монгол Улсын эдийн засагтай холбомоор байгаа юм. Монгол Улсын эдийн засаг сүүлийн 10 жил гацчихсан, гацчихсан төгрөгөөрөө ингээд дээшээ өсөөд байдаг, доллар дээрээ гацчихсан юм шүү дээ 10-аас 12 тэрбум доллар дээр гацчихсан. 1 хүнд оногдох ДНБ 3.8, 3800 доллар дээр гацчихсан, 10 жил гацчихсан. Яагаад энэ гацаад байна, яагаад эдийн засаг маань тэлэхгүй байна гээд тэгэхээр энэ сонгуулийн тогтолцооноос болоод байна бүр үндсэн. Яагаад вэ гэхлээр Монгол улсын төсөв сүүлийн 20 жилд дандаа алдагдалтай. Тэгээд тойргоо санхүүжүүлдэг, хавтгайрсан нийгмийн халамжийг санхүүжүүлдэг. Тэгээд үр дүнд нь байнгын алдагдалтай. Алдагдалтай болохлоор өртэй, өр байнгын өсөж байгаа. Өнөөдөр улсын өр 30 тэрбум доллар үнэн шүү дээ. Засгийн газрын өр болохоор 30 их наяд байна гээд.

Үүгээрээ би юу хэлж байна гээд тэгэхээр энэ сонгуулийн систем явах юм бол Монгол Улс хөгжихгүй. Эдийн засаг хөгжихгүй, залуучууд чинь гадагшаа амьдрал хөөж явсан хэвээрээ л байх болно. Яагаад вэ гээд тэгэхээр байнгын алдагдалд өр үйлдвэрлэдэг ийм л систем байгаа юм. Төсвийн бодлого хэзээ ч бодлого байж чадахгүй. Өнөөдөр эдийн засагчид ярьсан төсвийн бодлого байхгүй юм байна гээд. Мөнгөний бодлого хэзээ ч орон зай байхгүй. Макро байдал хэзээ ч тогтвортой байдалтай байж чадахгүй юу үнэн тэр үнэн шүү. Эдийн засагчид бүгдээрээ энэ дээр нийцэж байгаа. Эдийн засаг нь хөгжил сул байх юм бол тэнд ямар юмных нь ардчилал байх юм бэ. Ардчилал байхгүй шүү. Ийм болохлоороо өнөөдөр бид нар бодлого ярьдаг, бодлогыг дэмждэг, бодлогыг кноподдог, бодлогыг санхүүжүүлдэг ийм парламенттай болмоор байгаа юм. Доор хаяж 50 хувь нь энэ улсын 10, 20 жилийн асуудлыг ярьдаг, төлөвлөдөг ийм парламенттай болмоор байгаа юм. Гэтэл Монгол Улсад 10 жил биш 5 жилийн төлөвлөлт байхгүй. 1 жилийн төлөвлөлт буюу төсвөө хүртэл байнга тодотгодог өөрчилдөг, ийм л улс болчихсон шүү дээ. Байхгүй. Ийм болохоор энэ улс орны эрх ашиг юм 1.

Хоёрдугаарт, авлига хээл хахуулын асуудал байна. Хөгжлийн банкны асуудал гарч ирсэн нийтээрээ цочирдсон. Бид нарын хүндэлж авдаг бизнесүүд чинь бүгдээрээ л төрөөсөө авдаг юм байна шүү дээ гээд л бүгд ойлголоо. Дараагийн маш том авлигын асуудал нүүрсний асуудал гарч ирсэн. Хөөе энэ парламент чинь парламент биш юм байна шүү дээ. Парламент 2023 оны хөрөнгө оруулалт гээд шинэ хөрөнгө оруулалт 1.3 их наядыг ярьж байхад тэнд оффтейк гэрээ гээд нууцалчихсан 19 их наядын чинь тэнд зөвхөн 1 төрийн өмчийн компани шийдээд явж байдаг юм байна шүү дээ. Бодитой шүү дээ. Яг л ийм байдлаар өнөөдөр явж байгаа. Яагаад ийм байдалтай явж байна гээд тэгэхээр парламент чинь давжаа байна, парламентын энэ тогтолцоо чинь

буруу байна, тийм болохоор авлига, хулгай дуусахгүй.

Тэр нүүрснээс авсан мөнгөөрөө дахиад сонгогдох ийм чөтгөрийн тойрог дээр байна. Ийм болохоор иргэд маань алсраад байна, ийм болохоор цаашаагаа энэ ардчиллыг авлигыг бууруулъя гэх юм бол энэ тогтолцоог өөрчлөхөөс өөр арга байхгүй. Энэ улс үндэстний хөгжлийн асуудлын дэлхий дээр африкчууд 100 жил хөгжиж чадаагүй юм. Латин америкууд хөгжиж чадаагүй юм, Монгол араас нь явж байгаа юм. Тэгээд тэр улсууд руу та бүгдийг бас очиж үзээсэй гэж бодож байгаа. Би Монгол улсын 21 аймгаар явсан, 330 сумын 280 сумаар ажилласан, очсон, мэднэ. Харин та нарыг хамгийн хөгжил муутай Африкийн 40 хэдэн улсуудаар, Латин Америкийн улсуудаар очиж үзээч гэж хүсэж байгаа юм. Тэнд амьдрал яагаад болохгүй байгаа гэдгийг ойлгох юм бол өнөөдөр та бүгд маань энэ дээр бол санал нэгдэх байх. Тэгэхдээ бүгдэнг нь хэлж байгаа юм биш шүү.

Дараагийн 1 асуудал бол төлөөллийн асуудал байна. Үнэн шүү дээ. Хамгийн мөнгөтэй хүмүүс нь л энд суудаг ийм л тогтолцоо байгаа шүү дээ. Намууд хэнийг дэвшүүлдэг вэ гэхээр хуучин хамгийн нэр алдартай хүмүүсийг онилдог байсан дуучин, бөх юу байдаг юм. Одоо бол хамгийн их мөнгөтэй хүмүүсийг л дэвшүүлдэг болсон шүү дээ. Одоо тэр мөнгөтэй хүмүүсийн хүүхдүүдийг гоё, гоё нэвтрүүлэгт оруулаад л дэвшүүлэх гээд л бэлдээд явж байгаа нь үнэн шүү дээ. Үгүй ээ, тэгээд цаашаа хамгийн мөнгөтэй хүмүүс нь энэ төрийг барьдаг болчих юм бол дундаж давхарга нь яах юм. Жирийн иргэд нь яах юм. Тэнд эмч, багш нарын төлөөлөл байх ёстой биз дээ. Энэ эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай байх ёстой. Яагаад гэвэл 51 хувиас дээш нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байх ёстой. Хаана байгаа юм, байхгүй байгаа биз дээ. Байхгүй байгаа болохоор гадаа чинь жагсаал цуглаан хийгээд байна шүү дээ.

Тэгээд ийм болохоор парламентын чадавхыг өсгөхийн тулд төлөөллийнхөө зарчмыг хангахын тулд өнөөдөр энэ тогтолцооны өөрчлөлт хэрэгтэй.

Иргэдийн 40 хувийн саналыг аваад 80 хувьд нь парламент дүүргэдэг энэ гажиг тогтолцоог өөрчлөх хэрэгтэй. Үгүй бол бид нар хойд Солонгосын араас орно. Ийм болохоор энийг.../минут дуусав/

Н.Энхболд: Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Бид нар яах вэ 1 асуудал ярихаараа л бүр ингээд өмнөхөө бүгдийг нь харлуулаад л, туйлираад байж бас болохгүй. Тогтолцооны өөрчлөлтөөс бүх юм болоод байгаа юм бас биш л дээ. Харин энэ авч явж байгаа энэ 30 жил улс орныг удирдсан улс төрчид тэд нарын чинь алдаа байгаад байна шүү дээ. Тийм. Үнэнийг хэлэхэд яг бодит байдал тийм байна шүү дээ. Хэн нь төрийн толгойд гарахаас, ямар асуудал хийхээс, ямар менежер байхаас маш олон зүйл байгааг бусад улс орон ч гэсэн харуулж байна л даа. Тэгэхээр бид нар энэ дээр бас наанатай, цаанатай хандах ёстой байх. Хамгийн мөнгөтэй хүмүүс Улсын Их Хуралд орж ирээд, энэ жижиг мажоритар болохоор гээд. Том дээр энэ намын жагсаалтын ард дахиад нөгөө олон жил болчихсон нөгөө л саяын тэр Хөгжлийн банк, нүүрсний ард компаниудынх нь нэр нь гарчихсан том томчууд төлөөлөөд оруулаад л ирнэ шүү дээ.

Тэгэхээр энийг жишээлбэл энэ ТББХ бид нар бас л энэ дээр анхаарах ёстой байхгүй юу. Тэрнээс тогтолцоо өөрчлөөд холимог болоод намын жагсаалт дээр дан нийгмийн төлөөлөл, малчин, багш, эмч нарын мундаг мундаг хүмүүсийг шууд шууд оруулаад ирнэ гэдэг бол бас юу л бол. Тэгэхээр бид нар энэ намын жагсаалтад хэнийг оруулах вэ, ямар зарчим баримтлах вэ гэдэг дээрээ хүртэл Сонгуулийн хууль хэлэлцэхдээ одоо Улс төрийн намуудын тухай хууль дээр ч

гэсэн бодолцох ёстой. Энэ бол бодит үнэн шүү.

Одоо жишээ нь намын жагсаалт гэхээр хүмүүс нөгөө л 1 идэж уудаг хачин муу нэртэй хүмүүсийг оруулаад ирэх вий гэдэг шүүмж бол маш их явж байгаа. Энэ үнэн. Өмнө нь дан тэгж байсан. Гэтэл нэг талаасаа ийм ярианы цаана дахиад ёстой сая Доржханд гишүүний хэлдэг шиг мөнгөтэй хүмүүсийн нөгөө 1 хамаг 3 хувийн тэр төрөөс олгож байгаа зээлүүд, Хөгжлийн банк, нүүрс энэ бүхний юм уу эсвэл Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Хөдөө аж ахуйн дэмжих сангаас хэдэн зуун тэрбумаар нь авсан хүүхдүүд нь өнөөдөр тэгээд л жагсаалтын ард мөнгөө төлөөд л ороод ирэх магадлал маш өндөр байна шүү дээ. Та ч өөрөө тэрийг мэдэж байгаа, бид нар ч бас мэдэж байгаа. Тэгэхээр энэ дээр жишээ нь яаж энийг хаах юм бэ тийм ээ, иймэрхүү зүйлүүд дээр бас бодолцохгүй бол энэ чинь бас 2 талтай байгаад байгаа шүү гэдгийг бас хэлье.

Ер нь бол мэдээж улс орон хөгжих төсөв орж ирэхэд 1 жижиг, жижиг тойрог руу байх юм энэ тэр гээд тэгэхгүй. Би түрүүний хэлээд байгаа хот төлөвлөлт, хүн ам зүй, тэр хөгжлийн бодлого энэ тэртэйгээ уяж төлөвлөх асуудал бол маш чухал байгаа. Сая тэр Blue sky-д төсвийн шинэчлэлтэй маш олон эдийн засагчид, улс төрчид, экспертүүд, шинжээчид ирж байна. Тэд нар бас сая яг тэгж л ярьж байна лээ шүү дээ. Саяын 3 хувийн хүүтэй зээл, тэр том том зээлүүдийг харахад бид нарын нөгөө бахархаж, шүтэж, өөрсдийнхөө хүчээр болсон том компаниуд маань л харин тэрийг хүртдэг. Нөгөө 1 жинхэнэ өөрсдийнхөө хүчээр явж байгаа компаниудад юу ч хүртдэггүй тэд нар нь тэгээд л тэдэндээ ингээд идэгдээд дуусдаг юм байна шүү дээ. Тийм учраас л наад төсвийн бодлогоо та нар энэ юугаа өөрчлөөч гээд ярьж байна л даа. Тэгэхээр бид нар ер нь маш сайн энэ бодолцож аль, аль талаас нь ярьж байж ёстой бодлогыг

санхүүжүүлдэг тийм зөв парламент байхгүй бол одоо ингээд л өөр өөрийгөө зарим нь бас бодож байна. Зарим нь бүлэглэлээ бодож байна, зарим нь намаа бодож байна ч гэдэг юм уу тийм маягаар энэ Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намуудын тухай хуульд бол хандаж болохгүй болов уу.

Бүгд л Сонгуулийн хуулийн тогтвортой байдлын тухай ярьж байна шүү дээ. Тэгэхээр энэ заалтуудаа ч гэсэн манай СЕХ-ны дарга, гол албан тушаалтнууд маань сууж байна. Энэ заалт дээрээ та нар маань харин ёстой хөндлөнгөөс маш зөвөөр оруулж ирж, Улсын Их Хурал, ТББХ энэ дээр маш хариуцлагатай хандах ёстой гэсэн байр суурьтай байгаа.

Харин дэвшил бол саяын хэлээд байгаа харин нөгөө төлөөллийн тэнцвэртэй байдлыг хангах, энэ шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг бас гэхдээ чадварлаг, хүчтэй эмэгтэйчүүдийг оруулж ирж байж л энэ яриад байгаа хөгжлийн бодлого шийдэгдэнэ шүү. Тэрнээс биш бас даргын юугаар хөдөлдөг, кнопыг дараарай гэхэд нь дараад сууж байдаг хүмүүс орж ирвэл дараагийн сонгуулиар бүүр энэ жендерийн баланс энэ тэр гэдэг чинь дэмий юм байна гээд энэ сайхан хөгжлийн тогтолцоог унагаах юмыг өнөөдөр та бүхэн бас хийчих вий дээ, сайн анхааралтай байгаарай гээд жишээ нь НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн туршилагатай орны шинжээчид өчигдөр энэ тэр ярьж байгаа юм. Тэгэхээр энэ бүх зүйлүүд дээр бид бас сайн бодолцох ч, ёстой нөгөө 7 хэмжигч 1 огтол гэдгээр асуудалд хандах нь зөв болов уу гэсэн байр суурь байна. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа Пүрэвдорж гишүүн нэрээ татаж байгаа юм байна. Ингээд хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Одоо санал хураана. Саналаа хураая, анхааралтай байгаарай гишүүдээ. Хангалттай байна уу? Монгол

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Пүрэвдоржоо хүлээж байгаарай. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэд хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд байна уу? Тэрнээс хэд байна вэ, манайх. Санал хураалт явуулъя, гишүүд анхааралтай байгаарай. Гишүүдээ харууцлагатай санал хураалт, туршилтын санал хураалт явуулчихъя. Тест. Манай Байнгын хороонд харьяалагддаг 15 гишүүн байна, бүгдээрээ нэрээрээ байна уу? Амарсайхан, Баатарбилэг, Занданишатар. Санал хураалт явууллаа шүү, анхааралтай байгаарай.

Хуулийн төсөл хуулийн болон тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт, санал хураалт анхааралтай байгаарай. Эднийхэн өөрснөө эсэргүүцэж байгаа юм байлгүй дээ. 15 гишүүн санал хураалтад оролцож, 9 гишүүн дэмжиж, 60 хувиар хуулийн төсөл, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн дүн гарч байна. Нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Сарангэрэл гишүүн танилцуулчих уу?

16.43 цаг

Хоёр.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 2 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Энэ төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл, Ганбат нарын гишүүд 23 оны 4 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Хууль санаачлагчийн илтгэлийг Цогтгэрэл гишүүн тавья. Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн нэр бүхий гишүүд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийн төслийг бэлтгэн өргөн барьсан. Бидний боловсруулсан уг хуулийн төслийн ерөнхий агуулга ач холбогдлыг дараах байдлаар тоймлон илэрхийлж байна.

Нэгдүгээрт нь, Монгол Улсын нэгдсэн бодлого гаргах, хөгжлийн нэгдсэн төлөвлөлт нэгдсэн байх энэ үндэс суурийг бүрдүүлнэ.

Хоёрдугаарт нь, сонгуулийн хамгийн сонгуулийн санал хамгийн багаар гээгдэх пропорциональ элементийг оруулж өгсөн.

Гуравдугаарт нь, жендерийн тэгш байдлыг чухалчлан хүйсийн квотыг үлэмж нэмэгдүүлсэн.

Дөрөвдүгээрт нь, олон нам нар парламентад орох үүд хаалга нээгдэнэ.

Тавдугаарт нь, шударга сонгууль явагдах нөхцөл бүрдэнэ.

Зургаадугаарт нь, гадаадад байгаа Монголчууд санал өгөх, Монголчуудын санал өгөх эрх баталгаажна.

Долоодугаарт нь, сонгууль хийх, нэр дэвших, дэвшин сонгогдох зардлыг бууруулах, эмэгтэйчүүд, залуучууд Их

Хуралд сонгогдох боломж бас нийгмийн төлөөллүүд сонгогдох боломж бүрдэнэ.

Өнгөрсөн 8 удаагийн Улсын Их Хурлын сонгуулийн 7 нь мажоритар системээр явагдсан. 2000 оны ээлжит сонгуулиар нийт сонгогчдын 51 хувийг авсан тухайн үеийн МАХН Их Хурлын суудлын 76 суудлын 72 буюу 95 хувийг авч байжээ. Тэр үед нийт сонгогчдын 24 хувийг авсан АН 1 суудал авч байж. 2016 онд нийт сонгогчдын 46 хувийг авсан МАН Улсын Их Хурлын 65 суудал буюу 85 хувийг, харин нийт сонгогчдын 34 хувийг авсан АН 9 хувийн суудал авч байж. Харин одоогийн парламент буюу 20 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд сонгогчдын 45 хувийг авсан МАН нийт суудлын 82 хувийг буюу 62 суудал авч байсан бол нийт сонгогчдын 24 хувь авсан нь АН 11 суудал авчээ. Энэ мэтээр сонгуулийн үр дүн савлаж, иргэд сонгогчдын санал гээгддэг муу жишиг мажоритар тогтолцоонд бас ихээр агуулагддаг. Ийм учраас АН-ын бүлэг сонгуулийн тогтолцоонд пропорциональ элементийг оруулах шаардлагатай гэж бас уг нэмэлт, өөрчлөлтийн төсөлд голчлон тусгалаа.

Мөн иргэдийн дунд очих нүүргүй, ирэх эрхгүй улс төрчид намын жагсаалтад нуугдаж үүдээр гаргасныг тооноор оруулж ирдэг гэдэг хардлага эргэлзээ байгаа тул жагсаалтаар сонгогдох гишүүдийн тоог 28 байх, мөн тэдгээрийг хаалттай хүрээнд жагсаах бус иргэдийн саналаар нээлттэй эрэмбэлж өгөхөөр бас заасан. Ийнхүү 2012 оны Улсын Их Хурлын сонгууль явагдсан жишгээр томсгосон тойргоос 48, намын жагсаалтаар буюу ард иргэдээс эрэмбэлэгдсэн 28 гишүүн байхаар хуулийн төсөлд өргөн барьсан. Дан мажоритар тогтолцооны 1 сул тал нь сонгох сонгогдоход санал гээгдэх явдал байдаг бол сонгогдсоны дараа тойргийнхоо асуудлыг шийдэх эрэлт хэрэгцээний үүднээс олон улсын нэгдсэн хөгжлийн бодлого гаргах, мөрдүүлэхэд

тодорхой хэмжээгээр саад тотгор бий болох явдал байгааг бас тодорхой хэмжээнд сааруулахад намын жагсаалтад нөлөө үзүүлнэ гэж бас харж байгаа.

Жендерийн тэгш байдал бол зөвхөн аль 1 хүйс, хэн нэгэн хүмүүсийн тухай асуудал бас биш. Энэ бол нийгмийн асуудал, хөгжлийн шалгуур үзүүлэлт, ардчиллыг тодорхойлох хамгийн чухал үнэлэмжүүдийн 1 болсон. Ийм учраас төлөөлөл хангагдахгүй байгаа бүлгийн эрхийг хангах, төлөөллийг нэмэгдүүлэх нь тогтвортой хөгжилд хүрэх боломж гэж дэлхий нийтээрээ үзэж байна. ОУПХ-ны нэгдсэн мэдээллээс үзэхэд 21 оны байдлаар нийт улс орнуудын парламентад эзлэх эмэгтэйчүүдийн хувьд дунджаар 26 хувь байхад Монголд 16 орчим хувь байна. Энэ нь бас Ази тив болон бүс нутгийн дунджаас доогуур үзүүлэлтэй. АН-ын бүлгийн зүгээс хүйсийн квотыг зөвхөн эмэгтэйчүүдийг албан тушаалд дэмжих тухай асуудал гэж үзэлгүйгээр асуудлыг том зургаар харах, харах цаг нь болсон гэж үзэж эмэгтэй квотыг бас 40 хүртэл, 40 хувь байх нь зүйтэй гэж бас үзэж байна.

Сонгуулийн тогтолцоог зөв сонгохоос дутуугүй ач холбогдолтой 1 зүйл бол сонгуулийг шударгаар явуулах нөхцөлийг бүрдүүлэх. Ийм учраас сонгуулийн үеийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэл хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс хэрэв цөөнхийн бүлэг байхгүй бол цөөнхийн гишүүдээс гэх зэргээр хуульчлан зааж өгөхөөр тусгалаа. Жил бүр өсөн нэмэгдэж буй гадаадад өсөн нэмэгдэж буй гадаадад сурч суурьшин буй иргэдээ Монгол төрийн сонгуульд оролцох боломжийг бүрдүүлнэ. Тухайн улсынхаа ЭСЯ-нд очин намын жагсаалтад дэвшсэн нэр дэвшигч болон намдаа намд санал өгөх боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр олон намын төлөөлөл Улсын Их Хуралд дэвших сонгох боломж бодитоор

бүрдэнэ. Энэ нь сонгуулийн зардлын босго зардлын өндөр босгыг буулгана, олон бүлгийн төлөөлөл Улсын Их Хуралд парламентад бодитоор сонгогдох замыг нээж өгч байна гэж бид бид үзэж байгаа.

Улс орны эрх ашгийг эрэмбэлэн үзэж, олон улсын жишгийн дагуу пропорциональ элементийг тусган өгсөн, парламентын гаднах намуудад бас боломж олгосон, жендерийн тэгш байдлыг чухалчилсан бидний өргөн барьсан Улсын Их Хурлын энэ Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэн шийдвэрлэж өгнө үү.

Н.Энхболд: Цогтгэрэл даргад баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэлээс асуух гишүүд байвал нэрээ өгье. Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Баярлалаа би төсөл санаачлагчаас 1 хэдэн асуулт асууя. Яах вэ би төсөл санаачлагчийн сая хэлсэн үгэн дотор гарч байгаа зүйлтэй санал 1 байгаа юм. Энэ нь юу вэ гэхээр холимог тогтолцоо орж ирж байж санал гээгдэхгүй, сонгогчийн санал гээгдэхгүй байх энэ асуудал бүр 2000 оноос л хойш яригдсан. 2000 оны сонгуулиар тухайн үед олонх болсон нам нийт сонгогчдын тавин дөрөв, таван хувийг аваад 70 хэдэн суудал авсан л гэдэг энэ асуудлаас эхлээд л ерөөсөө маш ихээр энэ санал гээгддэг тогтолцоогоор бид явж байна гэж үзээд 12 онд холимог тогтолцоог анх оруулж ирсэн. Тэгээд тэр үед ямар зүйлүүд ажиглагдаж байсан бэ гээд би тэр үед орон нутагт ажиллаж байсан. Тойргийн иргэд сонгогчидтойгоо ирж тойргоос сонгогдсон гишүүд нь уулздаг. Нөгөө хэд нь тойрог дээр давхар ачаа үүрдэггүй гэдэг ийм сөрөг зүйлүүд яригдаж байсан.

Одоогийн түрүүчийн манай намаас оруулж ирж байгаа төслийн агуулга бол 50, 50 байя. Өөрөөр хэлбэл, тойргийн том бодлого, тойргийн бодлого

ч төрийн бодлогод тусгаг, улс орны томоохон төсөл хөтөлбөрүүд ч гэсэн яг адилхан байдлаар төрийн шийдвэр болж гарах ёстой гэдэг агуулгаар л оруулж ирсэн. Тэгэхээр та хэдийн төсөл дээр 1 бид нарын 12 оныхоо нөгөө 28, 48 гэдэг хувилбарыг оруулж ирж байгаа нь бид нар яг л ийм ялгамжтай байдал том бодлогын асуудал гээгдэх ийм сул тал гарах юм биш үү? 12 оны тэр Сонгуулийн хуулийн хэрэгжилт дээр та бүхэн маань хэр ажилласан юм бэ гэдэг 1 асуулт байгаа.

2 дахь асуулт нь би Бат-Эрдэнийг СЕХ-ноос Бат-Эрдэнэ бид хэд нөгөө 20 оны сонгуулийн дараа хууль батлагдсаны дараа аягүй олон дефектүүд гарч ирсэн шүү дээ. Энэ сонгуулийн хууль чинь өөрөө дандаа процесс. Процессууд дээр бид нар маш олон алдаанууд гарч ирж байсан. Тухайлбал сая Одонтуяа гишүүн ч гэсэн хэлж байна лээ. Энэ нэгдсэн самбартай больё. Тэр чинь Сонгуулийн хуулийг бид нар хэрэглэж байгаа хэр нь алдаанууд гаргаад байдаг. Хаана, хэн, ямар байршилд байхыг тухайн иргэдийн хурал нь л 1 тогтоол гаргадаг. Тэр нь ерөнхий тойм байдлаар явчихдаг. Тэгэнгүүтээ хэн түрүүлж очиж хөрөнгө мөнгөтэйнүүд нь том самбарууд тэр зай нэрлэсэн талбайг дүүргэж чадсан нь юуяадаг тийм ээ, илүү өөрсдөдөө давуу байдал болдог. Гэтэл бид нар ингээд Европын холбооны сонгуулийг ч харж байсан. ХБНГУ-ын сонгуулийг ч харж байсан. Яг тодорхой тоонд яг нэр дэвшиж байгаа хүмүүсийг яг ижил хэмжээний боломжууд олгодог.

2 гэвэл нөгөө сонгуулийн соёлд суучихсан зүйлүүд харагдаж байгаа л даа. Тэгэхээр би Бат-Эрдэнийг яг энэ хууль санаачлагчийн санаачилж байгаа хуультай холбоотойгоор нөгөө бид нарын процесс дээр алдсан алдаануудыг энэ 2 төсөл дээр ер нь суулгаж чадсан уу? Өөрөөр хэлбэл бид нар 1 алдаагаа 2 алдмааргүй байгаа байхгүй юу.

3 дахь зүйл болохоор бид нар яг энэ хувилбараар явбал цаашид тэр ҮХЦ-ийн дүгнэлтүүд ч байгаа. Гишүүдийн тооны асуудал дээр Цогтгэрэл гишүүн яг ямар байр суурьтай байгаа юм бэ? Би Их Хурлын гишүүн болгонд энэ ордны номын санд 1 ирж байгаад 1991 онд Үндэсний дэвшлийн намаас хийгдсэн гишүүдийн тоо судалгаатай холбоотой материалыг хэвлүүлээд тараасан. Та хэд тэрийг үзсэн үү, үгүй юу? Тэрэн дээр бид нар 92 оны Үндсэн хуулийн төсөл дээр одоогийн 76 гэдэг тоо төсөлд тусахдаа нийтдээ 1-2 сая хүн амтай улс орнуудын парламент болон зөвлөх парламентуудын жишигээс жишиглэж байгаад 70-80 байдаг юм гэдэг ийм дүгнэлтэд хүрч Их Хурлын гишүүдэд тэр бас гарын авлага болж очиж байсан байгаа юм.

Одоо бид нарын сонгогчийн тоо ирэх жил нийт хүн амын тоо ирэх жилийн мөн үе гэхэд бараг 3.5 сая 3000520 орчим мянгад хүрэхээр байгаа. Энэ жилийн хүн амын өнгөрсөн жилийн өсөлт бол 60 хэдэн мянга болсон байна лээ. Ингээд харахаар бид нар гурав аравны.../минут дуусав/

Д.Тогтохсүрэн: 1 минут чинь нөгөө дараа нь тодруулгын дараа асуултад хариулсны дараа дэгээрэй явна. Би Нямбаатар гишүүнийх дээр нөгөө 2 төсөл хамтарсан учраас 1 зүйлийн хариулт өгье. Та нөгөө 1 энэ сонгуулийн хуулийн хариуцлагын тогтолцоотой холбоотой юмнуудын талаар юу орж ирэв гэсэн юм асуугаад байна. Тэгээд үгүй ээ үгүй, таны санаа бол тийм байсан юм. Тэгээд бид нар ийм тогтоолын төсөл өргөн барьчихсан юм. Нямбаатар гишүүнээ ийм тогтоолын төсөл та сонсоорой. Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан сонгуулийн зардлын ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг хангах, сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа боловсронгуй

болгох чиглэлээр Эрүүгийн хууль, Эрүүгийн хууль хэрэг хянан шийдвэрлэх хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг 23 оны 12 дугаар сарын 31-ний дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай гэсэн тогтоол гаргачхаж байгаа. Тэгээд энүүгээр би таныг бид нарын нөгөө энэ Сонгуулийн хууль гараад ирсний дараа энэ Сонгуулийн хуультай холбогдуулж энэ хуулиудын өөрчлөлтийг оруулж ирнэ гэсэн үг. Таны яриад байгаа санаа ийм байна гэж ойлголоо. Тийм. Эхлээд Цогтгэрэл гишүүн хариулна, дараа нь Бат-Эрдэнэ хариулна.

О.Цогтгэрэл: Нямбаатар гишүүний асуултад хариулъя. Ерөнхий санаа нь яагаад 48, 28 бэ, яагаад мажоритар нь их байгаа юм бэ энэ чинь өмнө нь бас явсан шүү дээ гэдэг утгатай гэж эхний асуултыг ойлгосон. Ер нь энэ дээр 2, 3 үндэслэл бид нар бас хоорондоо ярилцсан. Нэгдүгээр үндэслэл нь ер нь бас заримдаа ингээд тайлбарлахдаа мажоритараас гарсан гишүүд зөвхөн тойргийн эрх ашиг боддог гэдэг 1 ийм үзэл бодол, тайлбар маш их давамгайлдаг. Энэ бол бас арай хэтэрхий бас өрөөсгөл тайлбар, өрөөсгөл бодол. Бид нар бол Монгол Улс 30 жил Монгол Улс 30 жил явж ирлээ. Зөвхөн тойргийн асуудал гэж бас тэгж гишүүдийг би явцуурдаггүй байх гэж бодож байгаа юм. Бас Монгол Улсын эрх ашигт юу нийцэж байна гэдэг дээр. Тэгэхээр энэ Үндсэн хуулиараа ч гэсэн тойргийг биш бүх ард түмний бас элч төлөөлөгч гэдэг үг цаана нь явж байдаг. Тэгэхээр нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь иргэд Монгол Улсын иргэд өнөөдөр яг жагсаалт гэдэг зүйл дээр хэр зэрэг бэлэн байна вэ? Энэ нь их байх, тэнцүү байх хэмжээнд иргэдийн санаа бодол яг өнөөдөр бэлэн байна уу, үгүй юу гэдэг дээр бид нар бол бас арай өөр бодолтой буюу 2 дахь шалтгаан нь.

Гуравдугаарт нь аливаа сонгуулийн тогтолцоог судлаачид олон хүмүүс хэлэхдээ ер нь сайн, муу гэж тогтолцооноос урьдаад тухайн тогтолцоо тогтвортой явж хэрэгжиж байж үр дүн нь илүү сайн гардаг. Тэгэхээр 12 онд авсан нь мажоритар нь тодорхой хэмжээгээр давамгайл тэгэхдээ бас харьцангуй түрүүний тэр зарим улсынх дээр гардаг шиг биш, үндсэндээ энэ чинь 60, 40-ийн харьцаа 63, 47-гийн л, 37-гийн л харьцаа байгаа шүү дээ. Тийм харьцааны хувьд энэ 2 бол тийм бага зэргийн зөрүү буюу 48, 28 илүү зохистой гэж энэ дээр ингэж үзэж үзсэн.

Хоёрдугаарт нь, тэр Нямбаатар гишүүний асуултад бас гарч байна. Ер нь парламентын гишүүний тоон дээр ер нь ямар бодолтой байдаг вэ гэж. Энэ дээр дахиад 2 зүйл байгаад байгаа юм. Нэгдүгээрт нь, ер нь иргэдийн санаа бодлыг бас энэ дээр мэдээж Үндсэн хууль өргөн баригдаад явбал иргэдийн санаа бодлыг сонсох ёстой гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт нь, ер нь тоон дээр хүүхэд хэдий жижижсэн байсан ч гэсэн бүхий л эд эрхтэн нь хүүхэд хүүхдүүд байдаг. Том хүнээс жижижсэн гээд тал нь байдаггүй бас биш шүү дээ 2 бөөртөө, уураг тархитай, бүх зүйлтэй л байдаг иж бүрэн байх ёстой. Тэгэхээр энэ 2 зүйлийн баланс тэнцвэр дээр асуудал явах ёстой байх. Ямар ч байсан иргэдийн санаа бодол чухал. Тэгэхдээ тоо жижиж улсын парламент жижижсэн байх ёстой гэдэг бодлого цаана нь бас байх ёсгүй байх гэсэн. Тэгээд энэ бүгд дээр бодлогын шийдлүүд мэдээж гарч таарна л гэж бодож байгаа. Хууль санаачлагчийн хувьд Ганбат гишүүн бас зарим зүйлийг нэмж хариулъя.

Д.Тогтохсүрэн: Хууль санаачлагч Ганбат гишүүн хариулт өгнө, нэмэлт хариулт.

Д.Ганбат: Нямбаатар гишүүний асуултад хариулъя. 2012 оны сонгуулийг та ярьж байх шиг байна. Та орон нутагт ажиллаж байсан байна. 2012 оны сонгууль бол тойрогт 50, жагсаалтаар 26 байсан. Манай АН-ын бүлгээс бид 2-ын зүгээс өргөн барьж байгаа энэ хууль бол 48, 28 гэж авч байгаа. Энэ дээр юу хэлэх вэ гэхээр 48 нь яагаад Ардын намынхаас өөр байна вэ 38, 38 биш байна вэ гээд асууж байх шиг байна. Энэ түрүүн тэр Занданшатар гишүүний яриад байдаг тэр нутаг дэвсгэрийн төлөөлөл. Манай Монгол улс чинь өргөн уудам нутаг дэвсгэртэй ийм. Тэгэхээр аймаг орон нутгаа төлөөлсөн нь энэ нь ахиу байх ёстой, хотоос төлөөлсөн нь ахиу байх ёстой гэж бид нар үзэж байгаа.

Нөгөө талаар бол улс орны хэмжээнд тооноор орж ирдэг, хатавчаар орж ирдэг гээд л ярьж байна. Ард түмний сонголтээр орж ирдэг. Манай бид 2-ын өргөн барьсан хууль дээр бол бүгдийг нь л сонгогчид шийднэ. Хэн нь хаана жагсах юм, тэр жагсаалтад байгаа 28 хүн маань бүх ард түмний саналыг авч байна шүү дээ. Тэгж байж орж ирнэ. 2 сая сонгогч байгаа бол тэр 28 сонгогчийг нь намууд жагсаагаад аваад ирлээ, хэн хэнийг нь дугуйлах юм тэрийг нь бол шууд саналаа өгөөд ингээд ингэчих болохоор тэр нь ч бас давуу талтай, орон нутгаа ч төлөөлнө, улсын хэмжээнд ч ажиллаж чадна ийм нөхцөл байдалтай юм.

Энэтэй холбогдуулаад нэг юм хэлэхэд бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн өнгөрдөг 2022 оны 8 сард. Одоо бол ийм л болчихсон шүү дээ. Энэ давжаа парламентад давхар дээл өмсгөчихсөн. Ард түмэнд хамгийн ашиггүй юмнуудыг бид нар хийчихсэн. Тэр манай Адьшаа гишүүн бас нэлээн зөв шүүмжилж байх шиг байна лээ. Үндсэн хууль чинь хууль тогтоогоод байгаа юм уу, яагаад байгаа юм гээд. Үгүй ээ энэ хууль тогтоогчид өөрснөө хуулиа тогтоож болохоор байтал ҮХЦ рүү аваачаад шидчихсэн. Тэрийг нь 4 гэсэн

тоог нь аваад хаячихсан ийм л юм болсон. Одоо бол энэ маягаараа цаашаа явж болохгүй болчихсон. 76-хан хүн дотор 20 хүн нь сайд болчихсон ийм маягтай ажиллаж байгаа. Тэгээд энд бол олон түмэн маш их дургүй байгаа. Тэгээд олон намын системтэй бид нар. АН бол олон ургалч үзэл олон намын системийг ямагт дэмждэг. Тэгээд аль болохоор олон намууд орж ирээсэй гэсэн ийм бодлын үүднээс бид нар хандаж байгаа. Тийм.

Н.Энхболд: Зассан юу байна гэж үү? Бат-Эрдэнэ 2 номер ажлын хэсэг.

Д.Бат-Эрдэнэ: Нямбаатар гишүүний асуултад хариулъя. Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Нямаагийн Энхболд гишүүнээр ахлуулсан ажлын хэсгээс өргөн барьсан хуулийн төсөл дээр бол СЕХ-ноос санал өгч, мөн боловсруулах дээр бол орж ажилласан байгаа. Хуулийн төсөл үндсэндээ яг 2 хэсэгт хуваагдаж байгаа. Нэгдүгээр хэсэг нь бол яг сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны процессын шинжтэй өмнөх сонгуулиудаар гарч байсан алдаа хийдлийг яаж засаж залруулах вэ гэдэг талаар бол цэвэр процессын шинжтэй зохицуулалтыг хийж өгсөн. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хамгийн гол онцлог бол нэг нэгнээсээ харилцан уялдаатай процессын ийм үйл ажиллагаа учраас ямар нэгэн алдаа гарах эрхгүйгээр зохион байгуулах ийм онцлогтойгоор явагддаг үйл ажиллагаа. Тийм ч учраас өмнөх буюу 2020 оны Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулж явуулсан туршилага, алдаа дутагдлаас үндэслээд тэр зохицуулалтуудыг бүрэн хэмжээнд бол тусгасан гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт нь нэгдсэн самбартай холбоотой асуудлыг 2019 онд батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэлэлцэх үед СЕХ-ноос бас санал өгсөн. Энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах явцад бас СЕХ-ноос санал өгсөн. Нэгдсэн самбарын хувьд бол сонгогчдод ойлгомжтой мөн дээрээс

нь гудамж талбайд олон самбар байрлахгүй байх ийм давуу тал ач холбогдол байдаг боловч нөгөө талаараа энэ дээр бол энийг зохион байгуулалтын хувьд бол бас улсын төсвөөс тодорхой хэмжээнд зайлиггүй зардал гаргах ийм шаардлага бол үүсдэг юм байна лээ. Тэгэхээр энийг зарчмын хувьд шийдэх юм бол СЕХ-н дээр бол томъёолол бэлэн байгаа гэж хэлэх байна. Баярлалаа.

Н.Энхболд: Нямбаатар сайд тодруулъя. Микрофоныг өгье.

Х.Нямбаатар: Их Хурлын гишүүдээ би 1 хуулийн заалтыг та хэдэд уншаад сонсгоё. Энэ Энхболд дарга би ялангуяа танд бүр хандаж хэлэх гээд байгаа юм. Энэ 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр бид нар 1 ийм заалт оруулчихсан юм. Тэр нь юу вэ гэхээр 21.4-д Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын тухай, Сонгуулийн тухай хууль батлах түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж байгаа юм. Энэ окэй.

Гэтэл энэ хууль магадгүй таны өргөн барьсан эсхүл Цогтгэрэл гишүүний нарын өргөн барьсан аль, аль төслүүд нэгдэж нийлээд ингээд бид энэ хуулийн хугацаандаа хуулиа баталчихна. Гэтэл энэ хууль батлагдсаны дараа хэн 1 иргэн ҮХЦ-д хандаад энэ Сонгуулийн хууль нь Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөж байна гэвэл бид яах вэ? Өөрөөр хэлбэл Үндсэн хуульд ҮХЦ-ийн шийдвэрээр.../минут дуусав/

Н.Энхболд: Цогтгэрэл гишүүн хариулъя.

О.Цогтгэрэл: Нямбаатар гишүүний асуултыг би буруу ойлгосон байж магадгүй шүү. Мэдээж аливаа хууль Улсын Их Хурал хууль тогтоох эрх бүхий байгууллага. Улсын Их Хурал хууль тогтоолоо, хуулиа эцэслэн шийдвэрлэж

гаргалаа. Энэ дараа дараагийн процесс ҮХЦ-ийн болоод уул нь мэдээж энэ бүгд Үндсэн хуульд өөрт нь зориулсан л харилцаа шүү дээ. Өмнөх сонгуулиудын үед ч гэсэн сонгууль эхлээд явж байлаа, сонгуулийн жил эхэллээ. Тэр үед ҮХЦ дүгнэлт гаргавал яг ямар журмаар юм. Тэрнээс өмнөхөөс өөр нөхцөл байдал энд үүсэхгүй байлгүй дээ л гэж бодож байна. Уламжилж ирсэн харилцаанаас өөр нөхцөл, шинэ нөхцөл байдал.

Н.Энхболд: Тийм. 20 оны сонгуулийн өмнө ийм явдал болсон, тийм. Тэгээд жишиг гарвал тухайн үед нь тэгээд Цэцийн дүгнэлтийг бид нар яаж хэлэлцэх ёстой юм тэрний дагуу, үгүй ээ тийм, тийм л дээ. Тийм. Цэцийн дүгнэлтээ хэлэлцээд ингэж л бодож байна Нямбаатар гишүүнээ. Цэцийн дүгнэлт яаж гарах нь вэ нэгдүгээрт.

Хоёрдугаарт Цэцийн дүгнэлтийг хэлэлцээд Их Хурал хүлээж авах уу, үгүй юу гэдэг асуудал байна. Хүлээгээд одоо жишээ нь хууль зөрчсөн байна Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн дүгнэлт гарчихвал тэрэнд нь эрх зүйн ямар нэгэн зохицуулалт байхгүй байгаа бол тэр үед нь л асуудлыг шийдэхээс өөр аргагүй болно шүү дээ. Тийм. Ойлгосон, ойлгосон. Хуулийн зөрчлийг арилгах ямар нэгэн арга хэмжээ аваад л Цэцийн дүгнэлтийг хэлэлцсэнийхээ дараа ямар шийдвэр гарсан тэрэндээ нийцүүлсэн хуульдаа зохицуулалт хийх ийм л дараагийн арга хэмжээ авах шаардлага гарах байх. Яг өнөөдөр хариулахад. Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Сонгуулийн үеийн зардлыг бууруулах тал дээр Ганбат гишүүн, Цогтгэрэл гишүүн нарын өргөн барьсан хуулийн төсөлд хэрхэн яаж тусгасан байгаа вэ? Ер нь мөнгөний хүчин зүйлийг хэрхэн яаж бууруулах вэ энэ тал дээр та бүхний байр суурь ямар байна вэ гэж нэг.

Хоёрдугаарт, миний асуулт бол түрүүний Нямбаатар сайдынхтай

адилхан. 38, 28 гэдэг 28, 48 гэдэг тоог ер нь та бүхэн маань ямар тооцоо үндэслэлээр гаргаж ирэв? Дээр нь гишүүдийн тоог нэмэх тал дээр ямар байр суурьтай байгаа вэ? Энэ дээр та бүхэн маань саяын хэлсэн үндэслэлээс гадна нэмж тайлбар хийх боломж байна уу? Тэгээд тодруулъя би.

Н.Энхболд: Хэн хариулах вэ? Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Өмнө нь өмнөх гишүүний асуултад яг л энийг л асуусан л даа. Яагаад мажоритар нь их байгаа юм бэ? Дахиад л хэлэхэд бид нар энийг бас бүлэг дээр олуулаа ч ярилцсан. Хууль санаачлагчийн хувьд Ганбат гишүүн бид 2 ч бас ярилцсан. Ер нь тодорхой хэмжээнд тэгэхдээ энэ 48, 28 гэдэг чинь өөрөө хэт тийм зөрүү тоо бас биш. Үндсэндээ 60, 40 гэдэг тоо. Тэгээд тодорхой хэмжээнд Монгол Улс маань сийрэг нутагишилтай, газар нутагт том, орон нутгийн төлөөлөл гэдэг зүйл. Тэгээд энэ бүгдийн цаана нөгөө талаасаа ажлын хэсэгт орсон гишүүдийн өргөн барьсан хуулийн төслөөр 50, 50 байхгүй болохоор том бодлого явдаггүй гээд байгаа юм. Яг үнэхээр тойргоос гарч ирсэн гишүүд үнэхээр улс орноо боддоггүй гэж бас хэлэх нь бол арай л хэтийдүүлсэн хэрэг болно. Яг өнөөдрийн хувьд бас 1 бодит юм чинь 1 хэдийгээр гоё зүйл байдаг ч гэсэн амьдралтай зүйл гэж бас байдаг. Бодитой зүйл. Яг бодитой нь бол Монгол шиг орны хувьд бол ийм 60, 40, 50, 50 биш 60, 40 байх нь өөрөө тийм нэг ухарсан ухралт юм шиг энд харагдахгүй л гэж үзэж байгаа юм.

Тэгээд бусад зүйлүүд бол дахиад л яг адилхан. Тэр байтугай бүүр 1 удаа өмнө нь хэрэглэчихсэн хуулийг дахиад ер нь төгөлдөржүүлээд хэрэглэхэд илүү ард иргэдэд болоод бүхий л талаараа ойлгомжтой. Дахиад дээрээс нь судалгааны дүнгүүд, сонгуулийн дүнгүүдэд анализ хийсэн ч гэсэн их олон

талын давуу талууд энэ дээр бас бий болох учраас ер нь сонгуулийн тогтолцоогоо дахин 1 удаа ухралт хийсэн тогтолцоогоо ер нь авч ашиглах нь өөрөө тийм илүү давуу тал гарах гарна л гэж бид нар бодож байгаа.

Д.Ганбат: Би нэмчих үү?

Н.Энхболд: Ганбат гишүүн хууль санаачлагчийн хувьд нэмж тайлбар хийе.

Д.Ганбат: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Би сүүлээс нь эхлээд хариулаад явчихъя. Тэр тоо. Тоо бол гарцаагүй болчихоод байгаа юм л даа. Тоо нэмэх нь зөв байх. Яагаад гэвэл энэ парламент маань өөрөө давжаа парламентад давхар дээл нөмрүүлчихсэн гэдэг. Энэ буруутан нь Доржханд л болоод байх шиг байна шүү дээ тийм үү. Энэний ар талд нь мэдээжээр эрх баригчид байсан. Хамаг муу муухай юмаа Доржханд, Одонтуяа хоёроор хийлгэхээд л, тэгээд л ингээд л үлдсэн. Би та нарыг ярьж байхад би дуугүй байдаг шүү. Ингээд энийг тоог нь нэмэхээс гарцаагүй болж байгаа юм.

Хэрэв нэмэхгүй бол энэ маягаараа цаашаа үргэлжилж чадахгүй. Гудамжинд талбай дээр жагсдагаараа хүмүүс жагсдагаараа л жагсана. Яагаад гэвэл энэ 76 хүн дотор нөгөө хариуцлага тооцож чадахаа байчхаж байгаа юм Засгийн газартайгаа. Ард түмнээс сонгогдсон парламент маань өөрөө ард түмний төлөө зүтгэх Засгийн газрыг байгуулахдаа мэдээж хэрэг хариуцлага тооцохуйцаар тийм хүмүүстэй байх ёстой. Нөгөө талаар бол тоо нэмэх нь бол өнөөгийн улс төрийн, геополитикийн нөхцөл байдал, бас хүн ам өссөн, анх 76 гишүүнтэй анхны Үндсэн хуулийг баталж байхад бид нар чинь нэг хоёр сая хүнтэй байлаа. Саяхан сонгогчтой байсан. Одоо бол 3 сая 500. Бид нар дараагийнхаа 5, 6 жилийг харах хэрэгтэй байх, 10 жилээр харж хуулиа батлах хэрэгтэй.

Манай Цогтгэрэл гишүүн түрүүн ярьж байна лээ. Улс шиг улс байя. Жижиг улс гээд бид нар жижиг бодлого байх ёсгүй, жижиг парламент байх ёсгүй. Яг хүн амынхаа тоонд нийцсэн ийм тоотой байх нь зөв. Тэр нь хэд байх ёстой юм. Мэдээж хэрэг тэрийг дараа ярих байх. Өнөөдөр бол тэр жагсаалт орон нутгаас сонгогдох мэдээж хэрэг бид нар бэлчээрийн мал аж ахуйтай, Монгол Улс 1,5 сая хавтгай дөрвөлжин километр нутагтай. Энэ төлөөлөл нь орж ирэхгүй бол энэ бүх юм чинь өв уламжлал энэ тэр юм чинь болохоо байна. Тэр хамгийн захын сумд байгаа Увсын Тэс сумд, Баянхонгор аймгийн тэр Баянлиг энэ сумд очиж малчидтай уулздаг, санал бодлыг нь сонсдог ийм төрийн төлөөлөл нь байх ёстой. Гэхдээ бид энэ жагсаалтыг хийхдээ тэр дээр үеийнх шигээ хавтгайруулж болохгүй. Баахан.Италийн парламентыг бид нар мэднэ тийм ээ. Тэрэн шиг одоо хэрэв нам нь мэдээд жагсаах ёстой юу, ард түмэн нь ингээд тэрийг эрэмбэлэх ёстой юу. Тэгэхгүй бол нам нь мэдээд жагсаавал аягүй л бол нэр хүндтэй нөгөө биеэ үнэлэгчид ч гэсэн орж ирэх нь байна шүү дээ. Италийн парламент тэрүүгээрээ бол цуутай шүү дээ. Тэр юмыг нь хаасан барьсан тэр бодлого явуулахын тулд тооноор хатавчаар орж ирсэн гэсэн юм байх ёсгүй.

Тэр гадаадад байгаа 200000 иргэн нь бас өөрсдийгөө төлөөлөх хүмүүсээ сонгог. Тийм учраас жагсаалтыг эрэмбэлэх, нэрсээр нь санал өгөх юмыг бол сонгогчид өөрсдөө шийдэг гэж бид бүхэн шийдсэн юм. Тэр 12 оных шиг хаалттай биш, нам нь жагсаадаг биш, ийм нээлттэй жагсаалт байя гэхээр энэ бүх юмнууд нь байхгүй болчихно. Тэр тоогоо бол өнөөгийн нөхцөл байдал ярих байх. Ингээд жагсаалтыг хийгээд, эмэгтэйчүүдийн квот 40 болоод ирэхээр энэ зардал чирэгдэл бол хэмнэгдэнэ. Ийм их мөнгө төгрөг тараадаг юм байхгүй болно гэж ойлгож байна. Тийм.

Н.Энхболд: Баярлалаа. Тогтохсүрэн гишүүн. Жагсаалт нээлттэй байх тухай асуудал 2 хуулийн төсөл хоёуланд нь байгаа шүү.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Манай АН-ынхан тусдаа хуулийн төсөл боловсруулаад, үндсэн концепц нь бол Нямаагийн Энхболд гишүүн нарын гишүүдийн санаачилсан хуультай үндсэн концепц нь бол ойролцоо байгаа юм. Тийм учраас энэ хуулийн төслийг дэмжээд, Их Хурлаар шийдэгдсэний дараа хамтраад ажлын хэсэг гаргаад хамт хэлэлцүүлээд явах нь зөв байх гэж бодож байна.

Би 4 зүйлийг тодруулъя гэж бодож байгаа юм. Нэгдүгээрт, нөгөө тойрогт нэр дэвшиж байгаа хүмүүст 28 хувийн босго тавьчихаж байгаа юм. 12 он хүртэл энэ босго байсан. Тэрнээс хойш сүүлийн 2 сонгууль дээр энэ босгыг авсан юм. Тийм авсан юм. Босго байхаар юу байна вэ гэхээр дараа нь нөгөө сонгуулийн дүн гарсны дараа дахин сонгууль явагдаад ирэхээр тэр дахин сонгууль нь үр дүн муутай сонгууль болоод байгаа юм. Тийм учраас бол хамгийн олон санал авсан хүнээ л явъя. Сүүлийн 2, 3 сонгууль дээр, энэ босгыг больё гээд босгыг хасчихсан байхгүй юу. Тэгээд 28 хувийн босго ороод ирчихсэн байгаа юм. Тэгээд энэ эргээд 1 ухралт болчхож байгаа юм. Мажоритар дээр би яриад байна шүү дээ. 1 дэх асуудал нь энэ дээр би яагаад 28 хувийн босго тавсан бэ гэдэг асуудал байгаа юм.

Хоёрдугаар асуудал 74.2 дээр заагаад өгчихсөн байгаа юм. Мажоритараар суудал авах нам пропорциональ дээр нийт мандатын 50 ба түүнээс дээшид нэр дэвшүүлж, суудал авсан байна гэж байгаа юм. Тэгээд энэ нөгөө намд тавигдах шаардлага аягүй өндөр болчхож байгаа юм. Заавал пропорциональ дээр мажоритар дээр суудал авч байж пропорциональ дээр суудал авах болчхож байгаа юм. Тэгээд энэ шаардлага бол аягүй өндөр болчхож

байгаа юм. Энэ 74.2.1-ээр. Энэ бид чинь бол хамгийн гол нь энэ парламентад аль болохоор олон намын төлөөллийг оруулъя гэдэг нэг л ийм зарчим явж байгаа. Сая та 2-ын илтгэлд ингээж дурдаж байна. Тэгсэн мөртөө 74.2.1 дээр болохоороо шаардлага нь өндөрсчхөж байгаа юм. Тэгээд энэ нөгөө шаардлага өндөрсөнө гэдэг чинь оруулах боломжийг нь бага болгож байна л гэсэн үг байгаа юм.

Гуравдугаарт нь, 74.3.1 дээр сая тайлбарлахдаа бол та бүхэн бол намын нэрсийн жагсаалтад санал өгнө гээд байна. Ингээд яг уншаад 74.3.1-ийг уншаад үзэхээр нэрсийн жагсаалт буюу нэрсийн жагсаалт буюу 28 хүнд санал өгөхгүй, зөвхөн намд санал өгөхөөр харагдаад байгаа юм. Би бол тэгж ойлгоод байгаа юм 74.3.1-ийг.

Дөрөв дэх асуудал нь юу байна вэ гэхээр Төсвийн хуульд өөрчлөлт оруулаад энэ хуулиа дагалдуулж Төсвийн хуульд өөрчлөлт оруулаад Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдаад байгаа юм. Энэ юу байна вэ гэхээр Улсын Их Хурал бол Төсвийн хуулийг батлах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх юм. Гэтэл сонгуулийн жил тэтгэлэг өгөхгүй, тусламж өгөхгүй, цалин тэтгэвэр нэмэгдүүлэхгүй, нийгмийн халамжийн ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхгүй гээд бүгдийг нь хаачхаж байгаа юм. Тэгэхээр энэ нөгөө Улсын Их Хурал төсөв батлах онцгой бүрэн эрхэд халдаад байгаа юм энэ Төсвийн тухай хуулийн заалт тийм. Тэгэхээр бол явцын дунд энэ хуулийг бол би дахиж хэлэлцэх эсэхийг нь дэмжээд ярих болов уу гэж. Яагаад заавал ингээд Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдсан хууль оруулж ирэв гэдэг ийм 4 асуултыг асууя.

Н.Энхболд: Хэн нь вэ? Цогтгэрэл дарга.

О.Цогтгэрэл: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Олон асуулт байгаа болохоор аль болох

тодорхой товчхон хариулъя. Яагаад 28 гэдэг босго тавьсан бэ гэдэг асуулт байна л даа. Тэгэхээр энэ сонгуульд орсон, оролцсон иргэдийн 28 хувь, тухайн тойрог гэдэг чинь тухайн тойргийнхоо иргэдийг нийт иргэдээс бодвол 20 орчим хувийн санал авсан нь гишүүдийн ингээд төлөөлөл Улсын Их Хуралд орж ирээд байгаа юм. Ингээд бодоход тухайн тойрог дээр ажиллаж амьдарч байгаа нийт иргэдийнхээ 20-хон хувийн саналаар орж ирчхээд тэгээд тэр тойргийг төлөөлнө гэж ярих, энэ дээр тодорхой хэмжээний тийм босго цензур байхгүй бол нэр дэвшигч олонтой тойргууд байдаг. Тэгэнгүүт санал хуваагдаад, тухайн тойргийн иргэдийнхээ 28, 28 гэдэг чинь сонгуульд орсон иргэдийн тэгээд нийт иргэдийнхээ маш бага саналаар иргэдийг төлөөлөх асуудал бас гарч ирээд байна гэдэг ийм АН дээр гарсан дэд ажлын хэсэг дээр иймэрхүү саналууд гарсан.

Тэр байтугай зарим нэгдсэн том ажлын хэсэг дээр ярих байх. Ер нь явсаар явсаар байгаад 50 дээр нэмэх нь 1 гэдэг зүйл рүү хамгийн өндөр санал авсан сонгогчдоо оруулаад нэр дэвшигчдээ оруулаад явах юм биш үү гэдэг ийм зүйл бас яригдсаныг энд бас дурдчихъя. Тэгэхээр энэ бол өөрөө тийм төлөөлөх чадвар байна уу, үгүй юу гэдэг асуудал энэний цаана бас яригдаж байна. 28 хувиас доош авсан цөөн биш гишүүд өнөөгийн 76 дотор жишээ нь байгаа.

Хоёрдугаарт нь тэр заавал мажоритарас 1 суудал авсан байх. Энэ өөрөө бас тийм хатуу босго, өндөр босго юм биш үү гэдэг. Тэгэхээр Улсын Их Хурлын нэр, Улсын Их Хуралд намын босгыг 3 хувь гэдэг бол харьцангуй маш Ардын намын буюу тэр нөгөө ажлын хэсгээс орсон санал ч гэсэн харьцангуй энэ бол маш тийм нам дор түвшин гэж үзэж байгаа юм. 3 хувь гэдэг чинь ойролцоогоор 2 сая сонгогчийн насны иргэдтэй 1500000 хүн санал өгнө гэвэл 40000 хүний саналаар бүхэл бүтэн нам тэрийг давж орж ирэх

намуудад бол маш тийм өргөн боломж нээгдэж байгаа байх. Тэгэхээр ингээд тодорхой хэмжээнд бас энэ мажоритар тойргоос гишүүн орж ирэх нь бас зүйтэй юм гэдэг санал бас АН-ын дэд ажлын хэсгүүд дээр бас ингээд гараад явсан санал байгаа. 3 хувийн босготой энэ тоог нэлээн тийм холбож тавьсан тоо. Тийм 1 суудал авахад тийм.

3 дараагийнх нь тэр Төсвийн хууль. Төсвийн хууль дээр бас яг энэ бас л нэлээн ингээд бүлэг дээр болоод бид нар ажлын хэсэг дээр маш их ярьцаасан. Ер нь эрх баригч намууд зөвхөн Ардын нам гэлтгүй 16 онд АН-д ч байсан. Сонгууль дөхөөд янз бүрийн амлалтууд, янз бүрийн зүйлсүүдийг маш ихээр, тэр тусмаа төсөвт заримдаа тусгагдаагүй зүйлсүүдийг хүртэл янз бүрийн энэ арга саамаар оруулдаг. Нөгөө талаасаа энэ дээр тухайн намын мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй зүйлсүүд хүртэл энд сонгуулийн жил, сонгуулийн өмнөх жил, сонгуулийн хугацаанд бараг сонгуулиас сарын өмнө хүртэл маш олон зүйлүүд ингээд хийгдэж байсан ийм түүхэн тохиолдлууд маш их байдаг. Тэр байтугай 16 оны сонгууль дээр ч ийм зүйл байсан. Тухайн үед бас аль нам эрх барьж байсан билээ. Ингээд бодоход энэ өөрөө улс орны эрх ашгийн үүднээс, сонгуулийн шударга тогтолцоо, тэр тэгш, эрх тэгш боломжийн үүднээс энэ бол өөрөө бас тийм шударга ёсны үүднээс байх ёстой зүйл заалт. Магадгүй энийг Төсвийн хуулиасаа гадна улсын энэ Сонгуулийн тухай хуульдаа ч оруулж өгөхөд энэ энд энэ боломж тийм болохгүй зүйлгүй гэж үзэж байгаа.

Тэр байтугай энэ бол Сонгуулийн хуульд оруулж өгнө гэдэг Төсвийн хуулиас илүү тийм илүү өндөр шаардлагатай хууль байх. Илүү өндөр шаардлага, илүү өндөр босготой Үндсэн хуульд зарим зүйлд Сонгуулийн хуулийн хугацаа заагдчихсан учраас энэ өөрөө цааш цаашидаа ирээдүйд, Монгол Улсын ирээдүйд бас илүү чухал хэрэгтэй зүйл

заалт гэж бас бид нар энэ хуулийн энэ ажлын хэсэг, дэд ажлын хэсгүүд дээр бас ингээд ярилцсан зүйл заалтууд.

Н.Энхболд: Болсон уу? Адъяаа гишүүн асууя. Хууль санаачлагчдаас асууя.

Ш.Адъяаа: Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл нарын өргөн мэдүүлсэн энэ хуулийн төслийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Өнөөдөр энэ сонгогчдын санал гээгддэггүй, бусад улс төрийн хүчнүүд, түүнчлэн нийгмийн төлөөллийг оролцуулах шийдлийн хүрээнд энэ пропорциональ тогтолцооны хэлбэрийг сонгож оруулж ирэх нь өнөөдөр бас нийгмийн хүлээлтийн асуудал. 30 жилийн төрийн тогтолцооны хүрээнд энийг шийдэх ёстой. Сонгуулийн тогтолцооны энэ шийдлийг гаргах нь өнөөдөр бас Монгол Улсын парламентын төлөвшил, хууль тогтоох эрх мэдэлд бусад иргэдийн хүйсийн төлөөллийг оруулж ирэхэд чухал ийм зүйл болсон гэдэг ийм байр суурьтай байгаа.

48, 28 гэдэг энэ өгүүлбэр хамгийн зөв өгүүлбэр. Өнөөдөр намын жагсаалт гэдэг энэ төлөвшөөгүй байгаа энэ намууд төлөвшөөгүй энэ цаг үед мажоритар тогтолцооноос харьцангуй олон төлөөлөл орж ирэх нь цаашидын парламентын төлөвшлийн асуудал, тойргоос иргэд төрийн төлөөллөө сонгоход бас зарчмын ач холбогдолтой ийм тогтолцооны шийдлийг орсон учраас энэ дэмжиж байгаа юм.

Би энд 1 зүйлийг асууя. АН бол хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ийм үндсэн үзэл баримтлалтай нам. Энэ Улс төрийн намуудын тухай Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн барьсан энэ хуулийн хүрээнд ч намын хатуу гишүүнчлэлгүй байх тухай үзэл баримтлал энэ хуулийн төсөл дотор байгаа. Гэтэл өнөөдөр сонгуульд намууд нэр дэвшүүлэх дэвшүүлсэн нөхцөлд хуучин хуулийн хүрээнд ярьж байгаа шүү. Хэрэв нам нь

зөвшөөрөөгүй, нам нь дэвшүүлээгүй ийм намын гишүүд бусад намаас нэр дэвших ийм нөхцөлийг энэ хуульдаа яаж тусгаж өгөх вэ бусад улс төрийн хүчнүүдээс?

Гэтэл өнөөдөр энэ асуудал чинь яригдахгүй байна л даа. Энэ дээр аль, аль хуулийн төсөл дээр ч байхгүй. Хүний сонгох, сонгогдох эрхийн тухай өнөөдөр энэ Сонгуулийн хууль онцгой ач холбогдолтой байх ёстой. Гэтэл бие даасан нэр дэвшсэн хүмүүсийг тухайн улс төрийн нам, намын бодлого зөрсөн, намын даргыг дэмжээгүй гэдэг үндэслэлээр хөөдөг туудаг энэ асуудал дээр энэ Сонгуулийн хуулийн хүрээнд хүний эрхийг дээдэлдэг АН-ын хувьд энэ хуулийн төсөлд энэ талаар ямар бодлоготой, ямар зорилготой байна вэ гэдэг энэ асуултад харилт авъя.

Н.Энхболд: Цогтгэрэл дарга.

О.Цогтгэрэл: Товчхондоо Адъяаа гишүүний асуулт өөр намын гишүүн сонгуулийн үеэр дахиад тэр намдаа байж байсан мөртөө өөр намаас нэр дэвшиж болох уу гэсэн ийм тодорхой асуулт юм шиг байна. Тэгэхээр ер нь энэ Сонгуулийн тухай хуулийг ярилцах болоод энэ бүх үе шатад энэ Сонгуулийн тухай хуулийн нөгөө талд нь Улс төрийн намын тухай хууль намын дотоод зохион байгуулалт дотоод дүрмээр зохицуулагдах харилцаа гээд олон зүйл Сонгуулийн хуультайгаа бараг тэнцүү шахуу нэг зүйлийн 2 тал шиг энэ 2 ингэж явж байж зохицуулалтууд гарах байх.

Улс төрийн намын тухай хууль дээр тэр гишүүнчлэлийн асуудлууд болоод дотоод өөрийнхөө дүрэм журмаар юу гэж зохицуулахыг бид нар бас тэнд бас тодорхой хэмжээний тийм дотоод эрх чөлөө, дотоод ардчиллын олон асуудлууд тэнд байгаа байх. Харин энэ яагаад пропорциональ тогтолцоо ер нь байх нь зүйтэй вэ гэдэг сая Сонгуулийн хуулийн танилцуулга дээр миний хэлээгүй жишээ нь 1 зүйл бол, жишээ нь манай намын

хувьд АН-ын хувьд энэ сонгуулийн пропорциональ тогтолцоо гэдэг зүйл холимог тогтолцоо гэдэг зүйл намын төлөвшилд илүү нам чухал. Намын дотоод сахилга батыг бас илүү дээшлүүлнэ. Нам дотооддоо нэгдсэн бодлого гаргах, тойрог тойргоос гараад ирчихсэн гишүүдийн цуглуулга биш, намын нэгдсэн бодлого зохион байгуулалтад илүү тийм дэм үзүүлнэ.

Тэр тусмаа яг манай АН шиг ийм түүхтэй илүү тийм арай задгай гэх үү дээ, илүү эрх чөлөөтэй гэх үү энэ хүмүүст энэ яг энэ хуулийн тогтолцоо өөрөө АН-ыг нам болж илүү цаашид илүү тийм институцлаг болох д илүү дөхөм үзүүлнэ. Тийм болохоор зүгээр миний хувь хүний бодол бол тэгвэл тэр хүн сонгогдох эрх нь байж л байгаа шүү дээ. Бие дааж нэр дэвшинэ үү, намаасаа нэр дэвшинэ үү бүхий л сонголтууд байгаа. Заавал тэнд 1 намын гишүүн тэр чигээрээ нөгөө намаас, энэ чинь бас 1 үзэл баримтлал гээд нэг олон зүйлүүд энэний цаана явж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг тийм сонгогдох эрх чөлөөтэй бас холбож үзвэл бас хэтэрхий энэ задгай зүйл болж хувирах байх л гэж бодож байна. Зүгээр миний хувь хүний хувьд бол харин энэ нь холимог тогтолцоо, пропорциональ тогтолцоо орж ирж байгаа нь намын дотоод зохион байгуулалтад нам дотооддоо илүү бодлогын нэгдмэл байдалд хүрэхэд илүү тийм зангидсан арга хэмжээ болох тийм хөшүүрэгтэй зүйл заалт. Энэ бол манай тэр тусмаа манай АН-д илүү дөхөм, илүү АН-ын цаашидын төлөвшилд илүү тийм дөхөм болох зүйл заалт л гэж бодож байгаа. Тийм болохоор тэр яг энэ намын, хувь хүний сонгогдох эрхтэй энэ бол арай тийм холигдож тэр түвшинд очих очихгүй байлгүй дээ л гэсэн бодолтой байна.

Д.Ганбат: Би нэмчихье.

Н.Энхболд: Ганбат гишүүн нэмж тайлбар өгье.

Д.Ганбат: Адьшаа гишүүн маш чухал асуудлыг хөндөж байна. Энэний цаана бол асар том ач холбогдолтой зүйл агуулагдаж байгаа. Юу вэ гэхээр энэ үнэт зүйл үзэл баримтлал гэж зүйл байх ёстой л доо. Аливаа нам чинь үнэт зүйл, үзэл баримтлал дээрээ нэгдэж байж тэр улс орныхоо бодлогыг зангидаж явна. Үнэхээр намуудын нэр хүнд унасан байгаа. Тийм учраас энэ жагсаалтыг оруулж ирж, энэ намуудын нэр хүндийг өргөх, энэ улс оронд бодлогын чанартай зүйл явагддаг, тэр бодлогынхоо дагуу асуудлыг шийддэг ийм хөгжлийн бодлогыг алсалж харах энэ зүйл нь зөв.

Би ахиад уучлаарай ХҮН намаар жишээ авахад тийм. Ингээд 2020 оны сонгуульд зүүний үзэл баримтлалтай нам орж байгаа юм л даа. Тэгээд дунд нь явж байгаад гэнэтхэн барууны үзэл баримтлалтай болчихож байгаа юм. Нөгөө 1 өдрийн дотор 24 цагийн дотор, 2 цагийн дотор ч юм уу. Сонгогчид бол зүүний үзэл баримтлалд саналаа өгсөн байхгүй юу. Тэгээд аягүй муухай юм хийж байгаа байхгүй юу. Нөгөө сонгогчдоосоо ч асуулгүй. Тэгээд энэ чинь хаана яваад байгаа юм бэ? Нөгөө нам чинь үзэл баримтлалаа танилцуулаад, 1 хүнийг нь ингээд сонгоод өгсөн. Гэтэл гэнэтхэн барууны болоод явчхаж байгаа юм. Ингэж болохгүй.

Өмнө нь, манай энэ бас нөгөө намыг нь ч бас давхардуулаад явчихъя. Нагаржунай онолтой тийм нам явж л байсан. Нагаржунай онолоор ингээд л яагаад л, тэгээд л бас олонхын суудал аваад л. Ийм балай юм байж болохгүй шүү дээ одоо 21 дүгээр зуунд. Манай АН-ын үнэт зүйл, үзэл баримтлал яг тов тодорхой байгаа юм. Тийм ардчилсан, нээлттэй, чөлөөт зах зээл. Одоо өнөөдөр яг байхгүй байгаа өгүүлэгдээд байгаа бүх юм тэнд байгаа байхгүй юу. Энэний дагуу ажиллах боломжийг нь бол ерөөсөө өгдөггүй. Тэгээд энэ дагуу ажиллах ёстой. Тэрнээс биш хэдэн хүн бөөгнөрөөд л 1 суудал аваад л, тэгээд л өдөр хоног

өнгөрөөгөөд л, ямар ч улс орон хөгжсөн юм байхгүй. Тэгээд 1 бизнес хийж байгаа хэдэн нөхдүүд тэгээд л баяжиж бариад л ингээд л тардаг. Энэ байдлыг үндсээр нь өөрчлөх ийм ач холбогдолтой заалтууд бид 2-ын зүгээс өргөн барьчаад байгаа шүү. Тэгж харах хэрэгтэй.

Цаана нь хэдхэн 48, 28, нэг хүйсийн үнэтэй төлөвлөлт 40-өөс доошгүй, заавал нам дотроос 1 хүн сонгогдсон байна гээд маш чухал, чухал заалтууд байгаа. Нөгөө замын хөдөлгөөний дүрэм юугаар бичигддэг вэ гэдэг шиг бид АН яг туулсан замаараа энэ бүх сорилт бэрхшээлүүдийг даваад, Монгол Улсад яг ямар хэрэгтэй Сонгуулийн хууль байх ёстой юм гэдэг энэ талаас нь хандсан юм гэж ойлгоорой.

Н.Энхболд: Ганбат гишүүнээ, Цогтгэрэл гишүүнээ одоо болтол хүчин төгөлдөр мөрдөж байсан хуулийн дотор түрүүчийн хууль дотор жишээ нь 1 намаас нөгөө намын гишүүнийг нэрийг нь дэвшүүлж, дэвшүүлэхийг хориглоно гэсэн ийм заалт байгаа шүү дээ. Тэр нь хэвээрээ бид нарын өргөн барьсан дотор хэвээрээ явж байгаа. Тийм ээ. Тэр нам нь жишээ нь А намаас Б нам руу 1 хүн дөхөж гүйж очоод гэвэл Б нам нь тэрийг дэвшүүлэхийг хориглоно гэж байгаа. Тийм ээ, тэрэн дээр бол бид нарын заалтууд адилхан байгаа юм байна. Баярлалаа Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Ер нь бол аль 1 намаас сонгогдож байгаа Их Хурлын гишүүн бол тухайн намынхаа ялалтын төлөө л Сонгуулийн хууль дээрээ саналаа өгдөг. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд олон намын тогтолцоо хэдийгээр Монгол Улсад Үндсэн хуулийн дагуу бий болсон боловч ихэнх намууд АН-ын саналыг голдуу хуваах зорилготой байгуулагддаг, сонгуульд ордог. Өөрөөр хэлбэл МАН-ын хатуу бодолтой тэр гишүүд бол яг л намдаа санал өгдөг. Энэ АН-ын саналыг л пропорциональ бол юу байдаг юм олон нам оруулаад аль эсвэл юу байдаг юм тойрог дээр олон хүн дэвшүүлэх замаар энэ АН-

ын саналыг л хуваахыг зорьдог. Тэгээд тийм ч учраас ер нь бол энэ олон намын тогтолцоог илүү сайн болгохын тулд намын намыг бүх л намыг бол чадавхжуулах нь хамгийн чухал байгаа юм.

Тийм учраас энэ 3 хувийн босго тавьдаг нь бол Цогтгэрэл нарын гишүүний хууль дээр 3 хувийн босго тавьж байгааг би эсэргүүцэж байгаа. Өөрөөр хэлбэл бүлэг дээр бид нар 5 хувиа л ярьчаад орсон шүү дээ. Тэгээд тэрэн дээрээ тохирьё л гэсэн. Тэгээд энэнийхээ дагуу хуулиа өргөн барьж байгаа гэсэн чинь яг яах вэ хувь гишүүний 2 гишүүний бүрэн эрхийн асуудал л даа. Тэгээд 3 хувиар тавиад ороод ирчихсэн байна. Тэгэхдээ энэ бол юуг ямар санааг дэмжиж байна вэ гэвэл МАН-ын АН-ын саналыг хуваах тэр зүйлийг л бодитой зүйлээр нь бий болгоод л оруулаад ирж байна гэж харж байна л даа. Энийгээ 74.2.1-ээр буюу юу байдаг юм тойрог дээр нэг заавал 1 хүн гарч байж, жагсаалтад хүнээ оруулна гэдэг энэ юмаар хаана гэж байгаа бол эндүүрэл. Яагаад гэвэл хэлэлцүүлгийн явцад МАН-ын гишүүд тэрний чинь доор нь юу зарчмын тэр зөрүүтэй саналыг чинь хуулийн төслийн заалтыг чинь байхгүй болгочихно. Тийм учраас ийм зүйлд найдалт байхгүй. Энэ дээрээ яагаад ингээд бүлэг дээрээ 5 гэж ярьчаад, яагаад 3 руу оруулчихсан юм бэ гэдэг дээр 1 асуулт асууя.

2 дахь асуулт нь энэ хуулийг хэзээ өргөн барьсан юм бэ? Тэгээд энэ Засгийн газраас санал нь хэдний өдөр ирсэн юм бэ? Энийг тодорхой өдрөөр нь хэлээд өгөөч.

Н.Энхболд: Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: 2 асуулт байх шиг байна. Нэгдүгээрх нь намын босготой холбоотой. Босго дээр манай өргөн барьсан хувилбараар 3-аас 5 гэсэн байгаа. 5 гэдэг нь эвсэлтэй үед. Тэгээд энэ түрүүн бас Пүрэвдорж гишүүн бас хэлж байна. Нэлээн тийм 3 мөртөө нэг нэлээн тийм

бас нэмэлт шаардлага гэх үү тэр нь мажоритартаас заавал суудал авсан байя. Энэ бас яг АН-ын энэ бүлэг болоод намаас гаргасан дэд ажлын хэсгийн санал. Нэлээн тодорхой тэд нар нэлээн тодорхой үндэслэлүүд бүхий ийм саналууд гаргасан учраас. Энэ өөрөө тэгэхээр зөвхөн 3 хувийн босго биш, босгыг нэлээн өндөрлөж байгаа хэрэг.

Нөгөө талаасаа 38-аас 3 хувь авах, манай өргөн барьж байгаа 48 листтэй хэсэг чинь 48, 48-ын 3 хувь гэдэг чинь өөрөө агуулгын хувьд нөгөө гишүүдийн өргөн барьсан нь 3 хувиас агуулгын хувьд илүү тийм чанга 3 хувь. Энэ 28-тай хэсэг дээр дахиад 3 хувийн босго гэдэг чинь шууд тэрийг 3 хувь, 3 хувь гэж шууд харьцуулахад математик утгаараа энэ бол бас илүү тийм чанга хувь гэдгийг бас энэ хууль санаачлагчдын хүрээнд ярилцаад ийм тоо өргөн барьсан.

Дараагийнх нь тэр Засгийн газраас санал тухайн өдрөө ирсэн санагдаж байна. Энэ Их Хурлын ТББХ-ны ажилтан тэрийгээ хэлчихвэл зүгээр байх. Би ямар ч байсан Засгийн газраас ирсэн саналыг бид нар хавсаргаад л өргөн барьсан. Тэр Засгийн газрын хуралтай өдөр байсан санагдаж байна. Тэгэхдээ Засгийн газрын байсан хуралтай байсан өдөр нэг өмнөх ажлын хэсгийн Сонгуулийн хуулийн төсөлд санал өгчихсөн учраас бид нар маш хурднаар шийдээд, тэр саналыг өглөө гэсэн агуулга бүхий санал ирсэн санагдаж байна. Тэрийг хуулийн бүрдэл хариуцсан хүн нь нэмээд тайлбарлачихвал зүгээр байх.

Н.Энхболд: Тийм тарааж өгсөн материал дотор байж байгаа. Яг тэр өдөр нь өгсөн, яаралтай хэлэлцээд. Урьд нь ерөнхийдөө суурь нь ижил байсан учраас ижил санал өгч байна гээд яг адилхан санал өгчихсөн байж байгаа. Тийм. Ганбат гишүүн нэмье. Нэмэлт.

Д.Ганбат: Пүрэвдорж гишүүний санаа зовнилыг би ойлгож байна тийм.

Одоо энэ чинь юу вэ 1992 оноос хойш анхны сонгууль явснаас хойш гучаад жил болж байна. Тэр хооронд чинь 1 тамгатай 1 намын дарга бараг 20 жил явж байгаа тийм ч нам байна шүү дээ. Тэр намууд маань ингээд ороод ирэхээр л нөгөө энэ гудамж талбай юу болдог вэ яг тийм болчих вий гэсэн ийм санаа зовнил байна гэж ойлгож байна. Тэрийг бол ойлгож байна.

Нөгөө талаар бид нар манай АН-ын, манай нээлттэй нийгмийн үнэт зүйл, үзэл баримтлал байна л даа. Аль болохоор олон ургалч үзэл орж ирээсэй, олон нам бас орж ирээсэй. Тэгж байж бид нар юмаа ярья гэсэн ийм бодол байна. Өмнөх нөгөө зуун жил болчихсон нам шиг бид нар яаж ийгээд л дараа нь 50 суудал авчихъя, 50 хувиа илүү гаргаад авчихъя. Ямар нэгэн байдлаар тэгж хандъя гэсэн ийм бодлоос бид нар хандахгүй байгаа юм. Хууль санаачлагчийн зүгээс бол. Зүгээр л ямар ч үед л үнэт зүйл, үзэл баримтлалдаа үнэнч байя, энэ улс орныг, энэ асуудлыг энэ парламент дотроо шийддэг байя. Энэ гадна, дотнын нөхцөл байдал ийм хүндэрч байгаа үед эмх замбараагүй байдал ийм асуудал бол хэнд ч хэрэггүй юм. Энэ дээр бол бид нар 30 жил болсон намын хувьд бол энэ хүнд хэцүү бэрх үеийг дандаа зөв зүйтэй үед нь зохицож туулдаг байсны хувьд бол бид нар ингэж хандах ёстой гэж бид 2-ын зүгээс үзсэн. Та хэдийн маань санал ч бас ингээд тусгагдаад явж байгаа шүү гэдгийг хэлье.

Н.Энхболд: Сүхбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Сүхбаатар: Юуны өмнө Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн гишүүд маань ийм Сонгуулийн хуулийн төсөл дээр бас ажил хэрэгч хандаж байгаад бас талархаж хандаж байна. Миний тухайд бол Сонгуулийн хууль дээр өмнө нь бол олон удаа ажиллаж байсан хүн. Яах вэ 48, 28 бол энэ АН-ын бүлгийн санал бас биш л дээ. 2011 онд энэ Энхболд гишүүн бид нарын өөрсдийн хийж байсан 48, 28 гэдэг

тооцоолол, би тэр тусмаа өөрөө энэ тоог бодож гаргаж хийж явсан хүн байгаа юм. Тэгээд энэ тоог бол авч ашигласан байж байна.

Энд байгаа ер нь заалтууд бол бид нарын Сонгуулийн хуулийн заалтууд, энэ цөөн хэдэн заалт л өөрчлөгдсөн байна. Өөрчлөгдсөн дотор чинь харин 1 юм байна л даа. Тойрогт ноогдох нийт мандатын 50 буюу түүнээс дээш хувьд нэр дэвшүүлж суудал авсан байх гээд түрүүн Тогтохсүрэн дарга асууж байсан лээ. Тэгчхээд намын нийт намд өгсөн нийт саналын 3 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх гээд ингэчихээр энэ 2 чинь хоорондоо зөрчилтэй байхгүй юу. 28-хан санал дээр 3 хувь руу буулгаад онолын хувьд ингээд ойролцоо, ойролцоо нөгөө намууд их яах вэ амьдрал дээр бараг гарахгүй байх. Гэхдээ гарчихвал энэ саналд энэ суудал чинь угаасаа хүрэлцэхгүй байхгүй юу. Яг ингээд ойрхон жигд авбал. Яг энэ та хэдийн шаардлагыг тавиад 1 талаас нь.

Нөгөө талаас энэ 50 хувийг чинь тавьчихаар 3 хувь буулгах шаардлага угаасаа байхгүй болчихож байгаа юм. 3 хувь чинь өөрөө зүгээр яг тэр Израил маягийн юм руу орж байгаа чинь зүгээр ийм барьер үүсгэхгүйгээр аль болохоор олон намыг оруулъя. Европ маягийн хэлэлцээрийн юмыг зөвшилцлийн ардчиллыг бий болгоё. Сонгуульд ялагч намыг тодруулахаасаа илүүтэй ард түмнийг төлөөлөх дуу хоолойг оруулж ирээд, тэнд нь эвсүүлж Засгийн газар байгуулахад нь үйлчлэх нийгмийг зөвшилцүүлэх хувилбар руу оруулах энэ механизм байхгүй юу 3 хувь чинь багасгаж байгаа чинь.

Тэгэхээр энэ 2 чинь хоорондоо зөрчилдөөд байгаа юм биш үү? 3 хувь гэж тавьж нэг харахад намуудынхаа юмыг суллаж өгчхөөд, нөгөө талд нь 50 хувьд чи заавал нэр дэвшүүл, тэгээд суудал ав. Тэгэхээр чинь энэ чинь цаад механизмтайгаа нөгөө эсрэг боолт хийж

байгаа арга хэрэгсэл болчихож байгаа байхгүй юу. Тэгээд энэ манай энэ парламент давжаа гээд би бас нэг 10 жилийн өмнө нэг давжаа парламент гээд хэлчихсэн. 76-г 99 болгоё гээд. Тэгэхээр энэ зорилгыг чинь энэ парламентыг чинь бас давжаа байгаагийн бас 1 дутагдал нь хэдийгээр тоог бид нэмж чадахгүй үлдлээ гэж бодоход ерөөсөө 1, 2-хон намын загвар бүхий Англи саксоны загвараар явахад энэ нийгмийг 2 талцуулж хуваагаад байгаа байхгүй юу. Англи саксоны орнууд чинь бол том муж хотууд нь бие даачихсан байдаг учраас үндэсний хэмжээнд 2 нам болгож хуваагаад зөрчилдүүлж байгаа юм шиг ерөөсөө нэгтгэдэг байхгүй юу. Үндэсний хэмжээнд.

Манайд болохоор нөгөө төвлөрсөн нэгдмэл улс учраас 2 намд хуваачихаар дээрээсээ доошоо тэр чигтээ зөрчилдөөнт нийгмийг бий болгочоод байгаа. Тэгэхээр ийм механизм байгаа. Энийг би, нам ялах нь бол одоо ингээд амархан байна шүү дээ ялчихаж байна. Тэгээд засаглаж чадаж байна уу гэдэг асуулт байгаад байгаа байхгүй юу. Ард түмнийг төлөөлж байна уу? Парламент бол ард түмний төлөөллийн байгууллага. Тэнд эсендер орж байна уу, тэнд нийгмийн бүлгүүд орж байна уу? Тэгэхээр энийг чинь л хийх гэж энэ 3 хувь чинь орж ирж байгаа болохоос биш цаад чагтан юм чинь тавьчихаар цаад утгаараа бол хэт олон намуудыг бий болгох болчихоод байгаа зарим оронд бол энэ чинь зөв болохоос биш яг манай дээр ингээд тавихаар чинь энэ 3 хувь болгож байгаа чинь ямар ч ач холбогдолгүй болчихоод байгаа юм биш үү? Ийм асуудал байгаад байгаа юм. Энэ дээр байр суурь хэлэлцэж. Тэрнээс бусад заалтуудын ихэнх нь, дийлэнх нь бол бид нарын 11 онд хууль баталж байсан хуулийн заалтууд л байна л даа гол нь. Тэр тоо бол яг тэгж л 48, 28-ыг бол сайндаа ч хийгээгүй юм л даа. Нөгөө хасаж болох орон нутгаас хасаж болох хамгийн дээд хязгаар нь л 28 л хүртэл явж болохоор байсан учраас л 48,

28 гэдэг тоо гараад, тэгээд манай Фортуна миний саналыг сонсоод наадах чинь яг болж байна гээд л ингээд л явсан эд.

Н.Энхболд: Гишүүд, хууль санаачлагч нараас, хариулт нь уу? Сүхбаатар гишүүний асуултад Цогтгэрэл гишүүн хариулъя.

О.Цогтгэрэл: Сүхбаатар гишүүний асуултыг асуултад хариулъя. Нэгдүгээрт нь, 3 хувийн босго нь багасаж байгаа парламентад олон намын төлөөллийг оруулах гэж байгаа юм шиг мөртөө нөгөө талд нь бас босго тавьчихаад байна энэ чинь ямар учиртай вэ л гэж байна л даа. Ер нь энэ пропорциональ элемент гэдэг өөрөө намын намуудын төлөвшилийг хамгийн гол нь иргэдийн төлөөлөл иргэдийн санал парламент тусахаас гадна намуудын төлөвшил гэдэг зүйлд ач холбогдолтойг бас бүгдээрээ ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр мэдээж 3 хувийн буюу бага босгоор 3 хувь бол харьцангуй маш бага босго. Бараг өнөөдрийн энэ парламентад санал авч орж байгаа гишүүдийн дундаж санал болчихоод байгаа байхгүй юу. Яах вэ арай дунджаас өндөрдүү л санал.

Нөгөө талаасаа тухайн намыг бас төлөвшисөн байхыг бас шаардах, тойрогт болоод жагсаалтад бас гишүүд дэвшүүлэх. Одоо чинь манайд сонгуульд санал авахгүй байтугай гишүүн сонгогдохгүй парламентад орохгүй байтугай сонгуульд ерөөсөө л нэр дэвшүүлдэггүй намууд яваад л байдаг, яваад л байдаг. Тэгэхээр жишээ нь тэр 28 дээрээ тодорхой 50-иас доошгүй хувьд нь бас нэр дэвшүүлэг л дээ. Энэ чинь ингээд ийм нам гэдэг чинь олон хүний нэгдэл юм байгаа биз дээ. Хэн нэгэн ганц этгээд нам гэдэг тамга барьчихаад яваад байгаа энэ намын төлөвшилийг нь нөгөө тал руу, ер нь энэ эцсийн дүндээ энэ пропорциональ гэдгээрээ дамжуулаад Монголын энэ парламент, парламент тогтолцоо энэ чинь нам дээр тогтоож байна. Намын

чадавхжилтын асуудлыг илүү том хөшүүргүүд энд оруулж өгье.

Тэр тусмаа 3 хувь гэдгээрээ бас харьцангуй бага босгыг нь тавьж өгье. Нөгөө талд нь бас хөшүүргүүдийг оруулж өгье гэдэг санааг бас АН-аас гарсан дэд ажлын хэсгүүд дээр бас нэлээн хүчтэй яригдсан учраас энд бид нар бас тусгаж өгсөн.

Д.Ганбат: Би нэмчихье.

Н.Энхболд: Хариулчих, тэгээд тодруулчихъя. Ганбат гишүүн.

Д.Ганбат: Сүхбаатар гишүүн маань бас өөрөө хуульч хүн бас энэ Сонгуулийн хууль дээр нэлээн ажиллаж байсан болохоор их зөв зүйтэй зүйлүүдийг 2011 онд ярьж байсан. Энийг бол санаж байна. 3 хувь бол намуудын босго. 28 хувь бол нэр дэвшигчийнх. 3 хувь нь болохоор бид бүхний аль болохоор олон нам орж ирээсэй, яг таны яриад байгаа шиг олон ургалч үзэл энэ парламент дээрээ яригдаасай гэдэг энэ талаас нь хандаж байгаа юм. 28 гэдэг хувь маань нөгөө нэр дэвшигч маань сонгогчдын төлөөлөх чадварыг нь яриад байгаа юм. Энэнээс бага байж болохгүй шүү дээ. Тэгэхгүй бол 50-иас дээрх нэмэх гэхээр олон дахин сонгууль явах ийм байдал орж ирнэ.

Нөгөө тойрогт чинь олон хүмүүс дэвшинэ. Энийг нь бас хангаж өгч байгаа юм. Нөгөө талаар бол жилээс жилд сонгогчдын саналаа өгөх нь багасаж байна шүү дээ. Тэр 90 онд бараг л 90 хувьтай өгдөг байсан бол тэрнээс хойш ингээд л явсаар байгаад сонгуульд оролцох иргэдийн маань тоо сүүл рүүгээ 60, 60 хувьтай болчихсон байна. Энэ чинь одоо нөгөө төр засагтаа итгэх итгэл нь ямар болох вэ? Энэ дээр бид нар бас анхаарах ёстой юм шиг байна. Тэгэхгүй бол нэг хэдэн төрийн албан хаагчид ирж саналаа өгөөд л, төрийн албан хаагчид нь тоолоод л, тэгээд л МАН гардаг ийм л дүр зурагтай явдаг. Тэрийг нь цааш цаашидаа

хэн ч хүлээн зөвшөөрдөггүй. Нөгөө одоо бужигнаатай нөгөө *legitimate* чанар нь алдагдсан, нөгөө итгэл хүлээх энэ тэр юм нь байхгүй болчихсон ийм зүйлүүд байгаа. Энийг та тэртээ тэргүй маш сайн ойлгож байгаа. Энийг бид нар тэр хар машиныг баталгаажуулах, бүх иргэд сонгогчдыг саналаа өгөх боломжоор хангах, хүмүүсийг оролцуулах энэ бүх юмнуудыг бас нэмж хиймээр юм шиг байна лээ. Тэр процессынхоо юман дээр бол гэх мэтчилний зүйлүүд байна гэж ойлгож байгаа. Тийм.

Н.Энхболд: Сүхбаатар гишүүн тодруулья гэж байна.

Ж.Сүхбаатар: Харин тийм нөгөө яг тэрэн дээр би тэр 50 буюу түүнээс дээш хувьд нь нэр дэвшүүлээд суудал авсан байх гээд ингээд хэлчихээр 3 хувь болгосны чинь хэрэг байхгүй болчихоод байна. Зүгээр 38, 38 юу гэдэг юм суудлыг хэрэв пропорциональ дээр хуваарилж байсан бол та нарын энэ орж ирж байгаа тэр жишээлбэл 50, 50 хувийн пропорциональ байсан бол юу пропорциональ, мажоритар байсан бол энэ зөв байх. 28-хан суудал дээр өгчхөөд, тэгээд тэрийгээ 3 хувь болгож байгаа юм шиг мөртөө тэр бодит амьдрал дээр хэцүү байхад нөгөө талаас нь 50 гээд хэлчихээр чинь нөгөө ардчилсан үзлээрээ бусад намуудаа дэмжиж байгаа гэдэг чинь эсрэг болчихоод байгаа байхгүй юу. Харин эсрэгээрээ эрх барьж байгаа МАН чинь одоогийнхоо өөрт олон хүн нь хэлээд байгаа ашигтай байж болох хувилбараа либералчлаад илүү олон нам цаана нь ороод ирээсэй гэдэг байдлаар хувилбараа тавиад яваад байгаа. Тэгэхээр та хэдийн юмыг чинь харахаар аягүй бол хүн шүүмжлэх гээд байгаа байхгүй юу. АН байж нэг харахад хамгийн ардчилсан нам байж 3 хувь болгочхонгуутаа зөрүүлээд 50.../минут дуусав/

Н.Энхболд: Санал шахуу болчхов уу даа. Тэгье. Гишүүд асуулт тавьж, хариулт авч дууслаа. Одоо хууль

санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байхгүй байлгүй дээ. Байвал нэрээ өгье. Доржханд гишүүнээр тасаллаа. Нямбаатар сайд, Амарсайхан сайд, Доржханд гишүүн.

Х.Нямбаатар: Сая тэр нөгөө ярьсан.../үг тасрав/

Н.Энхболд: Чимээгүй, чимээгүй.

Х.Нямбаатар: Энэ би нөгөө энийг яг энэ ТББХ-ны өнөөдрийн энэ хуралдааны протоколд үлдэх байх гээд бодоод ярьж байгаа юм. Хатантуулаа. Энэ Үндсэн хуулийн тэр 21.4-ийг ҮХЦ-ийн дүгнэлттэй холбоотой энэ заалтуудыг хэдүүлээ цаашид нийцүүлэх талаар арга хэмжээ авах нь зүйтэй л гэж би хэлэх гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл амьдрал баян. Таны хэлж байгааг Цэцэд хэн нэгэн гомдол гаргаач уу, үгүй ч үү, гаргалаа гээд Цэц шийдвэр гаргаач уу, үгүй ч үү гэдэг байдлаар.../үг тасрав/

Н.Энхболд: Гаргасан хойно нь, хүлээж аваа ч уу, үгүй ч үү.

Х.Нямбаатар: Хүлээж аваа ч уу, үгүй ч үү гээд ийм маягаар бол явж болохгүй байх. Энийг цаашид хэдүүлээ 1 өөрчилье гэсэн санаа.

Хоёрт нь сая бид нар Одонтуяа гишүүн ч тэр би СЕХ-ныхонтой ярьж байсан. Бид нар 20 оны сонгуулийн тэр хуулийг хийхэд аягүй тулгуу байсан. Аягүй олон процессын зүйлүүд байсан. Тэрийг сая манай энэ СЕХ-ныхон бол нэлээн л Энхболд даргын өргөн барьсан төсөл дээр бол нэлээн шигтгэсэн юм байна лээ. Тэнд 1 аягүй том асуудал гардаг нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа. Бид нар би тухайн үед ХЗБХ-ны даргаар ажиллаж байгаад нэгдүгээрт энэ Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн зөрчилтэй холбоотой асуудлыг эрүүгийн хэргийг ТЕГ-ын мөрдөн шалгах байгууллагад харьяалуулсан. Гэтэл ТЕГ-ын мөрдөн шалгах алба нь бүх орон нутагт нэгжгүй, тэгээд маргаан

бүх орон нутагт үүсдэг энэ асуудал дээр эргэж тэр цагдаагийн харьяалал руу нь шилжүүлэхээс өөр аргагүй нөхцөл байдал үүсэж байгаа юм.

Хоёрдугаарт тэр Зар сурталчилгааны хууль тогтоомж зөрчих, Харилцаа холбооны хууль тогтоомж зөрчих маш олон хууль тогтоомжуудын зөрчил дээр яг харьяалан шийдэх байгууллага нөгөө орон нутагт нэгжтэй байгууллагууд байдаггүй нь том асуудал үүсгэдэг. Тэгээд бид нар бүр хугацаа тулаад тэр өдөр тухайн үед сонгуулийн энэ маргаануудыг хянан шийдвэрлэх хэргийн харьяаллыг зөрчлийн хэргийн харьяаллыг тогтоохдоо ер нь бараг 100-ны 70 орчим хувийг цагдаагийн байгууллагад харьяалуулсан юм. Энэ шударга өрсөлдөөнтэй холбоотой юутай зар сурталчилгаатай холбоотой маш олон хууль тогтоомжуудын зөрчлийн асуудлыг эргэж нэг энэ Сонгуулийн хууль хэлэлцэх явцад дагаж батлагдах хуулиуд дээр эргэж нэг сайн хэдүүлээ тал талаасаа цаг хугацаатай яримаар байгаа юм. Ер нь цаашидаа бид нар сонгуулийн маргааныг аль болох сонгуулийг маргаангүй явуулах тэр процессуудыг л хуульчилж өгөх тал дээр тал талаасаа анхаармаар байна гэсэн 2 дахь зүйлийг хэлэх гэж байгаа юм.

3 дахь нэг ярих асуудал бол энэ нэг сонгууль юунаас эхэлдэг вэ гэхээр ерөөсөө өглөө сонгуулийн өглөө нөгөө сурталчилгаа эхлэх өглөө сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулахаас л эхэлж байгаа юм. Бид нар сая өнгөрсөн онд Улсын Их Хурал Нийтийн мэдээллийн тухай хуулийг баталсан. Энэ хуулиар бид нар төрийн зарлан мэдээлэх чиг үүргийг цахимаар яаж явуулах цахим дэд бүтцийнхээ асуудлыг шийдсэн. Өөрөөр хэлбэл энд сууж байгаа танхимд сууж байгаа хүн бүр Монгол Улсын бүх иргэдэд бид нар имэйл хаягийг улсын бүртгэлийн байгууллага дата төвтэй нийлээд нээчихсэн. Өөрөөр хэлбэл энэ имэйл хаягийг бид нар гар утсан дээрээ

суулгасан тохиолдолд сонгуулийн зар мэдээ сурталчилгаа бүх юм очих боломжтой. Өөрөөр хэлбэл төрөөс үнэ төлбөргүй бид нар зар сурталчилгаа явуулах энэ дэд бүтцээ нэгдүгээрт ашигламаар байна. Энэ Сонгуулийн хуулийн хэлэлцэх явцад.

Хоёрдугаарт Монгол Улсын засаг захиргааны бүх нэгжүүд буюу баг, хороодын зар мэдээ тавьдаг самбаруудыг яг I стандарттай болгоод түүнийгээ нэр дэвших нам эвслүүдэд шодоод яг эн тэнцүү тэр талбайг өгдөг, тэрэн дээрээ яг ижил стандартын тэр сурталчилгааны ухуулах хуудаснуудыг наадаг ийм зохицуулалт руу бид нар бас шилжих шаардлагатай гэсэн ийм зүйлүүдийг л би хэлэх гэсэн юм.

Н.Энхболд: Саяын Нямбаатар гишүүний хэлсэн зүйлүүдийг хэдүүлээ бас хэлэлцүүлгийн явцад анхаараад, шаардлагатай гэж үзвэл гишүүдээр зарчмын зөрүүтэй санал гаргуулж байгаад нэмээд ингээд явах бололцоо нээлттэй байгаа шүү. Анхааралдаа авцгаая. Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Энэ Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал дээр ганц, хоёр санал хэлье. Сая Үндсэн хуулийн тэр дүгнэлт дээр бол Нямбаатар сайдтай санал нэг байгаа. Цаашидаа бас асуудлыг тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байгаа I талд нь гаргаж. Сонгуулийн хууль дээр 2, 3 асуудал байна. Бид нар энэ жагсаалт тойрог яриад байгаа юм. Хэн нэр дэвших вэ, хэдэн ямар тойрогт яаж хуваарилалт хийх вэ гээд жагсаалт тойрог яриад байгаа мөртөө хэн нэр дэвшиж болох вэ гэдэг асуудлыг ерөөсөө ярихгүй байгаад байна. Нэгэнт Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа бол хэн нэр дэвшиж болох юм бэ гэдэг асуудлаа өргөн агуулгаар нь шийдвэрлэхгүй бол яг байгаа тогтолцоогоор нэг хэсэг нь улс төрч туршилагатай гэдэг утгаараа сонгогдох боломж нь нээлттэй байдаг. Нөгөө хэсэг

нь гудамжинд хэн сайн улс төр хийж, хэн сайн нөгөө попорно гэдэг шиг аашилж чадсан нь сонгодог ийм хоёрхон сонголттой бий болчихоод байгаа юм.

Гэтэл нөгөө талдаа нөгөө эрдэм шинжилгээний салбарын судлаачид, эрдэмтэд, багш, эмч гээд мэргэжлийн инженер техникийн ажилчид гээд нарийн мэргэжлийн хүмүүс энэ улс төрд орж, улс орны бодлого шийдвэрийг гаргахад хязгаарлагдмал байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл одоогийн үйлчлэх гэж байгаа энэ Сонгуулийн хуулиар бол төрийн захиргааны байгууллагын ажилтан, төрийн үйлчилгээний байгууллагын ажилтан, төрийн өмчит үйлдвэрийн газрын дэд дарга, дарга гээд хүмүүс 6 сарын өмнө буюу 1 сарын 1-нээр тухайн сонгуулийн жилийн 1 сарын 1-нээр ажлаа өгсөн байна гэж. Сонгуульд оролцохын тулд заавал нэг хэсэг нь ажлаа өгдөг, өрсөлдөөд гарч чадахгүй бол ажилгүй орхигддог, хаягддаг, эсвэл нэг хэсэг нь давуу эрхтэй сонгуульд хэзээ ч хамаагүй ордог. Энэ чинь өөрөө бид нарын нөгөө эрх тэгш хүний эрх тэр хаана байна. Нөгөө эрх тэгш үйлчлэх зарчим хаана байна. Нөгөө жендерийн харилцаа гэдэгтэй адилхан хүний эрхийг бүрэн хангах тухай асуудал хаана байна. Ийм асуудал байхгүй учраас өнөөдөр манай төр тогтворгүй, төлөвшихгүй, шийдвэр гаргалт дандаа улс төржилттэй, тооцоо судалгаагүй, мэргэжлийн боловсон хүчин мэргэжилтнүүдийн оролцоогүй ингэж хийсвэр агуулгаар гарч ирээд цаана нь хуулийн цаана нь эдийн засаг, нийгмийн үр дагаврыг нь нарийн тооцож чаддаггүй. Эргээд гаргасан хуулиа маргааш нь өөрчилдөг, нөгөөдөр шинэчилдэг ийм тогтолцоо 30 жил явж ирлээ. Энэ улс төрийн Сонгуулийн хуулийн өөрчлөлт бол энэнээс эхлэх ёстой гэж бодож байгаа юм. Энэнээс. Хүн бүхэн тэгш оролцох боломжийг нээхээс.

Хоёрдугаарт бол дараа нь мэдээж тойргийн асуудал яригдана. Тойрог том байх уу, жижиг байх уу? Тэгэхээр энэ

тойргийг бүр илүү томруулах хэрэгтэй. Жишээ нь Улаанбаатар хот, нийслэл хот нэг тойрог, зарим аймгууд бол нийлээд нэг бүс, ингэж байж манайх шиг цөөн хүн амтай улс төржилт ихтэй, туйлиралтай, тэгээд асуудлаа шийддэггүй, бодлого ярьж байх ёстой, түүнийгээ хэрэгжүүлж, хянаж байх ёстой Их хурал нь, Их Хурлын гишүүд нь өвс тэжээл, гэрэл чийдэн, хог нови яриад явж байдаг. Нийслэл, аймаг, дүүргийн төлөөлөгчид нь тэр ахуйн асуудлуудаа ярьдаг, аюулгүй амьдрах орчин нөхцөл, хог шороогоо ярьдаг, бодлогоо ярьдаг, Их хурал нь бодлогоо ярьдаг, ажлаа хийдэг хорооны Засаг дарга нь хорооны Засаг даргаа хийдэг, аж ахуйгаа ярьдаг хотын дарга нь хотын аж ахуйн ажлаа ярьдаг энэ ялгаа салгааг гаргаж өгөхгүй бол бид алиных нь ч учрыг олохгүй явсаар байтал иргэд дунд төөрөлдөөд, төрөө үнэлэхээ болиод төр нь үнэгүй болж байна. Үнэ цэнгүй болж байна.

Төр гэж байгаа цагт ёс төрт ёс гэж байх. Ёстой өнөөдөр хэн байхаас үл шалтгаалаад, хэзээ хэн сонгогдож энэ томоохон улс орны эрх ашгийг өргөн цар хүрээтэй шийдвэрлэх тийм боломжийг бүрдүүлэх вэ гэдэг асуудлыг бид энэ Сонгуулийн хуулиар тодорхой болгож өгч байж, дараагийн асуудал тодорхой болно. Одоо бид нар эзэн биегүй тойрог, эзэн биегүй жагсаалт яриад байна. Хязгаарлагдмал явцуу хүрээнд. Өөрөөр хэлбэл энд байгаа Их Хурлын гэдэг юм уу, тэнд байгаа хэдэн намын нөхдүүдийг хэрхэн яаж оруулж ирэх вэ гэдэг тухай асуудал яригдаад байгаа юм. Гэтэл цаана нь байгаа нөгөө жинхэнэ мэргэжилтнүүд яаж орж ирэх вэ гэдэг асуудлаа энэ дээр ярихгүй бол болохгүй шүү гэдгийг хэлье гэж байгаа юм.

Н.Энхболд: Баярлалаа. Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Би уг нь бол үг хэлэхгүй дэмжээд явъя даа гэсэн бодолтой байсан юм. Үг хэлэхээс өөр арга

алга. Яагаад вэ гэхээр над руу хүн дайрахад бол би хүлээж авч чадна. Харин тэнд байгаа итгэл сэтгэл итгэл үнэмшилээрээ явж байгаа олон мянган тэр залуучууд, мэргэжилтнүүд рүү дайрч байгаа бол уучлаарай би тайлбар хийх ёстой юм. Тэгээд өнөөдрийг хүртэл манай нөгөө АН маань наашаа их дайрдаг л даа. Тэгээд ХҮН нам бид нарын саналыг хуваагаад байна л гэдэг. Тэгээд ХҮН нам Ардын намтай нийлээд яваад байна л гэдэг. Би маш тодорхой хэлье. ХҮН нам АН-ын саналыг хуваадаггүй. Сүүлийн 2 сонгуулиар АН ХҮН намын саналыг хуваасан. Ерөнхийлөгчийн сонгуулиар бид нар 20-иос дээш хувьтай авсан. Танай хүн 6 хувьтай авсан. Нөхөн сонгуулиар манай Найдалаа, Бат-Үүл гэдэг 2 хүн үзсэн 2-уулаа ялгаатай шүү. ХҮН нам дандаа хоёрт эрэмбэлэгдээд бид нар огт тийм юм ярьдаггүй. АН учраа олоосой л гэсэн байдлаар амаа хамхиад л явдаг. Өнөөдөр хүртэл бид нар та нарын оруулж ирсэн саналыг дэмжинэ.

Хоёрдугаарт оруулж ирсэн санал дээр харин зарчмын асуудал байгаа шүү. Би тэрийг бас хэлчихмээр байгаа юм. Улс төрийн намын удирдлагуудын түвшинд ярьсан, ажлын хэсгийн түвшинд ярьсан тохирсон. ХҮН нам бол пропорциональ элемент 100 хувь байдаг байгаасай, цаашидаа 100 хувь байг. Харин одоо бол 50 хувь дээрээ байх нь зүйтэй юм байна гээд л тохирсон. Тохирсон дээрээ ажлын хэсэг дээрээ тууштай байгаа. Харин АН бас 50, 50 гэдэг дээр тохирсон байсан юм шүү. Ажлын хэсгийн түвшинд ч, намуудын удирдлагуудын түвшинд ч гэсэн. Харин бүлэг дээрээ шал өөр 48, 28 гэж орж ирж байгаа нь ухралт шүү. Энэ бол улс төрийн соёл шүү. Улс төрийн соёл шүү.

Гуравдугаарт би Ардын намын дарга Оюун-Эрдэнэтэй 2 зүйл дээр бол санал нийлж байгаа. Нэгдүгээрт, Монгол Улсыг хөгжүүлэхийн төлөө, парламентын засаглалыг бэхжүүлэхийн төлөө тогтолцооны өөрчлөлтийг хийнэ гэдэг дээр бид нар санал нэг байгаа.

Энэний төлөө бол хамтарч ажиллаж байгаа. 2 дахь нь авлигачтай хулгайч нартай тэмцэнэ гэдэг дээр бол хав хатуу байгаа. Тийм болохоор энэ нүүрсний сонсголыг санаачилж хийсэн юм. Мөн энэ Хөгжлийн банкны сонсголыг бас санаачилж явсан юм, оролцсон юм. Цаашидаа ч гэсэн энэ дээр хав хатуу байх болно. Ингэснээрээ Ардын намын намтай харлуулж, нийлүүлж явдгийг бол тийм жижигхэн улс төрөө энэ парламент дээрээ ядаж болих эрхтэй шүү. Энэ бол ёстой бид тоохгүй. Гэхдээ энэ том улс орны эрх ашиг дээр бол бид нар нэгдэж ажилладаг юм гэдэг энэ соёлыг бол парламент дээр бий болгохын төлөө ажиллаж байгаа. Энэ дээрээ бол харин тууштай байх болно.

Харин үзэл баримтлалын хувьд би нэг тайлбар өгчихмөөр байгаа юм. 1 өдрийн дотор үзэл баримтлалаа өөрчиллөө гээд шоолоод байх шиг байна. Үгүй шүү дээ. Бид нар бүтэн 2 жил нам дотроо ярьж байгаад, олонхын саналаар шийдсэн байдаг юм. 3 жил ярьсан байдаг юм. 2016 онд бид нар үзэл баримтлалаа Дээд шүүх рүү оруулаад бүртгэж аваагүй юм Ганбат гишүүнээ. Тухайн үед Цахиагийн Элбэгдорж гэдэг хүн бүртгүүлээгүй юм. 3 удаа манай намын даргын бүртгэлийг хойшлуулсан байдаг юм. 2 тамга хийж өгсөн байдаг юм. ХҮН нам өнөөдрийг хүртэл сонгуульд орж чадаагүй шүү. ХҮН нам гэдэг нэрээрээ. Та маш тодорхой ойлголттой байгаад, ойлголтоо цэгцлээрэй. ХҮН нам эвслээр орсон байдаг юм. ХҮН намыг өдийг хүртэл оруулаагүй юм. Танай Цахиагийн Элбэгдорж оруулаагүй юм, Халтмаагийн Баттулга оруулаагүй юм. Хамгийн сүүлд 2020 оны орон нутгийн сонгуулиар бас оруулаагүй юм. Дандаа шүүхэд захиалга өгдөг. Бид нарын саналыг хуваадаг, нэг бол бид нартай хамтарч ор, үгүй бол та нар орохгүй л гэдэг. Аль, аль нь л ийм байдалтай ирсэн юм. 8 жил бид нар сонгуульдаа орж чадаагүй юм. Та нарын өнөөдрийн үүсээд байгаа зовлонг бид нар 5 жил өөр дээрээ авч явж байж харин

2021 оны сонгуулийн дараа бид нар ганцхан боломж гарч ирсэн. Тэр нь бол Дээд шүүхэд хандаж үзэл баримтлалаа өөрчлөх боломж гарч ирсний дагуу л явсан шүү дээ. 5 жилийн ажил юм шүү.

Өнөөдөр та нар маань ингээд өөрсдөө л их зовоод байгаа юм шиг байна лээ. Гэхдээ карма гэж байдаг юм шүү дээ. Өөрсдийн тэр өмнөх удирдлагуудад чинь хийсэн зүйл чинь та нар дээр өнөөдөр бий болж байгаа юм. Гэхдээ бид нар зовлон үзсэн хүмүүс болохоороо та нарыг дэмждэг юм. Та нар руу юу ч ярьдаггүй юм. Эмх цэгцдээ ороод, улс төрийн нам шиг, институт шиг байгаасай гэж хүсдэг юм. Тийм болохоор сошиал дээр ч гэсэн, өнөөдөр Улсын Их Хурлын танхим чуулган дээр ч гэсэн би та нарын эсрэг нэг ч үг хэлдэггүй, дандаа дэмжиж явсаар ирсэн шүү. Харин өнөөдрийг хүртэл ингээд ийм нэг хувь хүн рүү чиглэсэн байдлаар хандах юм бол би бас дуугүй сууж чадахгүй, хувь хүн рүү чиглэвэл болно. Харин тэнд явж байгаа итгэл сэтгэл, итгэл үнэмшилээрээ явж байгаа тэр мэргэжилтэн залуучууд руу явах юм бол тийм зүйл байхгүй. Хэлэх үгээ бол хэлнэ. Тэгэхээр ойлголтоо цэгцлээрэй.

Тэгээд улс төрийн нам хэзээ бэхжих вэ гэхээр энэ пропорциональ систем чинь үүсэж байж улс төрийн нам бэхэжнэ. Энэ танай намд маш чухал. Цогтгэрэл гишүүн ч гэсэн маш хэлж байна. Ийм болохоор энэ дээрээ харин та нар тууштай байгаад, АН юм бол Монголынхоо ардчиллын талд байгаарай. Монголын ардчилал өнөөдөр маш эмзэг байдалд бол байгаа. Энэ бол парламентын тогтолцооноос чинь сонгуулийн тогтолцооноос болоод байгаа юм. Олон намууд орж ирж байж энэ эрх ашиг чинь хангагдана. Энэ дээрээ харин та нар тууштай байгаарай. Баярлалаа. Дэмжинээ дэмжинэ.

Н.Энхболд: Гишүүд хууль санаачлагчаас асууж, хариулт авч, дараа нь үг хэлж дууслаа. Одоо санал хураана,

гишүүд анхааралтай байгаарай. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Санал хураана. Үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураана. Гишүүд анхаарч байгаарай. Дэмжье гэдэг санал хураалт. 14 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж 57.1 хувиар хэлэлцэх эсэхийг нь дэмжлээ. Дахиад нэг асуудал асуулт бий шүү, гишүүд байгаарай. Байгаа шүү, Цэцийн дүгнэлт байгаа шүү. Асуудлыг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аджьасүрэн гишүүн чуулганы нэгдсэн хуралд танилцуулчихъя.

18.00 цаг

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлт

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ. Энэ бол Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41.2 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг Цэцээр хэлэлцээд зөрчсөн байна гэсэн дүгнэлт гаргаж ирүүлсэн. Дэгийн дагуу энэ Цэцийн дүгнэлтийг ХЗБХ холбогдох бусад Байнгын хороо хэлэлцэх ёстой. Өнөөдөр ХЗБХ энэ асуудлыг хэлэлцсэн. Хэлэлцээд Цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэсэн шийдвэр гарсан байгаа.

Цэц дээр энэ асуудлыг хэлэлцэхэд Улсын Их Хурлаас манай гишүүн Ж.Сүхбаатар очиж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан. Одоо Цэцийн дүгнэлтийн талаарх товч танилцуулгыг Сүхбаатар гишүүн хийнэ. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Баярлалаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41.2 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хууль зөрчиж байгаа эсэх асуудлаар Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөр миний бие томилогдсон. Шалтгаан нь бол өмнө нь энэ хуулийн ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байсан учраас ингээд энэ итгэмжилсэн төлөөлөгч болсон байгаа.

Тэгээд энэ гол агуулга нь бол БЗД-ийн 8 дугаар хорооны оршин суугч иргэн Батмөнх Үндсэн хуулийн цэцэд хандаж мэдээлэл гаргасан байдаг. Тэр нь юу юм бэ гэхээр энэ хуулийн 41.2 дахь хэсэгт хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.3-д заасан тохиолдолд огцуулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасан нь Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна гэсэн Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн байна. Шүүхийн шийдвэрийг бол гарсан шийдвэрийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ гэж байдаг.

Тэгэхээр энэ асуудал дээр бол яагаад ийм зөрчсөн бэ гэдэг үндэслэлээ хэлэхдээ бол шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болчхоод байхад тухайн асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэхээр заасан нь шүүхийн шийдвэрийг хэрэгжихэд саад учирч байна. Тухайлбал хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад тухайн шүүхийн хүчин төгөлдөр шийдэх тогтоолыг хэлэлцэхээр оруулахад төлөөлөгчид нь бол Нэгжийн хуулийн 39.1.3-д заалтын дагуу хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт асууж хариулт авах санал, дүгнэлт гаргах, санал хураалгах эрхтэй байхаар заасан учраас энэ хүрээндээ дурын төлөөлөгч хэлэлцэх асуудлаас хойшлуулах санал гаргаад, үүний дагуу санал хураалт явуулаад олонхын саналаар хэдэн ч удаа хойшлуулж болохоор нөхцөл үүсчихсэн байна.

Тэгэхээр хэрэв иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээр тухайн төлөөлөгчдийг огцуулах асуудлыг хойшлуулсаар байвал шүүхийн шийдвэр хэрэгжих боломжгүй болж, шүүхийн шийдвэрийг давсан хүчин чадалтай шийдвэрийг хурлын төлөөлөгчид гаргах боломжтой байдлаар хуульчилсан нь Үндсэн хуулийг шууд зөрчиж, шүүх эрх мэдэл халдсан зохицуулалт болсон байна гэсэн ийм мэдээлэл гаргасан юм. Миний би тайлбараа өгөхдөө бол энэ бол хурлын Төлөөлөгчийн бүрэн эрхийг тухайн иргэдийн Хурал нь бол баталгаажуулдаг, тогтоол гаргадаг. Тэгээд энэ бол сонгуулиар иргэдийг төлөөлдөг ийм мандат эзэмшдэг хүн, бүрэн эрхийн хугацаа нь бол төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоол батлагдсанаар эхэлж, шинээр сонгогдсон төлөөлөгчийн бүрэн эрх эхэлснээр дуусгавар болдог. Тэгэхээр хурлын Төлөөлөгчийн бүрэн эрхийг ингэж баталгаажуулах нь бол орон нутгийн сонгуулийн дүнгээр энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу $\frac{3}{4}$ -аас доошгүй төлөөлөгч сонгогдож, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоол гаргасан бол тухайн хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцогдоно.

Тэгээд гол нь бол энэ шүүхийн гарч байгаа шийдвэр чинь бол хүнийг гэм буруутайд тооцож байгаа. Түүнээс биш яг тухайн төлөөлөгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь дуусгавар болгох тухай асуудлыг хэлэлцээд, шийдвэрлэж байгаа асуудал яг биш. Тийм учраас иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэгэнт гарсан шүүхийн гэм буруутай гээд гарсан шүүхийн шийдвэрийн дагуу хурлаар асуудлаа хэлэлцэж байгаа нь бол шүүх эрх мэдэлд халдаагүй, шүүхийн шийдвэрийг хянаж байгаа хэрэг биш. Харин хугацаанаас нь өмнө Нэгжийн хуульд угаасаа бид нарын зааж өгснөөр бол хугацаанаас дуусгавар болох үндэслэл дотор бол энэ бол шүүхийн шийдвэр гарчихсан бол хугацаанаас дуусгавар болох үндэслэл болно гээд заачихсан

учраас тухайн хурал нь бол энийгээ хэлэлцээд шийдвэр гаргана. Тэгж байж тэр хүний төлөөлөгчийн бүрэн эрхийг дуусгавар болгож байж, дараагийн тэр нөхөн сонгуулийн асуудал ч гэдэг юм уу, бусад асуудал тавигдана.

Түүнээс биш шууд л шүүхийн шийдвэр гарахаар автоматаар тэр хүний тухайн төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болоод байж болохгүй гэдэг энэ байдлаар бол Нэгжсийн хууль зохицуулагдсан гэдгийг бол ингэж тайлбарлаад явсан байж байгаа. Гэтэл харамсалтай нь бол Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргахдаа мэдээлэл гаргагчийн талд шийдэхдээ бол иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шүүхийн шийдвэрийг хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэхээр байна гээд ингээд заачихсан байж байгаа. Үгүй ээ энэ чинь бид нар ерөөсөө шүүхийн шийдвэрийг хянаж үзэж байгаа биш шүү дээ. Тэгэхээр яаж ойлгосон юм, энэ дээр бол шийдвэр нь гарахдаа бол шүүхийн эцсийн байна гэсэн шийдвэрийг бол зөрчсөн байна гээд ингээд явчхаж байгаа юм.

Гэтэл яг үнэндээ одоогийн Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар харсан ч гэсэн гишүүн бол ард түмнийг төлөөлдөг. Нэгжсийн юм дээр бол тойргийн иргэдийг төлөөлдөг, 2-уулаа сонгуульт мандаттай ард түмнийг юу иргэдийг төлөөлөх. Гэтэл гишүүдийг ч гэсэн Их Хурлын тухай хуулиар эргүүлэн татах асуудлыг ТББХ-ны санал, дүгнэлтийг үндэслээд нэгдсэн хуралдаанаар хэлэлцдэг. Хэдийгээр шүүхийн шийдвэр гарсан ч гэсэн. Тэгээд илээр санал хураагаад, тэгээд хуралдаанд оролцсон олонх гишүүний саналаар эргүүлэн татахыг дэмжсэн бол тогтоол батлагдсанд тооцдог. Гэтэл энэ жишээлбэл бид энийг хүлээгээд авчихвал энэ Их Хурлын гишүүдийн асуудал хөндөгдөнө.

Мөн бүүр Цэцийн тухай хууль дээр бол Цэцийн гишүүд бол өөрсдөө бид нараас илүү давуу хамгаалалт тогтоочихсон байгаа шүү дээ. Цэцийн

гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон байхад ч гэсэн Цэцийн гишүүнээр гишүүнээс нь эргүүлэн татах асуудлыг Цэцийн шийдвэр анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эргүүлэн татна гээд бүр 2 шаттай. Шүүхийн шийдвэр гарчхаад байсан ч гэсэн дахиад нөгөө Цэцийн шийдвэр нь юм уу, анх илгээсэн байгууллагын санал нь аль, аль нь гарч байгаад тэгээд Их Хурал нь эргүүлэн татна гэсэн бүр ингээд давхар хамгаалалт заачихсан. Гэтэл энэ шууд бас хөндөгдөнө.

Тэгэхээр бид нарын Нэгжсийн хуульд оруулсан энэ шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд бол огцуулах асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцээд шийдвэрлэнэ гэсэн энэ заалт яахаараа Үндсэн хууль зөрчдөг юм бэ гэдэг асуудал бол гарч ирээд байгаа юм. Тэгэхээр энэ ойлгомжгүй ийм асуудал ингээд гарчихсан. Зүгээр манай зарим гишүүд бол яах вэ хүлээж аваад, зүгээр бүр тодруулаад биччихье, агуулгаасаа ухрахгүйгээр, найруулгын чанартай өөрчилчихье гэж ярьсныг нь манай ХЗБХ-н дээр яригдсан, яригдахад бол гишүүд олонх нь бол дэмжээгүй. Үгүй ээ, Нэгжсийн хууль нь зөв юм. Энэ үзэл баримтлалаа дагах ёстой гэж. Тэгээд энүүгээр жишээлбэл ингээд явлаа гэж бодоход ч гэсэн ер нь нарийн яривал Үндсэн хуулийн цэцийн хууль дахь өөрсдийнх нь асуудал ч гэсэн хөндөгдөх л юм байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм асуудал байгаа учраас энийг хүлээж авахгүй байх нь зүйтэй юм. Цэц ч гэсэн дунд суудлын хуралдаанаар шийдсэн шүү дээ энийг чинь.

Тэгэхээр энэ бол ялгаагаа ойлгомоор байгаа юм. Шүүхийн шийдвэр бол гэм буруутайд нь ял өгөөд ингээд гардаг. Сонгуульт ийм төлөөлөгчийн бүрэн эрхийг цуцлах асуудал бол төлөөллийнх нь институтэд нь өөрт нь хадгалагддаг. Тэр байтугай ер нь би зүгээр онол номыг нь бас мэдэх хүний

хувьд хэлэхэд бол тэр байтугай шоронгоос ажлаа явуулах бололцоотой байх ёстой гэж үздэг юм шүү дээ. Энэ Үндсэн хууль эрх зүйн үүднээс. Төлөөлөгчийн мандат цуцлагдаагүй тохиолдолд шоронд орж болно. Тэгвэл тэр шоронгоосоо ажлаа хуралдаа оролцох боломжийг хангах тухай асуудал яригддаг. Америкт одоо Трампыг эрүүгийн ял тулгаад явж байгаад хэрэв шоронд орчихвол яах вэ гэхэд Үндсэн хуульд нь шоронд орчихвол нэр дэвшиж болохгүй гэсэн заалт байхгүй учраас тэр чинь Трамп Ерөнхийлөгч шоронгоос сонгогдох бололцоотой гэж хуульчид нь тайлбарлаж байгаа шүү дээ жишээлбэл.

Тэгээд энэ чинь шүүхийн шийдвэрийг шүүж байгаа биш, төлөөллийн мандатыг хамгаална, сонгогдох эрхийг хамгаална гэдэг 2 чинь өөрөө тусдаа асуудал байдаг. Энийг хольж хутгасан ийм асуудал бол энэ онол, арга зүйн хувьд бол би алдаатай ийм шийдвэр гарчхаад байгаа юм л гэж ингэж үзээд байгаа юм. Тийм, ийм байгаад байгаа, ийм тайлбарыг л хэлж байна, тийм.

Н.Энхболд: Болсон уу Сүхбаатар гишүүнээ? Сүхбаатар гишүүний тайлбартай холбогдуулаад асуух хүн байвал нэрээ өгье. Тогтохсүрэн гишүүнээр тасалъя. Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би зүгээр үг хэлчихье. Тэгэх дээр манай энэ Батмөнх гээд залуу байгаа. Ер нь бол 2014 оноос хойш байна уу даа Үндсэн хуулийн цэц дээр иргэдийн гаргасан гомдол, тэрэн дээр нь ялалт байгуулж чадахгүй манай Их Хурлаас очсон төлөөлөгч нар нэлээн унадаг байсан. Бараг 2 жил гаруй шахуу унаж байгаад, тэгээд би 16 оны сүүлээр байна уу даа тийм ээ, яг энэ Батмөнхийн гаргасан гомдол дээр очоод, бид нар хамт хоорондоо мэтгэлцээд, тэгээд яах вэ хамгийн 2 жилийн дараах хамгийн анхны Их Хурлын зөв гаргасан шийдвэр зөв болж

хувирсан л даа. Тэгэхээр яах вэ тэнд тэгэхэд оюутан байсан. Тэгээд ингээд. Одоо энэ 2 дахь хэд дэх өргөдлөө өгч байгаа юм. Энэ дээрээ бас ялсан байна. Тэгээд сайн хуульч болохыг бас тэгээд дээрээс нь бас энэ яг энэ ялангуяа энэ нэг тэр залуу сууж байна. Тэгэхээр сайн хуульч болохыг, дээрээс нь бас яг энэ улс төрийн өнцөгтэй ийм зүйлүүд дээр бас мэтгэлцээн гаргаад байгаа учраас чамд сайн улс төрч болохыг бас хүсэн ерөөе.

Тэгэхдээ яг энэ асуудал дээр ах нь арай өөр байр суурьтай байна. Яагаад гэвэл энэ бол хуульчдын хууль тогтоох байгууллага руугаа мярааж байгаа мяраалтыг анхан шатын тэр юу байдаг юм нөгөө орон нутгийн юу билээ иргэдийн хурлын Төлөөлөгч дээр Үндсэн хуулийн цэц гаргаж байгаа Цэцийн дүгнэлт гаргаж байгаад тэрнийхээ дараа хаашаа үсрэх гэж байна вэ гэхээр Их Хурал руу үсрэх гэж байна. Өөрөөр хэлбэл төрийн ерөөсөө л энэ Монгол төрийн дархлаа бол энэ парламентын засаглал, тэгээд дээрээс нь энэ Монгол төрийн бас нэг хэсэг болсон орон нутгийн өөрөө удирдах ёс руу, тэгээд тэр нь иргэдийн итгэл дээр сонгогддог тэр хүмүүс рүү орж байна гэдэг бол маш буруу зүйл юм.

Мэдээж асуудал гарвал тэр шүүхийн шийдвэр гараад янз янзын асуудал үүслээ гэхэд тэр татах тэр процесс нь шууд шүүхийн шийдвэрээр хэрэгжээд явчих юм бол энэ чинь ерөөсөө нөгөө нэг сонгогч та нар огт хэрэггүй, хуулийн байгууллага шүүх та нарын дээр байна гэсэнтэй яг агаар нэг байхгүй юу даа. Тийм учраас яг энэ гаргаж байгаа энэ таны гаргасан Батмөнхийн гаргасан энэ өргөдөл гомдол бол хамгийн их тэр нөгөө нэг энэ парламентын засаглалын дээр гаръя гэсэн, тэгээд нутгийн өөрийн удирдах ёсыг бас байхгүй болгох гэсэн тэр хүмүүс хамгийн их хүсээд байгаа тэр зүйл байхгүй юу даа.

Тийм учраас энэ удаа, дараа, дараа бас сайхан олон, олон энэ Ардын намын

бүтэлгүй зөндөө олон шийдвэрүүд гарч байгаа. Тэрэн дээр сайхан өргөдөл юу гомдол гаргаарай. Амжилт хүсье.

Н.Энхболд: Ер нь бол Үндсэн хуулийн гол шүүхийн шийдвэр эцсийнх байдаг. Бид нар энэ дээр зүгээр процедурын дэгийн тухай асуудал хөндөгдөж яриад, тэрнээсээ болж байгаа болохоос цаана нь мандатын тухай, мандатыг нь арилгахад яг ямар процедураар явах ёстой юм бэ гэдэг асуудал ярьж байгаа болохоос биш шүүхийн шийдвэрийг буцааж хүчингүй болгох тухай асуудал ерөөсөө яригдаагүй шүү гэдгийг зориуд анхааруулж хэлье. Сая Сүхбаатар гишүүн ч гэсэн үндэслэлүүдээ бол яг энэ саяын зүйлүүдээр тулгуурлаж ярьсан гэдгийг хэлчихье.

Байнгын хороо хурлаа явуулдаг дэгтэй. Пүрэвдорж гишүүнээ. Та дараа дараагийн удаа анхаараарай. Бид нар хуралдаанд ямар хүн оруулах вэ гэдгээ хуралдааныхаа дэгийн дагуу хэлэлцээд явдаг. Гишүүн болгон өөрсдийнхөө оруулж ирэх гэсэн хүнийг оруулж ирээд байвал.../үг тасрав/

Б.Пүрэвдорж: Би оруулж ирээгүй шүү.

Н.Энхболд: Тэгээд яагаад энэ хүн ороод ирчихсэн сууж байгаа юм. Үгүй ээ нэхэмжлэл гаргасан ч гэсэн. Тэгвэл бүлгийн ажлын алба бол хамаагүй. Бүлгийн ажлын алба бол хамаагүй. Би тэрийг нь мэдсэнгүй, ажлын албанд байдаг гэж тийм. Ер нь зүгээр би анхааруулчихъя тийм ээ. Хэдүүлээ цаашидаа бас дуртай хүн болгон нь чуулганы хуралд юу чуулган, Байнгын хорооны хуралдаанд оруулъя гэсэн хүнээ дагуулаад ороод ирж болохгүй. Бүлгийн ажлын албаны хүн байсныг нь мэдсэнгүй, уучлалт хүсье. Энийг бас та нар цаашидаа анхаараарай, дэгээрээ явцаана шүү. Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Тэгэхээр Сүхбаатар гишүүн түрүүн их тодорхой тайлбар өгсөн байна. Энэ Үндсэн хуулийн цэцэд Сүхбаатар гишүүний гаргасан тайлбарын 2 дугаар тайлбар дээр бол их тодорхой өгсөн байгаа юм. Энэ 41.3 гэдэг 41.1 гэдэг заалт бол 1.3 гэдэг заалт бол шүүхийн шийдвэр авчихсаны дараа шүүхийн шийдвэр гарсны дараа бүрэн эрхийнх нь огцуулах асуудлыг иргэдийн Хурал хэлэлцэж шийднэ гэдэг л ийм л асуудал байхгүй юу. Өнөөдөр Улсын Их Хурал дээр энэ зарчим явж байгаа. Үндсэн хуулийн цэцийн гишүүн ч гэсэн шийдвэр гарвал Цэцийнхээ асуудлыг Улсын Их Хурал заавал хэлэлцэнэ.

Нөгөө томилдог, шийдвэр гаргадаг, бүрэн эрх нь зөвшөөрдөг тэр мандат бол эцсийн эцэст иргэдийн Хуралд байгаа байхгүй юу. Эсвэл Улсын Их Хурал. Гэтэл бид шүүхийн шийдвэрийг ямар нэгэн хэлбэрээр хянах гэж юм уу, шүүхийн шийдвэрт оролцох тухай асуудал энэ огт биш юм байгаа юм. Тийм учраас би бол Сүхбаатар гишүүнтэй санал нэг, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг бол хүлээн авах боломжгүй гэж санал хэлж байгаа юм нэг дэх нь.

2 дахь нь яах вэ бид нар цаашидаа нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийн 41.3-ыг ер нь дэлгэрүүлж бодож авч үзэх ёстой асуудал юм байна. Энд огцуулагдах асуудлыг бид нар эргүүлэн татах гэдэг зүйлээр солиод, эргүүлэн татах гэдгээр солиод, тэгээд процессынх нь хувьд бол заавал шийддэг тэр хэлбэр рүү нь оруулж өгөх ёстой гэж ингэж дэлгэрүүлж оруулж өгөх ёстой гэж бодож байгаа юм. Улсын Их Хурал дээр бол энэ нь эргүүлэн татах гэдгээр орчихсон явж байгаа юм. Тийм. Тийм учраас би тийм хувилбараар цаашид бол бид нар шийдэх ёстой байх.

Харин бол энэ бүрэн эрхийг шийдэх асуудал бол ял юу, гэмт хэрэг үйлдсэн, үйлдээгүй асуудлаа бол Их Хурал юу шүүх

шийднэ. Шийдсэнийх нь дараа Их Хурал юу уучлаарай орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал заавал хэлэлцэж, шийдвэрээ гаргадаг ийм л хэлбэр түү явахгүй бол иргэдээсээ сонгогдчихдог, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа хэлэлцээд мандатаа авчихдаг, шүүх нөгөөдхийг нь байхгүй болгоод байж болохгүй байхгүй юу. Энэ агуулгаар нь хандах ёстой гэж ингээж бодож байна. Би бол санал хэлж байгаа юм. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Асуугаад санал хэлээд дуусчихлаа даа тийм ээ. Үг хэлэх хүн бий юу? Үг хэлэх хүн байхгүй байна. Энэ ийм шүү. Манай Байнгын хороо ингээд саналаа хураана. Тийм ээ. Ямар ч шийдвэр гарсан байсан бид нар энэ асуудлыг цаашид нь Байнгын хорооны зүгээс авч үзэх шаардлага гарах нь. Тэгээд саяын яг Тогтохсүрэн даргын хэлсэн шиг Үндсэн хуулиар бол шүүхийн шийдвэр аливаа асуудал эцсийн байх ёстой. Энүүнийг буцаадаг хүн байхгүй. Жишээ нь эрүүгийн хэрэг үйлдээд, тэр нь шүүхээр тогтоогдоод, ял ноогдоод шоронд ачигдсан хүнийг хойноос нь тийм юм байхгүй гээд аймгийн ч юм уу, сумын ч юм уу, Улсын Их Хурал ч юм уу шийдвэр гаргаад суллаад ирэх тухай асуудал байхгүй шүү дээ, тийм ээ.

Ганцхан процедурыг нь яаж зөв явуулах вэ гэдэг дээр, тэгээд тэр анх сонгогдож ирсэн байгууллага нь эрхийг нь баталгаажуулаад, албан ёсоор тэрийг нь байхгүй болгосны дараагийн сонгууль явуулдаг энэ зүйлүүдийг бас зөв дараалалтай, логиктой явуулахын тулд ийм заалт хуульд орсон юм байна гэдгийг бодолцоод хэдүүлээ энэ жишээ нь бол Их Хурлын хууль дээр ингээж байгаа байхгүй юу. Шүүхээр шийтгэгдээд ирсэн хүний асуудлыг ялагдчихсан хүний асуудлыг Их Хурал гишүүдээ гишүүд яриад олонхын саналаар дэмжсэн бол гэж байгаа юм. Ерөөсөө санал энэ тэр хурааж гэж болохгүй шүү дээ тийм ээ. Ер нь энэ бол Үндсэн хуулийн тэр үндсэн заалт шүүхийн шийдвэр эцсийн байдгаа байгаад л, яаж.

Тэр тусдаа асуудал. Өнөөдрийн манай хуулийн хүрээнд бол тэр боломжгүй байгаа асуудал.

Тийм учраас бид нар тийм, түрүүн Трампын асуудлыг Сүхбаатар гишүүн ярьсан. Яг тийм байгаа. Одоо нөгөөдүүл. Энэ бол жич асуудал. Тэгэхээр энэ нэг 3 одоо Их Хуралтай, Цэцтэй, орон нутгийн Удирдлагын тухай хуультай холбоотой энэ асуудлаа нэг эргээж харж, цэгцлэх ийм хэрэг гарна. Одоо санал хураана. Дэгээрээ бол Цэцийн дүгнэлтийн дагуу санал хураах ёстой. Ингээд зүйл зүйлээр нь хураах ёстой, заалт заалтаар нь. Яах вэ, би юмаа уншиж байя. Цэцийн дүгнэлтийг санал, дүгнэлт хэлэлцээд санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль тогтоолын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулна гэж заасан байгаа. Одоо санал хураалт явуулна. 2 саналаар санал хураана.

1 дүгээр санал. Энэ нөгөө Цэцийн дүгнэлтийг та бүхэнд тараачихсан байгаа, танилцсан байгаа гэж бодож байна. Тийм.

1 дүгээр санал. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 41 дүгээр зүйлийн 41.2 дахь дэх хэсэгт “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасны “... 41.1.3, ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Энэ томъёолол ингээж бичигдэж байгаа. Тэгээд яах юм бэ, Их Хурлын даргыг хүлээх юм уу, хүлээхгүй юм

уу? Тэгвэл Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрнө гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна. Гишүүдийг саналаа өгөхийг хүсье. Санал хураалт. Цэцийн дүгнэлтийг хүлээж авахгүй гэсэн дүн гарч байна. 100 хувийн саналаар.

Дахиад нэг санал байна, 2 дахь санал. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь хэсэгт, 41.2 дахь хэсэгт “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасны “... 41.1.3, ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүний 88.3 хувь нь зөвшөөрч байна. Өөрөөр хэлбэл Цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж үзлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Үндсэн хуулийн цэцийн 23 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. Нэгдсэн хуралдаанд Сүхбаатар гишүүн өөрөө танилцуулчих уу дахиад уу? Дахиад уу? Адъяасүрэн гишүүн танилцуулна.

18.21 цаг

Гишүүдээ сууж байгаарай.

Энд түр 1 асуудал байна. Үгүй ээ, тэгэхдээ бид нар яаралтай ярихгүй бол 1 асуудал байгаа юм. Шийдвэр гарахгүй, санал солилцоодохъё. Одоохон та жоохон хүлээж байгаарай. Энэ ийм асуудал үүсчхээд байгаа юм. Энэ ийм асуудал гараад байгаа юм. Одоо сонгууль болох гэж байна. Сонгуулийн автоматжуулсан

системийн тухай хуульд зааснаар энэ бичиг бичгийг уг нь та нарт тараачихсан байж байгаа. Тэгээд энэтэй танилцаад, нэг чиг гаргаж өгөөч гэсэн юм.

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудлуудыг ярьж дууслаа. Хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА